

**Төрийн Албан Хаагчдад Зориулсан МХХТ-ийн
Суурь Мэдлэгийн Академи**

МОДУЛЬ 2

**Хөгжлийн бодлого, Үйл явц, Засаглалд
зориулсан МХХТ**

Эмануэль С. Лалана

Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академийн модулиуд

Модуль 2: Хөгжлийн бодлого, Үйл явц, Засаглалд зориулсан МХХТ

Энэ номыг “Creative Commons Attribution 3.0 License” тусгай зөвшөөрлийн хүрээнд хэвлэсэн болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://creativecommons.org/licenses/by/3.0/> үзнэ үү.

Энэхүү номонд тусгагдсан санал бодол, тоо баримт ба тооцоолол нь зохиогчийн байр суурийг илэрхийлсэн бөгөөд эдгээрийг НҮБ-ын байр суурийг илэрхийлсэн буюу НҮБ-ээс зөвшөөрөгдсөн баримт бичиг гэж ойлгож болохгүй.

Үүнд багтсан танилцуулгууд болон тэдгээрийн зохион байгуулалт нь НҮБ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс ямар нэгэн улсын хууль ёсны статус, нутаг дэвсгэр, хот суурин болон газар нутаг, эрх баригчид, тэдгээрийн хил хязгаартай холбоотойгоор баримтлаж буй үзэл баримтлалын хүрээнд илэрхийлээгүй болно.

Компаниудын нэр, арилжааны бүтээгдэхүүнүүдийн нэрийг дурдсан нь НҮБ-ийн үзэл бодлын хүрээнд тусгагдаагүй болохыг анхаарна уу.

НҮБ-ын Хөгжлийн Төлөөх Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологийн Ази,
Номхон Далайн Бүсийн Сургалтын Төв

Хаяг: Bonbudong, 3rd floor Songdo Techno Park
7-50 Songdo-dong, Yeonsu-gu, Incheon City
Republic of Korea

Утас: +82 32 245 1700002
Факс: +82 32 245 7712
И-мэйл: info@unapcict.org
Веб сайтын хаяг: <http://www.unapcict.org>

Copyright©UN-APCICT 2009

ISBN: 978-89-955886-4-2 [94560]

Хэвлэлийн эхийг Scandinavian Publishing Co Ltd, Studio triangle компани бэлтгэж,
Бүгд Найрамдах Солонгос Улсад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

21 дүгээр зууныг даяаршиж буй дэлхий дээр амьдарч байгаа хүн төрөлхтөний хараат бус, бие даах чадварыг улам бүр нэмэгдүүлсэн гэж тооцдог. 21-р зуун нь шинэ технологийн үр өгөөжийг сая сая хүмүүст амсуулж, ард иргэдийн амьдралыг эрс сайжруулж, ядруурлыг бууруулж чадах мэдээлэл, мэдлэгийн хүртээмжийг өргөжүүлэх бололцоог нээсэн цаг хугацаа билээ. Гэхдээ хараат бус байдал нь дангаараа бус хүн бүрт нээлттэй байх тогтвортой хөгжлийн төлөөх үнэ цэнэ, зорилт, эв нэгдлийн хамт өсөн нэмэгдэх бололцоотой.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хувьд илүү давуу хөгжилтэй бүс нутаг болон хөгжиж байна. ОУЦХБ-ын тооцоолсноор тус бүс нутгийн телефон шугамын тоо хоёр тэрбумаас давж, хөдөлгөөнт холбооны хэрэглэгчийн тоо 1.4 тэрбумд хүрсэн үзүүлэлт гарчээ. 2008 оны хагас жилийн байдлаар дэлхийн нийт хөдөлгөөнт холбооны хэрэглэгчдийн дөрөвний нэг хувийг Хятад болон Энэтхэг улс эзэлсэн тооцоо гарсан. Дэлхийн интернэт хэрэглэгчийн 40 хувийг Ази, Номхон Далайн бүс хамрах бөгөөд интернэтийн өргөн зурвасын дэлхийн зах зээлийн 39 хувийг эзэлж байгаа нь хамгийн том зах зээл гэсэн үг юм.

Технологийн ололт, амжилтуудын үр дүнд тоон хуваагдал арилсан болов уу гэж таамаглахад хараахан арилж амжаагүй байгаа гэсэн хариулт гарч ирж байгаа нь харамсалтай. МНДДУ буюу Мэдээлэлжсэн Нийгмийн Дэлхийн Дээд Уулзалт /МНДДУ/ 2003 онд Женев хотноо зохион байгуулагдснаас хойшхи таван жилийн нөхцөл байдлыг авч үзэхэд тус бүс нутаг технологийн ололт амжилтаар тэргүүлж байсан хэдий ч хүн амын олонх нь ялангуяа ядуу иргэд харилцаа холбооны үндсэн үйлчилгээг авч чадаагүй хэвээр байна.

Тус бүсийн 25 орон буюу голцуу жижиг арлын хөгжиж байгаа орнууд болон далайд гарцгүй орнуудын 100 хүнд ноогдох интернэт хэрэглэгчийн тоо нь 10 хүрэхгүй, эдгээр хэрэглэгчид нь ихэвчлэн томоохон хотод амьдардаг хотын оршин суугчид байхад нөгөө талаас тус бүсийн хөгжингүй орнуудын 100 хүнд ноогдох интернэт хэрэглэгчийн тоо нь 80 гаруй байгаа тооцоо гарчээ. Өргөн зурвасын үйлчилгээний хэрэглээний ялгаа бүр их байна.

Тус бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангахад МХХТ-ийн чадавхийг ашиглаж, тоон хуваагдлыг арилгахын тулд хөгжиж байгаа орнуудын бодлого боловсруулагчид МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбар болон иргэдийн МХХТ-ийн чадварыг хөгжүүлэх түншлэлийг дэмжих, тэргүүлэх ач холбогдол бүхий ажил, арга хэмжээг тодорхойлж, бодлого хэрэгжүүлэх, хууль эрх зүй болон зохицуулалтын орчинг тодорхойлох, төсөв, санхүүг оновчтой хуваарилах шаардлагатай юм.

МНДДУ –ын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд “...хүн бүр мэдээлэлжсэн нийгэм болон мэдлэгт тулгуурласан эдийн засгийг ойлгох, оролцох, үр өгөөжийг хүртэхийн тулд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмших боломжтой байх ёстой...” гэж тусгасан. Уг төлөвлөгөөнд МХХТ-ийн мэргэжлийн боловсон хүчин, шинжээчдийг олноор нь төрүүлэх зорилгоор олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэхийг уриалсан байдаг.

Энэхүү уриалгын хүрээнд МХХТ-ийн АНДБ-ийн Сургалтын Төвөөс хөгжлийн зорилтод МХХТ-ийг ашиглах сургалтын хөтөлбөр боловсруулсан. Тус хөтөлбөр нь өөр хоорондоо уялдаа холбоотой 8 модулиас бүрдсэн бөгөөд бодлого боловсруулагчдад МХХТ-ийн санал, санаачилгыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг болох мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой юм.

Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь НҮБ-ын АНДБ-ийн Эдийн Засаг, Нийгмийн Коммисс-/АНДБЭЗНК/-ын бүсийн 5 байгууллагын нэг билээ. АНДБЭЗНК нь Ази, Номхон далайн бүсэд дүн шинжилгээ, норматив үйл ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаа болон мэдлэг хуваалцах замаар тогтвортой, тэгш хамарсан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой юм. НҮБ-ын бусад байгууллагууд, олон улсын байгууллагууд, үндэсний хэмжээний түншүүд, оролцогч талуудтай хамтран АНДБЭЗНК нь Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвөөр дамжуулан энэхүү сургалтын модулиудыг ашиглах, нутагшуулах, орчуулах, төрийн байгууллагуудын дээд болон дунд түвшний ажилтнуудад зориулсан бүсийн болон үндэсний хэмжээний семинаруудаар түгээх үйл явцыг хөхүүлэн дэмжиж, энэхүү үйл явцаар дамжуулан бий болсон чадавхи болон олж авсан мэдлэг нь хөгжлийн зорилтуудад нийцэхүйц МХХТ-ийн үр шим болон бодит үйл ажиллагааг бий болгох зорилготой байдаг юм.

Ноелиин Хэйзер

НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Орлогч Дарга бөгөөд
АНДБ-ийн Эдийн Засаг, Нийгмийн Коммиссын Гүйцэтгэх Нарийн Бичгийн Дарга

УДИРТГАЛ

Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академи хэмээх цуврал модулийг боловсруулах үйл ажиллагаа нь бидэнд ихээхэн урам зориг өгсөн, бидний нүдийг нээн өгсөн үйл ажиллагаа, томоохон аялал байлаа. Академи нь зөвхөн МХХТ-ийн чадавхийг бэхжүүлэх үйл явцад байгаа орхигдсон зүйлсэд бус мөн иргэдийн оролцоо, үйл явцыг өөриймшүүлэн эзэмших замаар сургалтын хөтөлбөр боловсруулах шинэ арга замыг бий болгох зорилготой билээ.

Академи нь Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн тэргүүлэх хөтөлбөр бөгөөд бүс нутаг дахь 20 гаруй улсыг хамруулан зохион байгуулсан эрэлт хэрэгцээний үнэлгээний үр дүн, төрийн байгууллагуудын ажилтнууд, олон улсын хөгжлийн нийгэмлэгийн гишүүд, эрдэмтэд болон судлаачидтай хийсэн зөвлөлдөх уулзалтуудын үр дүн; өнөөгийн хэрэглэж буй сургалтын материалын давуу болон сул талуудад хийгдсэн гүнзгийрүүлсэн судалгаа; Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн бүсийн болон дэд-бүсийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинаруудад оролцогчдын зүгээс модулийн агуулгын хоорондын хамаарал болон үр ашгийн талаар гаргасан саналууд; МХХТ-ийн салбарын олон тооны экспертүүдийн хийсэн судалгаа зэрэг дээр суурилан боловсруулагдсан билээ. Бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан Академийн сургалт/семинарууд нь төрөл бүрийн улс орноос төлөөлөн ирсэн оролцогчдын хооронд мэдлэг, туршлагаа хуваалцах үнэлж баршгүй боломжийг ханган өгсөн бол энэхүү арга хэмжээний хүрээнд Академийн төгсөгчид модулиудыг сайжруулах боломжийг мөн хангаж өгсөн юм.

Академиас гаргасан анхан шатны 8 модулийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэх нь бүсийн хэмжээнд өнөөгийн түншлэлийг бэхжүүлэх, МХХТ-ийн хөгжлийн асуудлаар бодлого боловсруулагч нарын чадавхийг бэхжүүлэх шинэ түншлэлийг бий болгох боломжийг бий болгож байна. Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь Үндэсний академиудад бүх бодлого гаргагч нарт хүрч ажиллах гол хандлагаа хэрэгжүүлэх зорилгоор 8 модулийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх хүсэл эрмэлзлэлтэй байгаа билээ. Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь төв болон орон нутгийн засаг захиргаатай нэгэн сүлжээнд ажиллаж буй бүс нутгийн болон үндэсний хэд хэдэн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж тэдгээр нь өөрсдийн хэрэгцээ болон тэргүүлэх чиглэлд нийцүүлэн Академийн модулиудыг ашиглах, нутагшуулах, орчуулах, түгээх чадавхийг нь бэхжүүлдэг юм. Цаашид ч өнөөгийн модулиудыг өргөжүүлэн гүнзгийрүүлэх болон шинээр боловсруулах төлөвлөгөөтэй байгаа юм.

Түүнчлэн Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь Академийн боловсруулан гаргаж буй агуулгыг нь бүс нутгийн хэмжээнд илүү өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх үйл явцыг баталгаажуулахын тулд олон суваг бүхий хандлагыг ашиглаж байна. Академийн агуулгыг бүс нутгийн болон үндэсний академиар дамжуулан нүүр тулсан байдлаар түгээн дэлгэрүүлэхээс гадна Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн Виртуал академийг байгуулан онлайн зайн сургалтыг бий болгон оролцогч нар сургалтын материалыг өөрийн боломжоор судлах бололцоог мөн хангаад байна. Виртуал академи нь бүх модулиуд, тэдгээрийн дагалдах материалууд болох танилцуулгууд, кейсүүдийг агуулж хялбархан нэвтрэн, ашиглах боломжийг хангасны зэрэгцээ татан авах, дахин ашиглах, өөрийн улсад нутагшуулах, нөхцөл байдалд нийцүүлэх боломжийг мөн хангадаг ба мөн виртуал лекцүүд, суралцах аргачлалууд, агуулга хөгжүүлэх аргачлалууд болон гэрчилгээжүүлэлт зэргийг мөн ханган өгсөн.

Анхан шатны цуврал 8 модуль, тэдгээрийг бүс нутгийн болон үндэсний Академийн сургалт/семинаруудаар түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа нь олон тооны хувьд хүмүүс, байгууллагуудын хичээл зүтгэл, оролцоогүйгээр амжилтад хүрэхгүй байсан юм. Энэхүү боломжийг ашиглан миний бие Академийн төгсөгчид, сургалт/семинаруудад оролцож байсан яамд, сургалтын байгууллагууд, бүс нутгийн болон үндэсний байгууллагуудад талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Эдгээр талууд нь модулиудын агуулгад ихээхэн үнэтэй хувь нэмрийг оруулаад зогсохгүй, хамгийн чухал нь өөрийн улс оронд энэхүү Академийн төлөөлөл болон, энэ талаар нөлөөлөл үзүүлэн өөр өөрийн оронд Академийн курсуудыг нутагшуулахад Ази, Номхон Далайн бүсийн хөгжлийн төлөөх мэдээлэл, харилцаа холбооны технологийн сургалтын төв болон үндэсний болон бүс нутгийн түншлэгч байгууллагуудын хооронд албан ёсны гэрээ байгуулах боломжийг нээн өгсөн билээ.

Түүнчлэн миний бие энэхүү гайхалтай, урам зориг өгсөн аялалд маань өөрийн хувь нэмрийг оруулсан олон тооны хүмүүсийн хүчин чармайлтад талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Тэдний тоонд Академийн төслийн зөвлөх Шахид Ахтар, Редактор Патрисиа Аринто, Хэвлэн нийтлэх менежер Кристин Апикул, бүх зохиогч нар болон Академийн ажилтнууд багтаж буй юм.

Улс орнууд нийгэм- эдийн засгийн хөгжил, Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх, түргэтгэхийн тулд МХХТ-ийн хүний нөөцийн хомсдлыг бууруулах, МХХТ-ийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад тотгорыг бууруулах, МХХТ-ийн хэрэглээг дэмжихэд нь Академи өөр тус дэмийг үзүүлж чадна гэдэгт би бат итгэлтэй байна.

Хьюн-Сук Рии

МХХТХ-ийн АНДБНСТ-ийн захирал
Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон Далайн Бүсийн Сургалтын Төв

ЦУВРАЛ МОДУЛИЙН ТУХАЙ

Өнөөдрийн “Мэдээллийн эрин” буюу мэдээлэлд хүрэх арга замыг хялбарчилж чадсан харилцаа холбооны технологийн шинэчлэл нь бидний аж амьдрал, ажил төрөл болон амралтын арга хэлбэрийг өөрчлөөд байгаа билээ. “Тоон эдийн засаг” буюу “мэдлэгийн эдийн засаг”, “харилцан хамаарал бүхий эдийн засаг” эсхүл “шинэ эдийн засаг” зэргээр нэрлэгдэж буй энэхүү эдийн засаг, улс орны хөгжил нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс илүүтэйгээр шинэ бүтээлч санааг зохион бүтээхэд шилжин өөрчлөгдөж буй өөрчлөлтөөр тодорхойлогдох болсон. Энэ нь эдийн засаг болон нийгмийн хөгжилд МХХТ-ийн гүйцэтгэж буй үүрэг өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Үүний үр дүнд дэлхийн улс орнууд, тэдгээрийн засгийн газар нь хөгжлийн зорилтуудыг хангахын тулд МХХТ-ийг ашиглах чиглэлээр түлхүү анхаарах болсон. Тэдгээр засгийн газруудын хувьд МХХТ-ийн үйлдвэрлэл эсхүл эдийн засгийн салбарыг зөвхөн хөгжүүлэхэд бус түүнчлэн эдийн засаг, улс төр болон нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахад МХХТ-ийн хэрэглээ чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь ажиглагдсан.

Гэхдээ МХХТ-ийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход засгийн газрууд зарим нэг хүндрэл бэрхшээлтэй тулгардгийн нэг нь бодлого боловсруулагч нар улс орны хөгжлийг хөдөлгөхөд чухал үүрэг гүйцэтгэж буй шинэ техник, технологийн талаар мэдлэг хомс байгаа явдал юм. Нэгэнт хэн нэгний ойлгохгүй байгаа асуудлыг нөгөө нэг нь зохицуулж чадахгүй учир олонх бодлого боловсруулагчид МХХТ-ийн бодлогыг тодорхойлж, боловсруулахаас жийрхэх явдал бишгүй тохиолдоно. Гэхдээ техник технологийн мэргэжлийн хүмүүс МХХТ-ийн бодлогыг тодорхойлох нь бас явцуу, учир нь тэдгээр мэргэжлийн хүмүүс өөрсдийн зохион бүтээсэн, хэрэглэгчдийн хэрэглэж буй технологийг бодлогын талаас нь тайлбарлаж, үр нөлөөг таниулж мэдэхгүй байх талтай.

Иймд доор нэрлэсэн албан хаагчид, ажилтнууд, мэргэжилтнүүдэд зориулан Төрийн удирдагч нарт МХХТ-ийн мэдлэгийг олгох Академийн цуврал модулийг НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ийн АНДБ-ийн сургалтын төвөөс боловсруулан толилуулж байна. Үүнд:

1. МХХТ-ийн бодлого боловсруулах асуудал эрхэлсэн үндэсний болон орон нутгийн хэмжээний бодлого боловсруулагч нар
2. МХХТ-д суурилсан хэрэглээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх асуудал эрхэлсэн засгийн газрын албан тушаалтнууд,
3. Төслийн удирдлага, зохион байгуулалтанд МХХТ-ийн хэрэгслүүдийг ашиглах зорилгоор ажиллаж буй төрийн байгууллагуудын менежерүүд.

Цуврал модуль нь хөгжлийн зорилтуудыг хангахад МХХТ-ийг ашиглахтай холбогдуулан бодлогын болон технологийн аль аль талаас нь авч үзэх шаардлагатай асуудлуудыг таниулах зорилготой. Гол нь МХХТ-ийн техникийн авлага боловсруулах бус харин орчин үеийн тоон технологийн хөгжил дэвшилд гүйцэтгэх үүрэг, үүнтэй уялдуулан авч хэрэгжүүлэх бодлогын асуудлуудын талаар ойлголт өгөх явдал юм. Цуврал модулиар хүргэх сэдвүүдийг дэлхийн олон улс оронд явуулсан сургалтуудын эрэлт хэрэгцээнд хийсэн шинжилгээ, судалгааны үндсэн дээр тодорхойлж боловсруулсан.

Эдгээр цуврал модулийг бие дааж судалж болохын зэрэгцээ сургалтын курс семинар эсхүл хөтөлбөр хэлбэрээр ашиглаж болно. Цуврал бүр өөр өөрийн гэсэн онцлог сэдвүүдээс бүрдэх боловч харилцан уялдаатай асуудлуудыг хөндсөн бөгөөд модуль тус бүрт байгаа сэдвүүдийг нөгөө модулиудтай уялдуулан ярилцах, ойлгуулах аргаар ашиглаж болно. Цуврал модулийн урт хугацааны зорилго нь нэг багц сэдэв болж гэрчилгээ авах бололцоог уншигч, судлагч нарт олгоно.

Модуль тус бүрийн эхэнд тухайн модулийн зорилго, үр дүн буюу уншиж судалсны дараа нөхцөл байдлыг үнэлж дүгнэх асуултуудыг тусгасан болно. Мөн модуль тус бүр нь тухайн сэдвийг гүнзгийрүүлэн ойлгох боломж олгох судалгаа, жишээ, дасгалуудаас бүрдсэн бүлгүүдэд хуваагдана. Дасгалыг дангаар бие дааж болон багаар хамтран ажиллан гүйцэтгэж болно. Тухайн яригдаж буй сэдвийн талаарх нарийн өгөгдөл, мэдээллүүдийг зураг болон хүснэгтээр харуулсан. Нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл авахад зориулан лавлах эх сурвалжууд болон интернэтийн хаягуудыг өгсөн болно.

Цуврал модулиудад тусгасан судалгаа, жишээнүүд нь өөр хоорондоо зөрчилтэй байж болох учир ХТМХХТ-ийг хэрэглэхэд олон талын асуудлууд гарч болзошгүй. Энэ нь улс орнууд МХХТ-ийн нөөц бололцоог хөгжлийн зорилтуудыг хангах хэрэгсэл болгон судалж буй энэ үед энэхүү шинээр үүсэн гарч буй мэдлэгийн салбарын үр өгөөж, нөгөө талаас тулгарч болох хүндрэл бэрхшээл юм.

Онлайн зайн сургалтын үед Академийн цуврал модулийг хэвлэмэл хэлбэрээр ашиглах ба Виртуал академи (AVA – <http://www.unapcict.org/academy>) нь сургагч багшийн хичээлийг дүрс бичлэгээр болон Power Point хэлбэрээр үзүүлж зохион байгуулна.

Үүний зэрэгцээ, Сургалтын төв (APCICT) нь МХХТ-ийн дадлага эзэмшигчид болон бодлого боловсруулагч нарын сургалт, туршлагыг бэхжүүлэх зорилгоор онлайн сургалтын цахим хуудас болох “e-Collaborative Hub for ICTD (e-Co Hub – <http://www.unapcict.org/ecohub>)” нээн ажиллуулж байна. Тус цахим хуудас нь хөгжлийн зорилтын төлөө МХХТ-ийг ашиглахад чиглэсэн төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжаар хангахын зэрэгцээ хамтран ажиллах, мэдлэг туршлага, солилцох чиглэлээр харилцан холбогдох боломж олгоно.

МОДУЛЬ 2

Засгийн газрууд зөвхөн МХХТ-ийн үйлдвэрлэл эсвэл эдийн засгийн зах зээлийг хөгжүүлэх төдийгүй эдийн засаг, нийгэм, мөн түүнчлэн улс төрийн өсөлт хөгжлийг бэхжүүлэхэд МХХТ-г ашиглах тал дээр эрчимтэйгээр төвлөрч байна. Ялангуяа Засгийн газрууд янз бүрийн салбарууд, түүн дотроо бодлого тодорхойлох, зохицуулалтын орчинг бүрдүүлэх, үндсэн дэд бүтцэд хандах, МХХТ-ийн суурь чадварын хөгжүүлэлтийг хурдасгах, зохистой контентыг хөгжүүлэх, ХМХХТ-г хэрэглэх, сүүлийн үеийн шийдэлд хүрэхийн тулд дэвшилттэй МХХТ-ийн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих тал дээр ХМХХТ-ийн бодлогыг хөгжүүлэхээр хүлээж байна. Энэ модуль ХМХХТ-ийг дэмжих үндэсний бодлого, стратеги, суурь бүтцийн онцлог шинжийн талаар чухал мэдээлэл өгөх зорилгоор ХМХХТ-ийн бодлого боловсруулах болон засаглал дээр үндэслэсэн болно. ХМХХТ-ийн бодлого, засаглалын асуудлуудыг хэлэлцэхээс гадна, Засгийн газрууд хэрхэн өөрсдийн хөгжил дэвшил, стандарт хэмжээ нь бусад улс орнуудтай харьцуулахад хэр зэрэг дэвшилттэй байна гэдгийг тооцоолох боломжийг харуулна.

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Тус модуль нь дараах зорилгуудыг агуулсан болно. Үүнд :

1. ХМХХТ-ийг ашиглахыг дэмжих үндэсний бодлого, стратеги, хууль эрх зүйн акт зэргийн төрөл бүрийн онцлог шинжүүдийн талаар онц чухал мэдээллээр хангах
2. ХМХХТ-ийг хөгжүүлж, хэрэгжүүлэхэд гарах асуудлуудыг хэлэлцэх
3. Засгийн газрууд ХМХХТ-ийн бодлого боловсруулах, стандарт хэмжээ тогтоох прогрессоо бусад улс орнуудтай хэрхэн харьцуулах аргыг тодорхойлох.

СУРГАЛТААС ГАРАХ ҮР ДҮН

Тус модулийг судалж, танилцсанаар дараах мэдлэг, дадлыг эзэмшинэ. Үүнд:

1. ХМХХТ-ийн бодлогын үйл явцыг тодорхойлох
2. Түлхүүр ХМХХТ-ийн бодлогуудыг шинжлэх
3. МХХТ-ийн засаглалын түлхүүр асуудлуудыг хэлэлцэх

АГУУЛГА

Өмнөх үг	3
Удиртгал	5
Цуврал модулийн тухай	7
МОДУЛЬ 2	9
Модулийн зорилго	9
Сургалтаас гарах үр дүн	9
Кэйс судалгааны жагсаалт	11
Нэмэлт мэдээллийн жагсаалт	11
Зургийн жагсаалт	11
Хүснэгтийн жагсаалт	11
Товчилсон үгсийн жагсаалт	12
1. МХХТ-ИЙН БОДЛОГЫГ БОЛОВСРУУЛАХНЬ.....	13
1.1.МХХТ-ийн хөгжлийн загвар	16
1.2.Технологи, хууль, зохицуулалтын шинэчлэл	24
1.3.МХХТ-ийн бодлогын хөгжилд олон төлөөллийн оролцогч талууд	31
2. ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ҮНДЭСНИЙ МХХТ-ийн БОДЛОГЫН ЭЛЕМЕНТҮҮД.....	37
2.1.МХХТ-ийн чадавхи бүрдүүлэх	38
2.2.МХХТ-ийн аж үйлдвэрлэлийг байгуулах нь	45
2.3.Цахим засаглал	56
3. МХХТ-ийн ЗАСАГЛАЛ.....	68
3.1.МХХТ-ийн засаглалын үндсэн бүтэц	69
3.2.МХХТ-ийн хөрөнгө оруулалтуудыг удирдан зохицуулах нь	76
ХАВСРАЛТ	83
Нэр томъёоны тайлбар	83
Сургагч багш нарт зориулсан зөвлөмж	87
Зохиогчийн тухай	90

КЭЙС СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ

1. Филиппиний цахилгаан холбооны салбарын шинэчлэл	15
2. Тоон технологи болон зохиогчийн эрх: Шинэ Зеланд улсын жишээ	26
3. Сингапурын мэдээллийн технологийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр	43
4. Хятад улс – Дэлхийн МХХТ-ийн үйлдвэрлэлийн төв	46
5. Энэтхэг – Глобал програм хангамжийн үйлдвэрлэлийн төв	49
6. БНСУ – Хагас дамжуулагчаас мултимедиа хүртэл	52
7. Ирландын тоон контентын аж үйлдвэрийн зах зээлийн стратегиуд	54
8. Малайзын нээлттэй эхийн програм хангамжийн мастер төлөвлөгөө	60
9. Бразил дахь хамтран ажиллах чадвараар нийтийн аюулгүй байдал	63

НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Нэмэлт мэдээлэл 1. Төр, Зах зээл, Иргэний нийгэм – Нэгдэл эсвэл Бутралт?	21
Нэмэлт мэдээлэл 2. ХМХХТ-ийн бодлого, стратегийг томъёолох алхмууд	23
Нэмэлт мэдээлэл 3. Цахилгаан холбооны тусгай зөвшөөрөл	28
Нэмэлт мэдээлэл 4. Олон төлөөллийн оролцогч талуудын түншлэлийн зарчмууд	34
Нэмэлт мэдээлэл 5. Цахим засаглын төслүүдээс гарсан сургамжууд	65
Нэмэлт мэдээлэл 6. Австралийн Бүх Засгийн газрын МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчмууд	77

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Английн e-Стратеги – Технологийг бэхжүүлэх нь: Хүүхдийн үйлчилгээ олон Сургалтын арга барилыг өөрчлөх	41
---	----

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Азийн МХХТ-ийн байгууллагуудын харьцуулсан матрикс	71
---	----

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ЗӨАУХ	Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо
БҮЯА	Бизнес Үйл Явцын Аутсорсинг
ХХМА	Харилцаа Холбооны болон Мултимедиа Акт
ДШХСО	Динамик Шуурхай Хандалтын Санах Ой
АНДБ	Ази Номхон Далайн Бүс
ЕХ	Европын Холбоо
ҮНЭПХ	Үнэгүй болон Нээлттэй Эхийн Програм Хангамж
ТБМАА	Төрийн Байгууллагын Мэдээллийн Ахлах Ажилтан
ЗГХҮАҮС	Засгийн газрын Харилцан Ажиллах Чадварын Үндсэн Бүтэц
ҮНБ	Үндэсний Нийт Бүтээгдэхүүн
ГПХҮ	Глобал Програм Хангамжийн Үйлдвэрлэл
МХХТ	Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи
ХМХХТ	Хөгжлийн төлөөх Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи
СМТХБ	Сингапурын Мэдээллийн Технологийн Хөгжлийн Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ИП	Интернэт Протокол
МТ	Мэдээллийн Технологи
ОУЦХБ	Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага
ТББ	Төрийн Бус Байгууллага
ҮМХХТХБ	Үндэсний Мэдээлэл Харилцаа Холбоо Технологийн Хөгжлийн Байгууллага, Камбожи
ҮМДБ	Үндэсний Мэдээллийн Дэд Бүтэц
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллага
НЭПХ	Нээлттэй Эхийн Програм Хангамж
ФАЗТУК	Филиппиний Алсын Зайн Телефон Утасны Компани
СШ	Судалгаа Шинжилгээ
ГТМСХҮ	Газар Тариалангийн Мэдлэгийн Системийн Хурдацтай Үнэлгээ
ТТ	Техникийн Туслалцаа
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
НӨТ	Нэмүү Өртгийн Татвар
ВКХ	Видео Касет Хураагуур
МНДДХУ	Мэдээллийн Нийгмийн Дэлхийн Дээд Хэмжээний Уулзалт

ТЭМДЭГЛЭГЭЭНҮҮД



Кейс судалгаа



Асуултууд



Дасгал



Өөрийгөө шалгах нь

1. ХМХТ-ИЙН БОДЛОГЫГ БОЛОВСРУУЛАХ НЬ

Энэхүү бүлгийн зорилго нь :

- МХХТ-ийн бодлого боловсруулахад төр, зах зээл, иргэний нийгмийн үүрэг ролийг тодорхойлох
- Шинэ МХХТ-ийн хөгжилд хуулийн болон зохицуулалтын шинэчлэлийн шаардлагуудыг авч үзэх
- МХХТ-ийн бодлогын хөгжилд оролцогч талуудын үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

ХМХТ-ыг хэрэглэх нь санаачлагатай олон нийтийн бодлогын түлхэцийг шаарддаг. Энэ нь дан ганц алсын харааг шаарддаггүй бөгөөд үүнд ямар нэгэн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгтэй болно. Мөн хөндлөнгийн оролцоогүй арга барил нь үүнийг хийж чадахгүй юм. Учир нь МХХТ бол маш үнэтэй бөгөөд үр дүнтэй хэрэглэж чадахгүй бол их хэмжээний нөөцийг үрэн таран хийх магадлалтай. МХХТ-ийн ирээдүй гэрэл гэгээтэй харин ямар нэгэн бүтэлгүйтлийн эрсдэл нь мөн л өндөр юм.

ХМХТ-ийн бодлогыг хэлэлцэхээс өмнө бид “бодлого” гэсэн ойлголтыг авч үзэх хэрэгтэй. Аливаа бодлого бол үйл ажиллагааны төлөвлөгөө гэж тодорхойлогддог. Үүнийг албан ёсоор томъёолохдоо “төрийн түшээ эсвэл бүлэг төрийн түшээдийн зорилгуудыг сонгох, эдгээр төрийн түшээдийн эрх мэдлийн хүрээнд, зарчмын дагуу тусгай нөхцөл байдалд эдгээр зорилгуудад хүрэхтэй холбоотойгоор хийсэн хоорондоо холбоотой шийдвэрүүдийн иж бүрдлийг” хэлнэ¹. Төрийн бодлого нь нийгмийн хангамж эсвэл сайн сайхантай холбоотой асуудлуудыг зохицуулах хариу үйл ажиллагаа байдаг. Энэ нь тухайн улсын хууль, зохицуулалтууд, шийдвэрүүд болон Засгийн газрын үйл ажиллагаанд хэсэгчлэн заагдсан байдаг².

Энд практик туршлагыг бодлого гэж тодорхойлох нь чухал юм. Бодлого байгаа гэдгийг баталж хэлэхэд албан ёсны тайлбар (зохицуулалтын хэлбэрээр) шаардлагагүй юм. Харин жишээ нь үнэтэй програм хангамжийг Засгийн газарт их хэмжээгээр хэрэглэх болон нээлтэй эхийн програм хангамжийг ашиглахад албан ёсны бодлого байхгүй байгаа нь үнэтэй програм хангамжийг хэрэглэхэд үнэн хэрэгтэй бодлого нь болж байгаа гэдгийг далд утгаар илэрхийлж байна.

Дүгнэж хэлэхэд төрийн бодлого бол баримт бичиг, тунхаглалд юу заагдсан, мөн Засгийн газраар ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэгдсэн гэдэг аль аль нь болж байгаа юм.

Төрийн бодлого нийгмийн сайн сайханд чиглэгддэг, харин тодорхой асуудлыг шийдэх хамгийн сайн шийдлийг үргэлж агуулаад байдаггүй. Төрийн бодлого боловсруулах нь зөвхөн асуудалд хамгийн сайн техникийн эсвэл шинжлэх ухааны талаас хандах бус, мөн хөрөнгө оруулагчдын хууль ёсны шаардлагыг хангах хамгийн сайн шийдлийг тодорхойлох юм. Учир нь хөрөнгө оруулагчид юу хамгийн сайн шийдлийг бүрэлдүүлж байгаа гэдгийг ялгаатай өнцгөөс хардаг тул сайн төрийн бодлого нь бүх оролцогч талуудад тохирох хамгийн тохиромжтой хэрэглэж болохуйц шийдлийг харуулах ёстой юм.

Бодлого хамгийн сайн боломжит техникийн шийдлийг агуулах шаардлагагүй өөр нэг шалтгаан нь шинээр боловсруулагдаж байгаа бодлого нь хуучин байсан бодлогын загварын хүрээнд бичигдсэн байдаг юм. Хуучин бодлого шинэ бодлогынхоо хязгаарлалт байдлаар үйлчилдэг. Жишээлбэл: Хуучин бодлогууд сохирхолын хүрээнд боловсруулагдсан нь одоогийн шаардлагад нийцэх шаардах эсвэл шинэ бодлого тэднийг үгүйсгэж чадахгүйд учир нь юм.

Филиппиний цахилгаан холбооны тохиолдолд МХХТ-ийн бодлогын хөгжлийн улс төрийн бодлогыг дүрсэлж байдаг.

1 William Jenkins. "Policy Analysis: A Political and Organizational Perspective," in Wikipedia, "Policy," Wikimedia Foundation, Inc., <http://en.wikipedia.org/wiki/Policy>.

2 Legislation or 'statutory law' is law that has been promulgated (or 'enacted') by a legislature or other governing body. The term may refer to a single law, or the collective body of enacted law, while 'statute' is also used to refer to a single law. (Wikipedia, "Legislation," Wikimedia Foundation, Inc., <http://en.wikipedia.org/wiki/Legislation>). Regulation is "a legal restriction promulgated by government administrative agencies through rulemaking supported by a threat of sanction or a fine." (Wikipedia, "Regulation," Wikimedia Foundation, Inc., <http://en.wikipedia.org/wiki/Regulation>).



Филиппинийн цахилгаан холбооны салбарын шинэчлэл

Филиппинийн цахилгаан холбооны зах зээлийн либералчлал нь шинэчлэлийн эвслээр эхэлсэн бөгөөд зах зээлийг нээлттэй болгох алхмуудын стратегийг боловсруулсан. Филиппинийн алсын хот хоорондын телефон утасны компани (PLTD) нь одоогийн хувийн салбарын монополи бөгөөд, одоогийн байгаа зөөлөн суудалд нь дайрах дайралтыг хүлээж авахгүй байгаа бөгөөд өөрийн зар сурталчилгааны ажлыг саармагжуулсан. Гэсэн хэдий ч Ерөнхийлөгч Рамос түүний монополийг үгүй хийх нь тодорхой болсон учир ФАЗТУК-ийн удирдлагууд зөвшилцлийн хэлэлцээрийг хүлээн авсан юм. Үүний дараа ардчилалын шинж орж Үндэсний цахилгаан холбооны комиссо-зохицуулагчаар, харин Зам тээвэр, Харилцаа Холбооны яам–бодлого боловсруулагч болж үлдсэн.

Филиппинийн энэхүү ардчилал нь Ерөнхийлөгчийн үүрэг идэвхи болон тусгай зорилго бүхий бүлэг шинэчлэгчдийн ажлын үр дүнд юм. Эдгээр шинэчлэгчид Малайзын кэйстэй харьцуулахад шууд ашиг хүртэгчид биш байсан юм. Нэгэнт бодлого тодорхой болсон тул, төрийн зүгээс зах зээлийг нээлттэй болгох шийдэмгий байдлаа зарласан. Бизнес эрхлэгчид ч цахилгаан холбооны зах зээлд шуналтай нь аргагүй орж ирсэн.

Малайз шиг биш, маш олон хүмүүс Филиппинийн шинэчлэлийн хөдөлгөөнд өөрийн хувт нэмрийг оруулсан байдаг. Малайзын кэйсийн хувьд, эрх мэдэл Ерөнхий сайдад төвлөрч, бодлогын өөрчлөлтийн хялбар байдал болон бодлогын шинэчлэлийн эхлэл нь харьцангуй амар болсон юм. Филиппинд, эрх мэдэл Засгийн газрын гурван тусдаа газарт сарниж, хүчирхэг эдийн засгийн элит төрийн хүнд сурталын сегментэд нөлөөлж, бодлогын шинэчлэл илүү төвөгтэй болж, бусад улсын Засгийн газруудаас илүү дарамт шахалт хэрэгтэй болсон төдийгүй голлох албан тушаалтнуудаа эргүүлэн татаж байсан.

Эх сурвалж: Abridged from Lorraine Carlos Salazar, Getting a Dial Tone: Telecommunications Liberalization in Malaysia and the Philippines (Singapore: Institute of Southeast Asian Studies, 2007).



Асуултууд

1. Филиппин болон Малайз улсуудаас танай орны цахилгаан холбооны чөлөөт байдлыг тогтоох хүчин чармайлт хэр ялгаатай вэ?
2. Дээрхи тохиолдол дээр үндэслэн, чөлөөт байдлыг дэмждэг хүчин зүйлүүдийн талаар ямар бодолтой байна вэ?
3. Цахилгаан холбооны чөлөөт байдлыг бий болгоход ямар төрлийн саад бэрхшээлийг та гаргаж ирж чадах вэ?

БНЭУ-ын Мандья, Коппал дүүргүүдэд Бүүмийн (Bhoomi project³) –ыг хэрэглэх нь түүхийн газар нутгийн захиргааны системээс шалтгаалаад нийгмийн нөхцөлд янз бүрийн ялгаатай байдлыг харуулсан. Бүр урьдчилан тооцоолоогүй үр дүнг авчирсан. Пакаш болон Дэ-ийн хэлсэнчлэн:

3 See Revenue Department, "Bhoomi," Karnataka State Government, <http://www.revdept-01.kar.nic.in/Bhoomi/Home.htm>.

Бид Мандяад төслийн дизайнрууд итгэж байсантай адилаар Бүүмийн төслийг (пүүсүүд албан ёсны сувгаар дамжуулан илүү зээлд хамрагдах, албан ёсны зээллэг нь пүүсүүдэд эерэг хөгжлийн нөлөөлөл үзүүлж байх) ашиглан таатай бүтцийн нөлөөллийг олж харсан, хэдийгээр Коппалд тухайн төсөл одоогийн байгаа янз бүрийн газрын шинэчлэлийн санаачлагууд нь газар бол->тариачинд⁴ гэсэн шаардлагыг тавьж байгаагын эсрэг газрын харилцааг хүчээр бий болгох байгаа ч.

Тэнд угтаах боломжгүй, төлөвлөөгүй сөрөг үр дүн гарсан. Гэхдээ энэ нь бодлогын хөгжлийн үе шатанд чухал бөгөөд, бодлого боловсруулагчид нөхцөл, мөн төлөвлөөгүй сөрөг үр дагаврыг багасгахын тулд хөндлөнгөөс оролцох явдлыг үнэн зөвөөр үнэлэх боломжийг олгоно.

1.1.МХХТ-ИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАР

1978 онд давамгайл хөгжлийн загвар төр-удирдлага гэдгээс зах зээл-удирдлагатай хөгжил болж шилжсэн⁵. Шинэ хөгжлийн стратеги- эхэндээ ДБ болон ОУВС зохион байгуулсны Вашингтоны тохиролцоо гэж нэрлэгдсэн бөгөөд энэ нь АНУ-ын Засгийн газрын эрх мэдлийн суудал байсан юм. Үүнийг “Засгийн газрын доод чанарын, төрийн зохицуулалтыг халах, хурдацтай ардчилал болон хувьчлал гэж цохон тэмдэглэсэн байдаг”⁶.

Энэ мэргэжлийн зах зээлийн хандлага нь мөн МХХТ-ийн хөгжлийн салбарт маш олон хүмүүсийн эрхэнд орсон⁷. Мэргэжлийн зах зээлийн МХХТ-ийн хөгжил нь МНДДХУ-ын Женевын тунхаглалд дараах байдлаар сийлэгдэн үлдсэн.

Бодлого нь бүх түвшинд тогтвортой байдал, урьдчилан харах байдал, шударга өрсөлдөөнд тохирсон хамгийн тохиромжтой орчинг үүсгэх нь МХХТ-ийн дэд бүтцийн хөгжилд хувийн хөрөнгө оруулалтыг татан оруулах зорилгоор боловсруулагдаж, хэрэгжүүлэгдсэн байх ёстой төдийгүй мөн түүнчлэн уламжлалт зах зээлийн нөхцөл байдал үүсэх боломжгүй хэсэгт тохирох универсал үйлчилгээний үүрэг хариуцлагыг нээж өгөх ёстой⁸.

Төрөөс зах зээлд шилжсэн энэхүү шилжилт МХХТ-ийн хөгжилд мэдээллийн дэд бүтцийн хөгжилд хамгийн чухал жор нь болсон бөгөөд ялангуяа цахилгаан холбооны салбарт илт ажиглагдсан юм. 1970 оны дунд үе хүртэл цахилгаан холбооны салбар Засгийн газрын үзүүлдэг үйлчилгээ л байсан (зарим тохиолдолд хувийн салбарын монополчлол). Харин өнөөдөр ийм байхаа больсон байна. Жишээ дурдаж хэлбэл: “Цахилгаан холбооны шинэчлэлийн хамгийн сайн практик туршлага”-д зориулсан глобал интернэтийн бодлогын санаачлагын ерөнхий зарчмууд нь :

4 Amit Prakash and Rahul De', "Enactment of Technology Structures in ICT4D Projects: A Study of Computerization of Land Records in India" (paper presented at the 11th Pacific-Asia Conference on Information Systems, Auckland, New Zealand, 3-6 July 2007), 11.

5 David Howell, The Edge of Now: New Questions for Democracy in the Networked Age (London: Pan Books, 2001), 59.

6 Joseph Stiglitz, Making Globalization Work (London: Penguin Books, 2006), 17.

7 The term 'ICT development' should be distinguished from 'ICT for development'. ICT development refers to development of ICT infrastructure and ICT-related industries.

8 See WSIS, "Declaration of Principles – Building the Information Society: A global challenge in the new Millennium," <http://www.itu.int/wsis/docs/geneva/official/dop.html>.

Засгийн газрууд харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч байх ёсгүй бөгөөд, харин энэ салбарыг хувийн хэвшлийнхэн авч явбал илүү үр бүтээлтэй байх юм. Харин Засгийн газрын үүрэг нь төлөвлөлт, бүтэц бий болгох, зохицуулах л юм. Хувийн хэвшил нь удирдлага, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, санхүүжилт зэргийг хариуцна. Хувийн хэвшлийнхэнд шилжүүлэн өгсөн үүрэг хариуцлага болон өрсөлдөөн нь ил тод зохицуулалтын (удирдлагын гэрээ, капиталын түрээс, концесси, өмч хөрөнгийн борлуулалт болон үйл ажиллагаа явуулах эрх) зарчмын дагуу л явагдах ёстой⁹.

Хэдийгээр универсал хандалтыг хангах зорилго нь Засгийн газрын үзүүлж байгаа үйлчилгээг зөвтгөн хүлээн авахаа больсон ч:

Универсал хандалтын зүтгэлийн амжилт нь хувьчлал болон өрсөлдөөний амжилттай байдлын их хэмжээний арга хэмжээнүүдээс хамаардаг. Хөдөөний хөрөнгө оруулалтанд хамгийн үр дүнтэй, ашигтай байдлын хүчин зүйлсүүд нь эрсдэл болон санхүүгийн хувьсагчаас илүүтэйгээр бодлогын хувьсагчтай хамааралтай байдаг¹⁰.

МХХТ-ийн хөгжлийн мэргэжлийн зах зээлийн шилжилт нь мөн практикт тусгалаа олсон байдаг. ОУЦХБ-ын мэдээгээр “2004 он үндсэн цахилгаан холбооны үйлчилгээнүүдийг өрсөлдөөнд оруулах боломжийг нээхэд хамгийн чухал үе болон тэмдэглэгддэг” энэ нь “үндсэн үйлчилгээнүүд дэлхий дахины улсуудад 54 хувийн өрсөлдөөнөөр олгогдсон” явдал байсан юм¹¹.

ЭЗХАБ-ын зохицуулалтын шинэчлэлийн хөтөлбөрийн дарга Scott H. Jacobs-ийн хэлснээр мэргэжлийн зах зээлийн шинэчлэлийн ихэнх үр ашиг нь:

- Бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг буулгах, ялангуяа цахилгаан, тээвэр, эрүүл мэнд мөн сонголт, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлснээр **хэрэглэгчид очих үр ашгийг нэмэгдүүлэх**
- Бүс нутгийн болон глобал зах зээлд **өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн тулд экспортын болон үйлдвэрлэгчийн салбарын зардлын бүтцийг бууруулах**
- Өсөлтийг хязгаарлаж буй **эдийн засгийн нийлүүлэгчийн талд уян хатан байдал болон шинэчлэлийг багасгах асуудлыг авч үзэх**
- Хүн амын өсөлт ихтэй байгаа газарт чухал шаардлагатай нийгмийн аюулгүй байдалд санхүүгийн хэрэгцээ шаардлагыг бууруулж **мөн шинэ ажлын байрны нөхцлийг бүрдүүлснээр ажил эрхлэлтийн хувийг нэмэгдүүлэхэд туслах.**¹²

Филиппин болон Сингапур улс бол хэрхэн мэргэжлийн зах зээлийн цахилгаан холбооны бодлого үр дүнтэй байсныг харуулсан жишээ улсууд юм. Филиппинд, 30 жилийн монополчлолоос илүүтэйгээр холбооны өрсөлдөөнт зах зээл бий болсон даруй 6-н жилийн дотор их хэмжээгээр телефон утасны шугамууд суурилуулагдсан байдаг.

9 Global Internet Policy Initiative, Best Practices for Telecommunications Reform (May 2002), 1, <http://www.apdip.net/documents/policy/regulations/gipi01052002a.pdf>.

10 Ibid., 2.

11 ITU, Trends in Telecommunication Reform 2004/05: Licensing in an era of convergence - Summary (Geneva: ITU, 2004), 3, http://www.itu.int/dms_pub/itu-d/opb/reg/D-REG-TTR.7-2004-SUM-PDF-E.pdf.

12 Scott H. Jacobs, “The Second Generation of Regulatory Reforms” (paper prepared for delivery at the IMF Conference on Second Generation Reform, Washington, D.C., USA, 8-9 November 1999), <http://www.imf.org/External/Pubs/FT/seminar/1999/reforms/jacobs.htm>.

Өнөөдөр Филиппин Ази тивд гар утасны өрсөлдөөнт зах зээлийн нэг нь болоод байна. Сингапурын хувьд холбооны хувьчлал нь илүү их хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжил, бусад салбарынханд эерэг хөшүүргийг авчирсан юм. Сингапурын хөгжлийн байгууллага нь “ихэнх хөрөнгө оруулалт шинэ үйл ажиллагаануудаас үүсэж байна, зах зээл бүхэлдээ хувьчлагдвал ирэх гурван жилд хөрөнгө оруулалт 1,8 тэрбум доллар болж, шинээр 2500 ажлын байр нэмэгдэнэ” гэсэн судалгааг гаргажээ¹³. Гэхдээ зах зээл удирдлагатай хандлагын шүүмжлэл нь шударга явдал, ажил эрхлэлт, өрсөлдөөн, шинэчлэлд хоцрохгүй байх, дараалан явуулах, эсвэл хэрхэн хувьчлал явагдаж байгаа асуудлуудад маш бага анхаарал тавьж байгаад юм¹⁴. Шинэ тохиролцоо – ‘Дараах Вашингтоны Тохиролцоо’ нь эдгээр асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор үүссэн. Kanishka Jayasuriya-ийн хэлснээр:

Хүчирхэг төрийг–хэдийгээр дахин бүтэцлэгдсэн- илүү зохицуулалтын чиглэлээр ардчилсан зах зээлд урьдчилсан нөхцлийн дагуу авч үзэх. Хүчирхэг өрсөлдөөний бодлого мэтийн тогтолцооны дутагдалтай байдал, төрийн зохицуулалтыг халах зэрэг нь магадгүй төрийн эрх мэдлийг хувийн хэвшлийн хүчирхэг олигархуудад шилжүүлэх үр дүнд хүрч болохыг тодорхой харуулж байгаа юм¹⁵.

Тиймээс бие даасан зохицуулагчийг бий болгох нь холбооны зах зээлийн ардчилсан байдлыг дагах ёстой гэдэг нь тодорхой болсон¹⁶. Бие даасан зохицуулагч нь давамгайлах операторын хийж буй өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаанаас хамгаалах зайлшгүй шаардлагатай ба мөн шинээр зах зээлд орж ирэх боломжийг нээж мэргэжлийн өрсөлдөөний арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явдал юм. Аргентины холбооны салбарын хувьчлалаас суралцсан жишээнүүд нь хүчирхэг бие даасан зохицуулагчийн чухлыг илтгэж байдаг:

Тогтвортой, итгэл үнэмшилтэй зохицуулалтын орчин энэ салбарын хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулдаг ба хувийн хөрөнгө оруулагчид оролцох шаардлагатай хүлээгдэж буй ашгийн хувийг бууруулдаг. Хувьчлалын өмнөх тогтвортой, итгэл үнэмшилтэй зохицуулалтын дэглэм нь худалдан авалттай хамааралтай эрсдлийг бууруулж боломжит худалдан авагчдад хувьчлагдсан цахилгаан холбооны үнэт зүйлийг өсгөдөг. Энэ нь эргээд Засгийн газрын худалдсанаар үүссэн үнэнд нөлөөлдөг. Энэхүү дэглэмийг урьдчилан тогтоох оролдлого бүтэлгүйтсэнээр Аргентиний Засгийн газар илүү доогуур борлуулалтын үнийг хүлээж аван худалдагчид гэнэтийн ашиг олж авах магадлалыг өсгөсөн¹⁷.

Энэ нь МХХТ-ийн хөгжилд төрийн үүрэг роль зах зээлийг бүх хүчин чадлаараа ажиллах боломжийг олгохгүй байгааг харуулж байгаа юм. Нобелийн шагналт эдийн засагч Joseph Stiglitz-ийн тэмдэглэн хэлснээр:

Зах зээл бол чухал; зах зээл нөөцүүдийг хуваарилахад туслаж, тэдгээр нөөцүүд байршуулагдахыг хангадаг нь ялангуяа нөөцийн хомсдолын үед бол хамгийн чухал юм. Гэхдээ үүнтэй адил чухал зүйл бол Засгийн газрыг хүчирхэгжүүлж, хөгжлийн шатандаа байгаа улс бүрийн хувьд Засгийн газар болон зах зээлийн ямархуу холимог харьцаа чухал болохыг тодорхойлох хэрэгтэй юм¹⁸.

13 See IDA, Singapore's Telecom Liberalization Draws ATT, MCI WorldCom and Other Global Players (Press Release, 3 April 2000), <http://www.ida.gov.sg/News%20and%20Events/20060926144739.aspx?getPagetype=20>.

14 Joseph Stiglitz, Making Globalization Work, 17.

15 Kanishka Jayasuriya, Governance, Post Washington Consensus and the New Anti Politics (Southeast Asia Research Center Working Papers Series No. 2, 2001), 3, http://www.cityu.edu.hk/searc/WP2_01_Jayasuriya.pdf.

16 See, for instance, Global Internet Policy Initiative, Best Practices for Telecommunications Reform.

17 Alice Hill and Manuel Angel Abdala, Regulation, Institutions, and Commitment : Privatization and Regulation in the Argentine Telecommunications Sector, Policy Research Working Paper Series 1216 (Washington, D.C.: The World Bank, 1993), http://www-wds.worldbank.org/servlet/WDSContentServer/WDSP/IB/1993/11/01/000009265_3961005141505/Rendered/PDF/multi_page.pdf.

18 Joseph Stiglitz, Making Globalization Work, 48.

Stiglitz төр болон зах зээлийг тэнцвэржүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэдэг. Гэхдээ энэ нь иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг ролийг батлах, ялангуяа төрийн бус байгууллагуудыг энд авч үзэх хэрэгтэй юм. Иргэний нийгмийн байгууллагууд нь өөрсдийн үүрэг ролийг хөгжилд ашиглах давтагдашгүй давуу талуудтай байдаг. АХБ-ны танилцуулснаар:

Төрийн бус байгууллагуудын тусгай давуу талууд нь нийгэмд нөлөөлөх гүүр нь болж, дотоодын шаардлагыг хангадаг. ТББ-ууд нь хөгжилд шинэлэг арга барил ашигладаг ба төслүүд урьдчилан тооцоологдсоноор хэрэгжих байдлыг хангах, төслийн ажлын тасралтгүй ажиллагааг дэмжих, ил тод байдал болон сайн засаглалыг дэмжих, эмзэг болон захын бүлгүүдэд үг хэл дамжуулахад тусалдаг¹⁹.

1987 оноос хойш, АХБ төрийн бус байгууллагуудтай сонгож авсан үйл ажиллагааны салбартаа хүчин чармайлтыг үр дүнтэйгээр нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна. АХБ “ТББ-ын чадавхи, туршлагыг тодорхойлсноор үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг сайжруулж чадна” гэснээрээ олонд танигдсан байдаг²⁰. 1998 онд АХБ ТББ-тай хамтарч ажиллах гурван өргөн хүрээний салбарыг тодорхойлсон. Үүнд: Зээл, техникийн тусламжийн үйл ажиллагааны хамтын ажиллагаа, хөтөлбөр боловсруулах болон улс орны түвшний ажил, бодлого боловсруулах зэрэг юм²¹.

Yvonne Asamoah-ийн үзэж буйгаар ТББ нь төрийн төсөв санхүү хязгаарлагдмал, улс төрийн байдал тогтворгүй, хүрээлэн буй орчны нөхцөл байдлаас шалтгаалж байгалийн гамшиг болох, угсаатны зөрчил газар авсан, нэг бүрийн капиталын орлогын түвшин нь нийгмийн, боловсролын, эдийн засгийн шаардлагатай бараа үйлчилгээг худалдан авах боломжийг хязгаарладаг нөхцөл байгаа газарт бол яах аргагүй чухал гэж тодорхойлсон²².

Хөгжилд ТББ-ын оролцоог Дараагийн Вашингтоны Тохиролцоонд дараах байдлаар тодорхойлдог:

Шинэ бодлогын загварын үг хэллэг нь... иргэний нийгэм, институтын байгуулалт, найдвартай байдлын цэвэр ашиг, ялангуяа засаглал, зэрэг нь уламжлалт Вашингтоны “нээлттэй зах зээл”, “төрийн зохицуулалтыг халах”, “чөлөөт байдал”, “бүтцийн тохиргоо” зэрэгт нэмэгдэж орсон²³.

Эдгээр бүх асуудлуудыг авч ХМХТ-ийн хүчийг бэхжүүлэхийн тулд ажиллаж байгаа бодлого боловсруулагч нарт хөгжлийн сорилт нь өөрсдийн улсын хөгжлийн стратегид төрийн, зах зээлийн, иргэний нийгмийн хооронд зөв тэнцвэртэй байдлыг бий болгох явдал юм. (Нэмэлт мэдээлэл 1-г хар).

19 ADB, ADB-Government-NGO Cooperation: A Framework for Action, 2003-2005 (May 2003), 2, http://www.adb.org/NGOs/Framework/final_framework.pdf.

20 Ibid.

21 Ibid., 3.

22 Yvonne Asamoah, NGOs, Social Development and Sustainability (12 September 2003), <http://www.foreignaid.com/thinktank/articles/NGOsAndSocialDevelopment.html>.

23 Kanishka Jayasuriya, Governance, Post Washington Consensus and the New Anti Politics, 3.

Нэмэлт мэдээлэл 1. Төр, Зах зээл, Иргэний нийгэм – Нэгдэл эсвэл Бутралт?

Доноруудын хувьд, иргэний нийгэм бол хүч болон ардчилалын найрлага мөн зах зээлийн эдийн засгийн байгалийн бүрэлдэхүүн хэсэг мөн. Донорууд иргэний нийгмийн бололцоог давтамжтайгаар шалгаж, төрийг хяналтандаа байлгаж, нийгэм цаашлаад ардчилалын үнэт зүйлд амин чухал судас болон үйлчилдэг. Төрийн эрх мэдлийг бууруулж, зах зээлийн үүргийг нэмэгдүүлснээр, иргэний нийгэм хөгжиж, энэ нь эргээд цаашдын эдийн засгийн чөлөөт байдлыг дэмждэг. Мөн иргэний нийгэм, төр, зах зээл тархай бутархай байдлаас илүүтэйгээр нэгдмэл байдал, зөрчилдөөнөөс илүүтэйгээр хамтын ажиллагаагаар тодорхойлогдож бүхэлдээ органик, харилцан үйлчлэлтэй бүхэл байдаг. Иргэний нийгэм төрийн болон зах зээлийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх, зах зээлд ёс суртахуунтай хяналт тавих, төрийн ардчилсан нэгдмэл байдлыг сахихтай адилаар оршдог гэсэн хүлээлт байдаг.

Төр, зах зээл, иргэний нийгмийн гурвал нь мөн л гурван элементүүд болох нарийн үйл ажиллагаа болон түүнд оролцогч, органик зохицолдлогоо, тэнцвэрийн хоорондын тодорхой хил хязгаарыг таамаглаж байдаг. Гэхдээ иргэний нийгмийн ихэнх байгууллагууд төрийн болон хувийн хэвшил аль альнаас нь тусламж хүлээн авч байна. Зарим улсуудад төрийн албан хаагч илүү үр бүтээлтэйгээр ажиллах, янз бүрийн нөөцүүдэд хандах, шинэ боломжуудыг олж авахын тулд өөрсдийн ТББ-ыг байгуулан ажиллаж байна. Үүнтэй адилаар зарим ТББ-ууд өөрсдийн жинхэнэ үйл ажиллагааны дагуу бус, харин татвараас зугтаах, хувийн ашиг сонирхлын зорилгоор ажиллаж байгаа юм. Цаашлаад, энэхүү гурвал нь тэнцүү–өө сэвгүй–гурван элементийн хүчний хувиарьлалтыг үзүүлж байна, мөн хүчний гурван тусгаарлагдсан байдлыг ч харуулж болох юм. Гэхдээ иргэний нийгмийн байгууллагууд хүчний тэнцвэрт байдалд таатай ханддаггүй. Жишээ нь: Бизнесийн холбоод үйлдвэрчний эвлэл эсвэл нийгмийн бүлгүүдээс илүүтэйгээр илүү сайн нөөцүүдтэй байх болон илүү хүчтэй улс төрийн хөшүүргийг авах магадлалтай байдаг. Зах зээлийн хүч ингэж уусан тархаж, иргэний нийгмийн зохиомжийг боловсруулдаг. Wood(1990) иргэний нийгмийн хийсвэр орон зайн хэсэгчилсэн болон янз бүрийн институудийн бүрдлийн харьцуулалт нь эдгээр ялгаатай институудыг үндсэнд нь холбож, утга төгөлдөр болгодог хөрөнгөтний нийгмийн логикийг нэгтгэн дүгнэхийг авч үздэг.

Хэдийгээр төр магадгүй гэргүй, хөгшин, өвчтэй хүмүүст тусламж, нийгмийн хангамж олгоход бэлэн байдаг ч, гол асуудал нь төрийн зардлыг бууруулах учир энэ нь тусламжийн бүлгийнхний хувьд шударга бус болж, Засгийн газрын бодлого эсвэл төрийн хууль зүйд эргэлзэх байгууллагуудын эсрэг кэйсүүдийг дэмжиж байна. Үүнтэй адилаар бизнесийнхэн нийгмийн хүмүүсийн хөгжлийг дэмжиж, харин хөдөлмөрийн болон хүрээлэн буй орчны стандартад хамгийн бага шаардлага тавьдаг хөдөлмөр зуучлалын байгууллагууд эсвэл хүрээлэн буй орчны бүлгүүдийн шаардлага, гомдлыг хүлээж авах тал дээр бага анхаарал хандуулна. Тиймээс төр, зах зээл, иргэний нийгмийн харилцан хамаарал нь зөрчлийн төлөөх зорилго, үнэ цэнэ, иргэний нийгмийн тэжээл, тогтвортой байдлыг батлах аль альныг нь дэмжихгүй байгаа шийдвэрүүдээр бүрэлдсэн байна. Эвсэл болон холбоод нь эрх мэдэл болон эд хөрөнгийг дахин хувиарьлахад үргэлжид итгэлтэй байж эсвэл түлхэц болж чадаагүй юм.

Эх сурвалж: Jude Howell and Jenny Pearce, in *New Roles and Relevance: Development NGOs and The Challenge of Change*, ed. David Lewis and Tina Wallace (Kumarian Press, 2000), 76-78. Quoted in Anup Shah, "Nongovernmental Organizations in Development Issues," <http://www.globalissues.org/TradeRelated/Poverty/NGOs.asp>.



Асуултууд

1. Танай улсад засаглалд иргэний нийгмийн үүрэг юу вэ?
2. Өөрийн улсын төр болон иргэний нийгмийн хоорондын харилцан хамаарлыг тодорхойлно уу?



Дасгал

Таны хольц юу вэ? Өөрийн улсын ХМХТ-ийн стратегид Засгийн газар, зах зээл, ТББ-ын хамгийн тохирсон/ирээдүйг харсан хольцийг болон одоогийн байгаа тоо хэмжээг тодорхойл.

Нэг улсаас ирсэн оролцогчдыг энэ дасгалыг багаар хийлгэх байдлаар сурга.

Амжилттай МХХТ-ийн бодлого болон стратегийн томъёолол нь хэд хэдэн алхмуудаас хамаардаг. (Нэмэлт мэдээлэл 2-г үзнэ үү).

Нэмэлт мэдээлэл 2. ХМХТ-ийн бодлого, стратегийг томъёолох алхмууд

1. Алсын баримлалаа зураглаж, МХХТ-ийн хөгжлийн богино/урт хугацааны хөтөлбөрийг боловсруулах. Энэ нь өгөгдсөн хугацааны хүрээнд хэмжигдэхүйц үр дүн эсвэл стандарт хэмжээг агуулах ёстой. Мөн энэ нь магадгүй зорилгыг биелүүлэхийн тулд холыг харсан дасгал ажлуудыг зохион байгуулахад чухал болох юм.

2. Зөвлөгөө, судалгаа, факт, тооцоолол, ойлголт, хэмжилт зэрэг дээр үндэслэн одоогийн нөхцөл байдлыг үнэл. (Энэ үйл ажиллагаа нь та хаана байгаа гэдэгт илүү тодорхой ойлголт өгөх бөгөөд таны хүрэхээр тэмүүлж буй зорилгын эцэст нь хүрэхэд шаардлагатай хүчин чармайлтыг танд тодорхой болгож өгнө)

2.1. Одоогийн байгаа бодлого, төлөвлөгөө, зохицуулалт болон санал болгосон бодлогууд, бодлогын чиглэлийг дахин нягтлан үзэх. Энд өөр ямар нэгэн МХХТ-той холбоотой асуудлууд байвал тэдгээрийг авч үзэх. Мэдээлэлд хандах, цахилгаан холбооны бодлого, зохицуулалтууд, радио, давтамжийн зохицуулалтууд, цахим худалдаа, цахим засгийн бодлого зэрэг нь үүнд хамаарна.

2.2. Бүс нутгийн нөхцөл байдлыг авч үзэх, түүн дотроо чөлөөт худалдааны гэрээ, хэлцэл нь бодлого томъёолоход нөлөөлж болох юм.

3. Зөвлөгөө явуулах, энэ нь нийгмийн тусгаар бүлгийнхэн болох эмэгтэйчүүд, ядуучууд, хөдөөний иргэд, залуучууд, тахир дутуу хүмүүсийг агуулсан байх. Мөн зөвлөгөөний цагийн хуваарь, аргачлал, агуулах хөрөнгө оруулагчдын төлөвлөгөөг бэлтгэх зайлшгүй шаардлагатай юм. Эдгээр нь төвлөрсөн бүлгийн хэлэлцүүлэг, ширээ тойрсон ярилцлага, онлайн зөвлөгөө болон солилцоо зэргийг агуулна. Зөвлөгөө нь байнгын байх ёстой.

4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний (бодит хэрэгжүүлэлтэнд зориулсан) төслийг гаргах. Энэ төлөвлөгөө нь санал болгосон төслүүдийн жагсаалт, төслийн үр дүн, амжилтын тодорхойлогч, хүлээж буй үр дүн болон тэдний нотолгоо, эрсдлийн үнэлгээ болон түүнийг бууруулах, зардал болон бусад нарийвчилсан нөөцийн шаардлагууд зэргийг агуулах ёстой. Төлөвлөгөө нь хэрэгжүүлэлтийн хуваарьтай байна. Энэ нь урьтамж тогтооход зориулсан янз бүрийн тайлбар хийхэд чухал юм.

5. Хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо тодорхойлох. Энэ байгууллага нь стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хийх үүрэгтэй байх ёстой. Ихэнх тохиолдолд, энэ агентлаг нь Засгийн газрын дээд түвшний шийдвэр гаргах байгууллагатай холбоотой байдаг. Энэ нь Засгийн газрын бүхий л дэмжлэг туслалцааг татан оруулах эрх мэдэлтэй байна.





6. Ажиглалт, үнэлгээний арга ажиллагааг оруулах. Энэ нь нээлттэй болон зөвлөх бүхий загвараар амжилтыг тодорхойлогч бүрэлдсэн, солилцсон, санал гаргасан байхад чухал ач холбогдолтой юм.

Эх сурвалж: Adapted from Richard Labelle, ICT Policy Formulation and e-Strategy Development: A Comprehensive Guidebook (Bangkok: UNDP-APDIP, 2005), <http://www.apdip.net/publications/ict4d/ict4dlabelle.pdf>.



Асуултууд

Аль алхам нь МХХТ-ийн бодлогыг томъёолоход бодлого боловсруулагчдад илүү сорилт болох вэ? Энэ талаар юу гэж бодож байна? Яагаад?

1.2. ТЕХНОЛОГИ, ХУУЛЬ, ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

Хууль эрх зүйн зохицуулалтууд нь технологи өөрчлөгдөхийн дагуу дагаж өөрчлөгддөг. Эдийн засаг, улс төр, нийгэмд МХХТ-г хэрэглэх хэрэглээ нь өсөхийн зэрэгцээгээр, үндэсний хуулиудыг дахин нягталж үзэх шаардлага гарч ирнэ. Шаардлагатай тохиолдолд зөвхөн технологийн өөрчлөлт, МХХТ-ийн оролцоотой хөгжлийг хорьж байгаа нэгийг нь хүчингүй болгох хэрэгтэй юм.

Хууль болон технологийн ойр дотны харилцан хамаарал нь гэрээний хуульд илэрхий харагддаг. Ихэнх улсуудад, гарын үсэг нь гэрээг хүчин төгөлдөр болгох хуулийн шаардлага нь болдог. Өнөөдөр, бараг бүх л хуулиуд цаас болон бэх ашигласан гарын үсгийг шаардаж байна. Бодит байдалд, гарын үсэг гэж юу вэ гэдгийг бид асуудал болгохгүй байгаа нь өөр технологи дээр суурилсан гарын үсгийн шинэ хэлбэрийн онцгой нөхцөл үүсэх хүртэл л юм. “Тоон гарын үсэг” нь функцийн хувьд гараар бичигдсэн гарын үсэгтэй адил юм. Хоёул гэрээнд хувь хүмүүсийн зөвшилцлын гарын үсгийг зурдаг. Гэхдээ тоон гарын үсэг нь ассиметрик криптографын төрөл бөгөөд ихэнх улсуудын хуулинд гэрээнд гарын үсэг зурахад хүлээн зөвшөөрөгдсөн болгож заагдаагүй байна. Асуудал нь гэрээ мөн адил тоон хэлбэрт байх ёстой юм. Тоон гарын үсгийг хуулийн талаас нь баталгаажуулах нь цахим худалдааг дэмжихэд чухал ач холбогдолтой юм. Тиймээс олон орнууд тоон болон гараар бичигдсэн гарын үсгийг ижил хүлээн зөвшөөрөх цахим худалдааны хуулиудыг баталсан байна.

Бизнесийн загвар мөн ямар нэгэн давамгайлах технологи дээр үндэслэгддэг. Номын худалдаа бол үүний нэг жишээ юм. Ном цаасан дээр хэвлэгдэж, мөн тэрхүү хэлбэрээрээ тараагдаж, худалдагддаг. Номын хамгийн их зардал нь хэвлэлийн зардал. Номыг тараах зардал нь мөн тэр ном цаасан дээр хэвлэгдсэн байдлаас шалтгаалдаг. (eBay-аас ном худалдаж авдаг хүмүүсийн хувьд заримдаа номын өөрийнх нь зардлаас илүү ихийг номыг имэйлдэхэд төлдөг). Ном цаасан дээр хэвлэгдээгүй, харин цахим хэлбэрээр тараагдсан бол юу болох бол? Хэн нэгэн интернэтээс татаж авсан цахим номондоо цаасан дээр хэвлэгдсэн номтойгоо адил хэмжээний төлбөр төлөх ёстой юу? Номын хэвлэгч интернэтээс татаж авсан номны үнэнээс хэвлэлтийн болон түгээлтийн зардлыг хасах ёстой юу? Хэрвээ номнууд интернэтээс татагдаж болох бол, номын дэлгүүрүүдийн хувьд юу болох вэ? гэх мэтчилэн.

Эдгээр бол зүгээр л хий хоосон бодлууд биш юм. Бодлого боловсруулагчид яагаад технологийн өөрчлөлт хувьсал хууль болон зохицуулалтын шинэтгэлийн орчинг гүйцэж түрүүлээд байгааг бодолцох хэрэгтэй юм. Ийм учраас хуучирсан дүрэм журам шинээр үүсэж буй зүйлсийг зохицуулахад хэрэглэгдэж байна. Энэ нь хуучин хууль шинэ болохоос сэргийлж байгаа хачирхалтай нөгөө талаар жигшмээр зүйл юм.

Хөгжмийг авч үзье. Сүүлийн жилүүдэд хөгжим бичлэг хэлбэрээр хадгалагдаж, бас л энэ хэлбэрээрээ худалдаалагдаж байна. Бичлэгүүд нь урт үргэлжилсэн Цомог эсвэл дан ганц дуу байдаг бөгөөд энэ нь винил хуванцарыг ашигладаг. Винил нь хамгийн тохирох хэрэгсэлд тооцогддог нь түүний уян хатан чанар болон эвдэршгүй байдалтай холбоотой юм. Харин бид хөгжмийг өөр бусад хэрэгсэл дээр хадгалж, түүнийг тоглуулах үед хөгжмийн зах зээлд юу болсон бэ? Бид хөгжмийг урт үргэлжилсэн Цомогийн хэлбэрээр худалдан авсаар л байх ёстой юу? Харин бид винил материалыг КД (CD-компакт диск)-ээр орлуулах үед үүний хариулт нь тийм болсон юм. Харин одоо ямар нэгэн хөгжмийг татаж аваад MP3 ашиглаад түүнийг тоглуулж чадаж байна. Хөгжмийг татаж авах нь шинэ асуултуудыг гаргаж ирж байгаа бөгөөд бас илүү боломжийг бидэнд олгож байна. Яагаад ямар нэгэн хөгжимчний цомгоос татаж авах гэж? Яагаад ямар нэгэн дууг татаж авч болохгүй гэж? Яагаад та өөрийн дуртай хөгжимчнөөсөө өөрийн дуртай дуунуудыг ялгаж авч татаад, яагаад тэднийг өөрийн цомог болгон хөрвүүлж болохгүй гэж? Энэ бол хуучны аргаар хөгжмийг зарах, худалдан авахын хувьд дуу бичлэгийн компаниудад шударга гэж үү? Засгийн газар одоогийн боломжтой байгаа аргаас өөрөөр хөгжмийг худалдан авах, зарах өөр боломжийг тогтоох ёстой юу?

Үнэндээ эдгээр асуултуудын хариултыг гаргаж ирэхэд хэцүү юм. Гэхдээ энэ нь бодлого боловсруулагчдад хувийн нууц болон оюуны өмчийн хамгаалалтын маргаан нь технологи болон хуулийн харилцан хамаарал гэдэг чухал асуудлуудыг ойлгоход чухал юм. Шинэ Зеланд улс бол өөрийн зохиогчийн эрхийн хуулиа дахин нягталж үзсэнээр энэ маргааныг шийдвэрлэсэн улсуудын нэг юм.



Тоон технологи болон зохиогчийн эрх: Шинэ Зеланд улсын жишээ

1

Технологийн өөрчлөлт, хөгжил, шинээр үүсэж буй технологиудыг ашиглах нь одоогийн байгаа хууль, зохицуулалтын хэрэглэх боломжтой байдал, яг таарах байдал, үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг гаргаж ирдэг. Энд ялангуяа зохиогчийн эрхийн тухай хууль нь технологийн өөрчлөлтөөс хамаарч байдаг. 1709 онд анх батлагдсан Английн Зохиогчийн эрхийн хуулиас харахад зохиогчийн эрхийн түүх нь технологийн өөрчлөлтөнд хариу барих хууль эрх зүйн орчны хөгжил шинэтгэлийг харуулж байдаг. Хэвлэлийн машин, дуу бичлэг тоглуулагч, төгөлдөр хуур, өргөн нэвтрүүлэг, зураг хуулагч, видео хураагуур, компьютер – зохиогчийн эрх нь шинэ технологийн хэрэгцээ шаардлагатай тохирон хөгжиж, зохиогчийн эрх нь зохиогчийн эрх үүсгэгч, эзэмшигчийн ашиг сонирхол, зохиогчийн эрхийн материал, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах байдлыг хангадаг юм. Худалдааны тоон технологийг их хэмжээгээр ашиглах нь мэдээллийн технологи, холбоо, үзүүлбэрийн зах зээл зохиогчийн эрхийн хуулинд өөр өөрийн өөрчлөлтийг бий болгож байна. Тоон технологи нь төвөггүйгээр зохиогчийн эрхийн ажлыг хуулах, хувиргах, тараах боломжийг олгож байгаа төдийгүй зардлын хувьд ижил технологи ашигласантай тэнцэж чадахгүй байгаа юм. Гол асуултууд нь одоогийн Зохиогчийн эрхийн хууль “тоон” гэсэн ямар нэгэн ишлэл агуулаагүй нь цахим болон онлайн орчинд ажлуудыг хийх чадамж болох бөгөөд Хууль нь зохиогчийн эрх үүсгэгч, эзэмшигч, хэрэглэгчийн шаардлагатай нийцэх өөрчлөлтийг оруулах ёстой юу гэдэгт юм. Зохиогчийн эрх үүсгэгч болон эзэмшигч нь интернэтээр тэдний өөрсдийн ажлуудыг тоон хэлбэрээр хуулах байдлыг хянах өөрсдийн чадамжиндаа үргэлж эргэлзэж байдаг. Зохиогчийн эрхийн хэрэглэгч нь зохиогчийн эрхийн материалд ухаалгаар хандах хандалтыг хязгаарлахад тоон технологийн үр дүнгийн талаар санаа зовниж байдаг.





2.

Зохиогчийн эрх нь санааны илэрхийлэл, оригинал ажлууд дахь мэдээлэлтэй холбоотой хуулийн дагуу олгогдсон эрхүүдийн бүрдэл юм. Зохиогчийн эрхийн хууль нь өрсөлдөхүйц ашиг сонирхлуудын хоорондын тэнцвэрийг цохихыг оролддог. Жишээ нь: үүсгэгчийн ашиг сонирхол болон зохиогчийн эрхийн материалын эзэмшигчийн хоорондын, нэг үгээр хэлбэл: бусад дээрхи иймэрхүү материалын хэрэглэгчийн ашиг сонирхол.

Зохиогчийн эрх үүсгэгч болон эзэмшигч нь өөрсдийн ажилдаа хамгаалалт хайж байдаг нь тэд өөрсдийн материалыг хэрэглэхэд буцааж ухаалаг хэмжээний мөнгө авах мөн түүнийгээ хянаж чаддаг юм. Зохиогчийн эрх нь зохиогчийн эрх үүсгэгч болон эзэмшигчдэд бүтээлч ажлуудын зах зээлийг зохицуулахад туслах тодорхой дүрмүүдийн ерөнхий бүтцээр хангахад тусладаг. Зохиогчийн эрх нь тиймээс дор дурдсан 2 замаар ажилладаг.

- Зохиогчийн эрхийн ажил, бүтээлийг боловсруулагчид болон эдгээр ажил, бүтээлийг боловсруулахад туслах хөрөнгө оруулагчид;
- Эдгээражил, бүтээлийг цааш нь хөгжүүлэх, нийгэмд тарааж, нийтлүүлэх зохиогчийн эрх эзэмшигч

Зохиогчийн эрхийн хууль нь зохиогчийн эрхийн бүтээл хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг таньж мэдэх ёстой. Энэ нь тусгай хэрэглэгчийн зохиогчийн эрхийн бүтээлийг хамгаалахыг хязгаарлахгүйгээр, олон нийт зохиогчийн эрхийн бүтээлд хандах боломжуудыг хангаснаар шийдэгдэх юм.

Хэдийгээр Шинэ Зеланд улс бага хүн амтай ч, ард иргэд янз бүрийн бүтээлч чадвар, авъяастай байдаг. Үр дүнтэй зохиогчийн эрхийн дэглэм нь эдийн засаг болон нийгмийн хөгжилд нэмэр болох бүтээлч бүтээгдэхүүний үнэ цэнийг таних хүчин зүйл нь болдог. Энэ нь дор дурдсан нөхцлүүдийг урамшуулснаар үндсэн хөдөлгөгч хөшүүрэг нь болж чаддаг. Үүнд:

- Дотоодын болон гадны хөрөнгө оруулагчдаар Шинэ Зеландын бүтээлч чадвар, авъяас билигт хөрөнгө оруулалт хийлгэх, түүнийг ашиглах,
- Зохиогчийн эрх дээр суурилсан зах зээлийг татан оролцуулснаар экспортын зах зээлийг хөгжүүлэх,
- Шинэ Зеландын соёл, үндэсний өв уламжлалд хувь нэмэр оруулах бүтээлийг үйлдвэрлэх.

Хэдийгээр олон авъяаслаг иргэд бүтээлч ажлуудыг хийж байгаа ч, бусад орнуудад зохиогчийн эрхийн хамгаалалт авсан маш олон бүтээлийг импортлон оруулж ирсээр байна. Үр дүнтэй зохиогчийн эрхийн эрх зүйн орчин нь мөн Шинэ Зеландын ард иргэд гадны зохиогчийн эрхийн бүтээлд хандах, ялангуяа зохиогчийн эрхийн бүтээлд байгаа мэдээлэлд хандахад юм. Тиймээс Шинэ Зеландын зохиогчийн эрхийн эрх зүйн орчин нь худалдааны түншүүд болон олон улсын гэрээгээр олгогдсоны дагуух хамгаалалтын түвшинг олгох байдал нь үргэлжилсээр байна.

Шинэ Зеландын зохиогчийн эрхийн зохицуулалтын ямар нэгэн шинэчлэл нь доорхи байдлаар чиглэгдсэн байх ёстой: дотоодын шинэчлэлийг дэмжих; Шинэ Зеландын ард түмэнд зохиогчийн эрхийн бүтээгдэхүүнүүдийг тараах; зохиогчийн эрх дээр суурилсан үйлдвэрлэлийн экспортын зах зээлийг дэмжих; олон улсын гэрээг дагах, одоогийн байгаа болон боломжит дотоодын хууль эрх зүйн орчныг шинэчлэн тодорхойлох.

Эх сурвалж: Abridged from New Zealand Ministry of Economic Development, Digital Technology and the Copyright Act 1994: A Discussion Paper (2001), http://www.med.govt.nz/templates/MultipageDocumentTOC___991.aspx.



Асуултууд

1. Зохиогчийн эрхийн хуультай байх нь зайлшгүй шаардлагатай юу? Яагаад эсвэл яагаад үгүй гэж?
2. Шинэ Зеланд улсаас танай улсын зохиогчийн эрхийн бодлого юугаараа ялгаатай байна вэ?

Энд ганцхан хууль өөрчлөгдөх нь хангалттай биш юм. Хууль эрх зүйн зохицуулалтууд нь тоон технологитой уялдан мөн өөрчлөгдөх ёстой²⁴.

Уламжлалт ярианы утсан харилцаа, хангамж, үйлчилгээ, хэрэгслүүд нь техникийн бүтэц, зохиомжийн хувьд нэгдмэл байсан. Тиймээс зөвхөн нэг компанийн хувьд үйлчилгээ (жишээ нь: яриа) болон холбогдох сүлжээний үйлчилгээг хамтад нь хүргэдэг байсан гэж ойлгож болно. Жишээлбэл: Филиппинийн PLDT нь өрсөлдөөний өмнөх жилүүдэд сүлжээ, яриа, өгөгдлийн үйлчилгээг хэрэглэгчдэд олгох эрхтэй ганцхан компани байсан. Энэ бол телевизийн өргөн нэвтрүүлгийн бас нэг жишээ юм. Жишээлбэл: Телевизийн компани тухайн компанийн бүтээсэн эсвэл худалдан авсан хөтөлбөрүүдийг хүргэх сүлжээг удирддаг.

Интернэтийн технологиуд, ялангуяа интернэт протокол нь сүлжээний төхөөрөмжүүд болон үйлчилгээг тус тусад нь хүргэх салгалтыг хийж чаддаг. Сүлжээний төхөөрөмжүүд нь эдгээр төхөөрөмжүүдээр дамжих үйлчилгээтэй хамтдаа байхаа больсон. Технологийн энэхүү өөрчлөлт нь Засгийн газарт сүлжээний төхөөрөмжүүд болон үйлчилгээний энэ салгалтыг таньж мэдэх зохицуулалтыг томъёолох боломжийг олгосон юм. Жишээ нь: сүлжээний үйлчилгээ эрхлэгчидийн тусгай зөвшөөрөл нь үйлчилгээ эрхлэгчдэд олгосон тусгай зөвшөөрлөөс ялгаатай бөгөөд салангид тусгай зөвшөөрөл олгогдсон байдаг. Сүлжээний бизнест байгаа компани зөвхөн сүлжээний нэг цэгээс өөр цэглүү өгөгдлийг (энэ тохиолдолд өгөгдөл нь яриа, хөгжим, мултимедиа зэргийг агуулна) дамжуулж өгснөөр л түүнээсээ ашиг олох боломжтой юм. Ярианы утас, хөгжим татаж авах, видео болон тоглоом татаж авах зэрэг үйлчилгээ үзүүлдэг бусад компаниуд байна. Эдгээр үйлчилгээ үзүүлэгчид нь сүлжээг эзэмших шаардлагагүй харин тэд сүлжээний үйлчилгээг олгох зорилготой байгуулагдсан компанийн сүлжээг ашиглаж болох юм.

Өөр нэг хууль, зохицуулалтанд нөлөөлж байгаа техникийн өөрчлөлт бол нэгдэн нийлэлт юм. Өргөн утгаараа нэгдэн нийлэлт нь “харилцаа холбооны салбар дахь үйлдвэрлэл эсвэл үйлчилгээний ялгаа заагийг арилгах”²⁵ гэж ойлгогддог. ЭЗХАХБ-ын томъёолсноор нэгдэн нийлэлт нь техникийн, функцийн, болон корпорацийн гэсэн гурван үзүүлэлттэй. Техникийн нэгдэн нийлэлт нь дамжуулалтын дан ганц дэд бүтцээр (зэс утсан болон шилэн кабель) нэгэн зэрэг янз бүрийн мэдээллийг(яриа, текст, өгөгдөл, дуу, зураг) дамжуулж байна²⁶. Та интернэт, телевиз, телефон утсыг гэртээ тус тусын кабелиар оруулж ирдэг байсан бол, технологийн нэгдлийн хүрээнд эдгээр үйлчилгээг (дээр нь нэмж хэлэхэд видео) гэртээ хэрэглэхийн тулд зөвхөн нэг кабель ашиглахад болно. Гэхдээ энэ бол зөвхөн техникийн боломж бөгөөд ихэнх тохиолдолд зохицуулалтын орчин тэр бүр тухайн боломжийг олгохгүй байх тал бий.

Тусгай зөвшөөрөл олгох нь нэгдмэл байдал бий болгох боломжийг олгож болно. Тиймээс л ОУЦХК Засгийн газруудыг нэгдмэл байдлыг дэмжих тусгай зөвшөөрлийн орчинг бий болгохыг уриалж байгаа юм.

24 Regulation is defined as “rule or order issued by an agency of the executive branch of government which has the force of law. Regulations must be authorized by the statute and generally provide more details on a particular subject than does the authorizing statute.” (Law Library, “A Glossary of Terms for First Year Law Students,” George Mason University School of Law, <http://www.law.gmu.edu/libtech/glossary>).

25 Robert E. Babe, Convergence and the New Technologies, <http://www.ucalgary.ca/~rseiler/babe.htm>.

26 Ibid.

Нэмэлт мэдээлэл 3. Цахилгаан холбооны тусгай зөвшөөрөл

1980-1990 онуудын цахилгаан холбооны салбарын шинэчлэлийн үеэр, ихэнх орнууд эхэндээ зах зээлд нэвтрэхийг хянах, зохицуулалтын үүрэг хариуцлагыг ноогдуулах хөшүүрэг болгож тусгай зөвшөөрлийг ашиглаж байсан. Зах зээлийн либералчлалын эхний үе шатны дараа ч, зарим улсуудад тусгай зөвшөөрөл нь зах зээлд нэвтрэхийг хянах гарц байдлаар ашиглагдсаар байна. Гэхдээ энэхүү нэгдмэл байдлын шинэ эрин үед, олон тооны бодлого боловсруулагчид тусгай зөвшөөрлийн ашиглагдах байдал болон зах зээлийн хөгжил болон технологийн хувьслыг бууруулалгүйгээр бодлогын зорилгуудад хүрэхийн тулд эдгээр тусгай зөвшөөрлүүд тохирсон байх асуудлуудыг гаргаж ирсэн. Эдгээр асуудлууд нь хоёр үндсэн чухал чиг хандлагад шилжсэн: тусгай зөвшөөрөлгүй үйлчилгээнүүдийн тоог өргөтгөх, уламжлалт үйлчилгээ ба технологид суурилсан тусгай зөвшөөрлүүдийг татан буулгах нэгдмэл тусгай зөвшөөрлийн орчинг хөгжүүлэх.

Нэг тусгай зөвшөөрлөөс ерөнхий зөвшөөрөл лүү шилжих

Өнөөдөр маш олон улсад, ихэнх үйлчилгээнүүдийн тусгай зөвшөөрлийн шаардлагууд нь зах зээлд нэвтрэх байдал, өрсөлдөөнийг дэмжихэд саад болж буй байдлыг арилгах зорилгоор хялбарчлагдсан байдаг. Нэг төрлийн тусгай зөвшөөрөл олгохыг шаардах, урт хугацааны дүрэм, журмын оронд ерөнхий зөвшөөрлийг ихэнх үйлчилгээнүүдэд хэрэглэх нь ихэссэн байна. Энэхүү чиг хандлагын хамгийн анхны жишээ нь Европын холбооны гишүүн улсуудад байсан бөгөөд бүх электрон холбоонд дан ганц тусгай зөвшөөрлийн ангиллыг үүсгэсэн явдал юм.

Үйлчилгээгээр төрөлжсөн тусгай зөвшөөрлөөс ерөнхий тусгай зөвшөөрөл рүү

Малайз улсын Харилцаа холбоо болон Мультимэдиагийн тухай хууль нь 1999 онд батлагдсан бөгөөд нэгдмэл байдлыг тусгасан, түүнийг дэмжих зорилго бүхий зохицуулалтын ерөнхий орчинг үүсгэсэн юм. Ялангуяа тус хууль нь технологи, үйлчилгээний төвийг баримталсан дэглэмийг цахилгаан холбоо болон өргөн нэвтрүүлэгт зориулж гаргасан бөгөөд тухайн улсын 31 төрлийн үйлчилгээгээр төрөлжсөн тусгай зөвшөөрлийг 4-н үндсэн ангиллын ерөнхий тусгай зөвшөөрлөөр зохицуулах болсон.

Нэгдмэл тусгай зөвшөөрлийн орчин

Цаашлаад зарим улсууд нэгдмэл тусгай зөвшөөрлийн загварыг нэвтрүүлэх арга хэмжээг авч эхэлсэн. Нэгдмэл тусгай зөвшөөрлийн зохицуулалтын орчинд чиглэсэн Энэтхэгийн хөдөлгөөн нь энэхүү чиг хандлагын тухай зарим ойлголтыг өгдөг. 2004 оны 4-н сарын зөвлөгөөны илтгэлд, Энэтхэгийн Харилцаа Холбооны Зохицуулах Газар зарим нэгдсэн тусгай зөвшөөрлийн загварыг санал болгосон.

Технологи болон үйлчилгээний төвч байр суурь баримтлах

Нэгдмэл тусгай зөвшөөрлийн бүтцэд шилжих үндсэн зорилгуудын нэг нь технологийн төвийг сахисан байдлыг хангах юм. Энэ үг хэллэг тусгай зөвшөөрөл авагч нь өөрийн тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдах технологи болон тоног төхөөрөмжийг сонгох боломжийг тусгай зөвшөөрөл авагчдад үлдээх гэсэн санааг илэрхийлж байгаа юм. Жишээлбэл: Хэрвээ оператор ямар технологи эсвэл архитектур нь үйлчилгээг хүргэхэд эдийн засгийн хувьд хамгийн тохиромжтой гэдгийг сонгох боломжтой бол утасны үйлчилгээнд татаас төлж байгаа хөдөөгийн олон талын хандалтын төсөл нь технологийн хувьд төвийг сахисан гэж үзнэ.

Технологийн төвийг сахисан байдалд туршлагажихад дээр нь, засгийн газар үйлчилгээний төвийг сахисан тусгай зөвшөөрөлд шилжиж байна. Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийг ямар үйлчилгээ хамгийн хэрэгцээтэй, зардалд хэмнэлттэй гэдгийг мэдэх зах зээлийн дохиог авахад туслана. Ерөнхий тусгай зөвшөөрөл нь зах зээлийн шаардлагад нийцүүлэн янз бүрийн үйлчилгээ болон хэрэглүүрийг операторууд санал болгох бүрэн эрхийг олгоно. Технологи болон үйлчилгээний төвийг сахисан байдлыг нэгтгэж байгаа нэгдмэл тусгай зөвшөөрлийн бүтэц нь ямар нэгэн оператор өөрийн сонгосон технологийг ашиглан хүргэж буй өөрийн үйлчилгээ болон хэрэглүүрийн хамрах хүрээг нэмэгдүүлнэ. Ихэнх орнууд ялангуяа Австрали, Европын холбооны гишүүн улсууд, Малайз нэгдмэл тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг баталсан.



Асуулт

Дээр тодорхойлсон цахилгаан холбооны тусгай зөвшөөрөлд ямар чиг хандлагыг та өөрийн улсдаа судалсан бэ? Яагаад та тэгж хэлэх вэ?

Шалтгаан нь шууд утгатай. Хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин нь технологийн өөрчлөлтийг ямагт дагах ёстой. Тоон технологийн дэвшлийн дагуу, ялангуяа интернэт, сүлжээ эсвэл дэд бүтцийг зохицуулж байгаа арга замыг өөрчлөх шаардлага байгаа юм. Энэ нь одоо үйлчилгээ үзүүлэгчдийг сүлжээний дэд бүтэц нийүүлэгчдээс ялгаатайгаар авч үзэх боломжтой болсонтой холбоотой юм.

Бодлого боловсруулагчид хуучин зохицуулалтын орчинд шинэ технологи болон түүний үр нөлөө уялдан нийцэхгүй байх асуудлууд урган гарч ирэх хүртэл техникийн өөрчлөлтийг хүлээн сууж болохгүй. Бодлого боловсруулагчид мөрдөгдөж байгаа ямар хууль тогтоомж, зохицуулалтын дүрэм журам шинэ технологиудын нэвтрэлт, шинэ бизнесийн орчны хөгжлийг сулруулж байгааг үнэлэж дүгнэж байх хэрэгтэй. Ялангуяа хууль тогтоомж, зохицуулалтуудын дүрэм, журам дараахь нөхцөл байдлыг үүсгэж байгаа эсэхийг тодруулах ёстой. Үүнд:

1. Бүрэн төгс нэгдсэн үйлчилгээний үр өгөөжийг хүртэхэд хийсвэр саад, тотгор учруулж байгаа эсэх,
2. Тухайн салбарын үйлчилгээний нэг сегмент нь бусад зах зээлд эергээр эсхүл сөргөөр нөлөөлж байгаа эсэхийг тогтоох,
3. Олон нийтийн шинэ үйлчилгээ, нийтийн ашиг сонирхолд нийцсэн шинэ боломж, нөхцөл шаардлагуудад уялдаж байгаа эсэх,
4. Үйлчилгээ хүрээгүй бүсийн иргэдэд сүлжээ болон үйлчилгээний хөгжлийг өргөтгөх замаар шинэ технологи болон үйлчилгээний боломжуудыг хэрэглэх байдлыг бүрэн дүүрэн дэмжих²⁷



Дасгал

Танай улсын хууль эрх зүй, зохицуулалтын орчинг тодорхойлох:

- Бүрэн төгс нэгдсэн үйлчилгээний үр өгөөжийг хүртэхэд хийсвэр саад, тотгор учруулж байгаа эсэх,
- Тухайн салбарын үйлчилгээний нэг сегмент нь бусад зах зээлд эергээр эсхүл сөргөөр нөлөөлж байгаа эсэхийг тогтоох,
- Олон нийтийн шинэ үйлчилгээ, нийтийн ашиг сонирхолд нийцсэн шинэ боломж, нөхцөл шаардлагуудад уялдаж байгаа эсэх
- Үйлчилгээ хүрээгүй бүсийн иргэдэд сүлжээ болон үйлчилгээний хөгжлийг өргөтгөх замаар шинэ технологи болон үйлчилгээний боломжуудыг хэрэглэх байдлыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа эсэх.

Нэг улсаас ирсэн оролцогчдыг энэ дасгалыг багаар хийлгэх байдлаар сурга.

27 ICT Regulation Toolkit, "Module 7: New Technologies and Their Impacts on Regulation," infoDev and ITU, <http://www.ictregulationtoolkit.org/en/Section.1318.html>.

1.3.МХХТ-ИЙН БОДЛОГЫН ХӨГЖИЛД ОЛОН ТӨЛӨӨЛЛИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Бид МХХТ-ийн төрийн бодлого, зах зээлийн удирдлагатай МХХТ-ийн бодлогын хөгжил, технологийн өөрчлөлт болон хууль зохицуулалтын шинэчлэлийн харилцан хамааралтай холбоотой 2 асуудлыг авч үзсэн. Энэ хэсэгт бид ХМХХТ-ийн бодлого боловсруулахад оролцогч талууд хэрхэн оролцох шаардлагыг авч үзнэ.

Оролцогч талуудад боловсруулж буй бодлогод өөрийн ашиг сонирхолтой хувь хүмүүс, бүлэг хүмүүс, байгууллагууд хамаарна. Оролцогч талын өөр нэг тодорхойлолт нь “хэн нэгэн хүний шийдвэр гаргах үйл ажиллагаанд шууд автах өөр нэгнийг”²⁸ хэлнэ. Жишээ нь: Боловсролын МХХТ-той холбоотой төслүүдийн оролцогч талууд нь оюутнууд, эцэг эхүүд, ажилчид, Засгийн газрын агентлагууд, нийгмийн бүлгүүд, сургуулиа төгсөгчид, компьютерийн компаниуд, мултимедиа компаниуд байдаг. Ялгаатай ХМХХТ-ийн асуудлууд нь ялгаатай оролцогч талуудтай байдаг. Боловсролын МХХТ-ийн оролцогч талууд нь эрүүл мэндийн МХХТ-ийн оролцогч талуудаас ялгаатай байна.

Оролцогч талууд нь хүснэгтэнд ялгаатай ашиг сонирхол болон ялгаатай хөтөлбөрийг үзүүлдэг. МНДХУ-д дэлхийн удирдагчид дор дурдсан байдлаар тэмдэглэсэн байдаг:

Засгийн газрууд, хувийн хэвшлийнхэн, иргэний нийгэм, НҮБ, бусад олон улсын байгууллагууд нь Мэдээллийн нийгмийн хөгжилд өөр өөрийн гэсэн чухал үүрэг хариуцлагатай, ялангуяа шийдвэр гаргахад чухал юм. Хүн төвтэй мэдээллийн нийгмийг цогцлоон байгуулах нь бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг шаардах нэгдмэл хүчин чармайлт юм.²⁹

Олон төлөөллийн сонирхогч, оролцогч талуудын бодлого боловсруулах итгэлцэл нь янз бүрийн бүлгүүд нийтлэг зорилгын төлөө ялангуяа ХМХХТ-ыг хэрэглэхэд хамтарч ажиллаж чадна гэсэн итгэлээс үүдэлтэй юм. Олон төлөөллийн оролцогч талуудын түншлэл нь:

1. МХХТ-ийн бодлого болон хэрэгжилтэнд бүхнийг хамарсан, тэнцвэрт байдлыг дэмжих
2. МХХТ-ийн бодлогын асуудлуудыг авч үзэх аналитик чадамжийг өргөтгөх
3. Хөдөөний иргэдийг дайчлах, оролцоог дэмжих
4. Нэгдмэл, төвлөрсөн үйл ажиллагааны төлөвлөгөөний хөгжлийг дэмжих
5. Ур чадвар, шинэ санааны солилцоог хөхүүлэн дэмжих
6. Экспертүүдийн шинэ бүлгийг сургах чухал орчин нөхцлөөр хангах
7. Зах зээлийн чиглэл болон хөгжлийн чиглэлийн хоорондын тэнцвэрийг үүсгэх
8. Түншлэл нь ялгаатай бүлгүүдэд тэдний урагшаа харж хийсэн ажлуудыг уялдуулан зохицуулах, өөрсдийн тус тусын бодлого, хөтөлбөрүүдийн хоорондын зөрчилдөөн, цоорхой, нэгдэн нийлэлтыг тогтоох боломжийг олгодог учир сайн засаглалыг дэмжих
9. Оролцогчдыг тэдний өөрсдийн санхүүгийн нөөцөд түшиглэх боломжийг нээж өгөх
10. Удирдагчид болон үргэлж хоцрогчдыг хоёуланд нь түлхэц болох, энэ нь эдгээрийг хязгаарлагдмал үүрэг болон шударга жүжигчдийн оролцогчдыг хамтад нь авчрахтай хамт урамшуулах орчныг үүсгэж байгаа түншлэл юм
11. Үйл ажиллагааг гардан гүйцэтгэх болон түүнд хүлээх үүрэг хариуцлагыг дэмжих
12. Харилцан үл итгэгч бүлгүүдийн хооронд итгэлцэл бий болгох³⁰

28 Jacques Chevalier, Stakeholder Analysis and Natural Resource Management (June 2001), <http://http-server.carleton.ca/~jchevali/STAKEH2.html>.

29 WSIS, “Declaration of Principles – Building the Information Society: A global challenge in the new Millennium,” <http://www.itu.int/wsis/docs/geneva/official/dop.html>.

30 Lishan Adam, Tina James and Alice Muniya Wanjirar, Frequently Asked Questions about Multi-Stakeholder Partnerships in ICTs for Development: A guide for national ICT policy animators (Melville: Association for Progressive Communications, 2007), 8-9, http://rights.apc.org/documents/catia_ms_guide_EN.pdf.

Оролцогч талуудын бодлого боловсруулахад нэгэн чухал хэсэг нь оролцогч талын дүн шинжилгээ бөгөөд үүнд “тэдний хамаарал, дотоод харилцан хамаарал, өгөгдсөн асуудал эсвэл нөөц дэх сонирхол зэрэг дээр үндэслэн оролцогч талуудыг ялгах, тодорхойлох төрөл бүрийн хэрэгслүүдийг ашиглана”³¹. Оролцогч талын дүн шинжилгээг гүйцэтгэхэд, дараах алхмуудыг авч үзнэ:

1. Дүн шинжилгээний үндсэн зорилгыг тодорхойлох
2. Системийн шийдвэр гаргагч болон түүний тогтолцооны ойлголтыг хөгжүүлэх
3. Үндсэн зарчмын оролцогч талуудыг тодорхойлох
4. Оролцогч талуудын сонирхол, зан байдал, нөхцөл байдлуудыг судлах
5. Оролцогч талуудын хоорондын харилцан үйлчлэлийн загвар, нөхцлийг тодорхойлох
6. Удирдлагын сонголтуудын тодорхойлох³²

Оролцогч талын дүн шинжилгээний илүү нарийвчилсан арга барил нь Хөдөө Аж Ахуйн Мэдлэгийн Системийн Хурдацтай Үнэлгээгээр олгогдоно. Энэ нь системтэй, тусгайлан загвараар оролцогч талууд болон тэдний сүлжээг үнэлэх зорилгоор боловсруулагдсан оролцогчид чиглэсэн арга юм. Энэ нь гурван ерөнхий үе шат, 16-н алхмуудаас бүрдэнэ.

Үе шат А. Асуудлыг тодорхойлох

1. Зорилтуудыг үнэлэх
2. Хамааралтай оролцогчдыг тодорхойлох
3. Янз бүрийн зорилгын заавруудыг ялган таних
4. Орчныг тодорхойлох
5. Асуудлыг тодотгох, дахин тодорхойлох

Үе шат В. Хязгаарлалт болон боломжуудын дүн шинжилгээ

1. Нөлөөлөл
2. Оролцогчид
3. Мэдлэгийн сүлжээнүүд
4. Интеграцчилал
5. Зорилтууд
6. Уялдаа холбоо
7. Холбоо
8. Шинэ санаачлагад зориулсан нийгмийн байгууллыг ойлгох

Үе шат С. Стратеги – Үйл ажиллагааны төлөвлөгөө

1. Мэдлэгийн удирдлага
2. Оролцогчийн чадамж – Хэн юу хийж чадах вэ?
3. Үйл ажиллагааны төлөвлөгөөний стратегийн даалгавар³³

МХХТ-д олон оролцогч талуудын түншлэлийг амжилттай байлгахын тулд, бодлого боловсруулагч нар Глобал мэдлэгийн түншлэлийг гаргасан төсөл болох Олон оролцогч талуудын зарчмуудыг сайн санаж байх хэрэгтэй. Эдгээр зарчмууд Нэмэлт мэдээлэл 3-т агуулагдсан болно.

31 Ricardo Ramirez, “Chapter 5: Stakeholder analysis and conflict management,” in *Cultivating Peace: Conflict and Collaboration in Natural Resource Management*, ed. Daniel Buckles (Ottawa: International Development Research Centre, 1999), http://www.idrc.ca/en/ev-27971-201-1-DO_TOPIC.html.

32 Ibid.

33 For more details see “Introduction: problem, purpose and design,” http://www.kit.nl/net/KIT_Publicaties_output/ShowFile2.aspx?e=604.

Нэмэлт мэдээлэл 4. Олон төлөөллийн оролцогч талуудын түншлэлийн зарчмууд

ЗАРЧИМ 1

Олон салбарын МХХТ-ийн түншлэлийн арга барилыг ашиглах үеэ мэдэх нь дараах гурван онцлог шинжүүдийн огтлолцолыг таних явдал юм: ямар МХХТ боломж олгогчоор ажиллаж чадахад тогтвортой хөгжлийн хэлэлцэх асуудлын эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд; тогтвортой хөгжлийг нээгч МХХТ-ийн суурилуулахад байнгын сорилт тулгарах, ялангуяа дан ганц талын гаргасан эсвэл гэрээний түншлэлээр хийсэн шийдлүүдийн зохиомж бүтэлгүйтэх тохиолдолд; эдгээр байнгын МХХТ-ийн сорилтууд, тэдний цогц байдлаас шалтгаалан бизнес, засгийн газар, иргэний нийгэмд нөөцүүд болон чадваруудын стратегийн нийцлийг шаарддаг.

ЗАРЧИМ 2

Түншлэлд орохдоо түүнийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө, оролцооны үндсэн хөдөлгөчийг хангахад түүний төслийн үнэ цэнэ нь боломжтой бусад хувилбар болон эрсдлүүдийн эсрэг төвийг сахисан байдлаар харьцуулагдсан байх ёстой.

ЗАРЧИМ 3

Олон оролцогч талуудын МХХТ-ийн түншлэл нь бусад талуудын ашиг сонирхлыг хангах шийдлийг олохын тулд талуудын өөрсдийнх нь ашиг сонирхол тохирох үед хамгийн сайн ажиллаж чадна. Энэ нь түншлэл хоёр талдаа батжиж байгаа үед юм.

ЗАРЧИМ 4

Амжилттай түншлэлүүд нь зарим стратегийн зохиомжийн параметруудтэй нийцэх нэмэгдэл чадвар болон нөөцүүдийн хослол дээр үндэслэн бий болдог.

ЗАРЧИМ 5

Түншлэлийн нөөцүүд болон чадварууд нь болж өгвөл түншлэлийн байгууллагын үндсэн гол бизнестэй ойр байдлаар дүрслэгдсэн байх хэрэгтэй, зорилтуудад түншлэлийн хамаарал болон байгууллагын өдөр бүрийн үйл ажиллагааг үлдээхийн тулд, түншлэлд тэдний одоогийн байгаа тогтмол зардлаас илүүтэйгээр хувьсах зардлаас тусламж авч буй түншлэлийн үр дүнтэй байдлыг ашиглахад юм.

ЗАРЧИМ 6

МХХТ-ийн түншлэлийн олон оролцогч талуудын хэлбэрийг үл харгалзан өмнөх зохицуулалт нь бичигдсэн баримт бичгийн адилтган таних зарим хэлбэрийг хайх ёстой бөгөөд хамгийн багадаа: түншлэлийн солилцсон зөн; түншлэлийн хамтрагч бүрийн зорилтууд; үүрэг, хариуцлагын хуваарьлалт. Баримт бичгийн ёс суртахууны болон хуулийн статус нь нөхцөл байдлаас хамаардаг.

ЗАРЧИМ 7

Олон оролцогч талын МХХТ-ийн түншлэлийн үр дүнг үнэлэх үед, гадаад хүчин зүйлүүд болон дараагийн боломжтой бусад сонголт дахь түншлэлийн үйл ажиллагаануудын нэмэгдэл тусламжийг тодорхойлоход бүх анхаарал чиглэгдсэн байх ёстой. Түншлэлийн нэмэгдэл үнэ = Түншлэлийн үр дүнгийн үнэ – (Гадаад хүчин зүйл + Боломжтой бусад сонголт)

Эх сурвалж: Abridged from Global Knowledge Partnership, Multi-stakeholder Partnerships: Issue Paper (Kuala Lumpur: Global Knowledge Partnership Secretariat), http://www.globalknowledge.org/gkps_portal/index.cfm?menuid=178&parentid=179.



Асуултууд

Таны хувьд, олон оролцогч талын түншлэлийн аль зарчмууд нь голдуу судлагдаагүй, орхигдсон байна вэ? Та яагаад энэ тохиолдлын талаар бодож байна вэ



Дасгал

Хэн таны МХХТ-ийн оролцогч талууд вэ? Оролцогч талууд болон тэдний үндсэн сонирхлыг тодорхойлж, дараах ХМХХТ-ийн төслүүдийн тэдний байр сууринаас сул тал болон давуу талуудыг тодорхойлуул.

- Эрүүл мэндэд зориулсан МХХТ
- Боловсролд зориулсан МХХТ
- Хөдөө аж ахуйд зориулсан МХХТ
- Гамшгийн удирдлагад зориулсан МХХТ

Нэг улсаас ирсэн оролцогчдыг нэг бүлэг болгон энэ дасгалыг гүйцэтгүүл.



Өөрийгөө шалгах нь:

1. ХМХХТ-д засгийн үүрэг юу вэ?
2. Зах зээлийн удирдлагатай МХХТ-ийн стратеги гэж юу вэ? Мэдээллийн дэд бүтцийн хөгжилд энэ хэрхэн тодорхойлогдсон бэ?
3. Хөгжилд ТББ-уудын үүрэг юу вэ?
4. Хуулиудад, ялангуяа зохиогчийн эрхийн хуульд цахим хувьсгалын нөлөөллүүд нь юу вэ?
5. МХХТ-ийн оролцогч талууд гэж хэн бэ? Яагаад тэд үүнд оролцоход чухал вэ?

Нэмэлт унших материал

Considine, Mark. 2015. Төрийн бодлого хийх нь: Институтууд, Оролцогчид, Стратегууд, Англи улс: Төрийн бүтэц.

Hanna, Nagy K. 2003. Яагаад үндэсний стратегиуд МХХТ-ашигласан хөгжилд хэрэгтэй вэ. ISG ажилчны ажлын илтгэлүүд. http://wsispapers.choike.org/national_strategies.pdf.

Labelle, Richard. 2005. МХХТ-ийн бодлого томъёолох, цахим стратегийг хөгжүүлэх: Өргөн хүрээний мэдээллийн ном. Банког: НҮБ-ын Ази Номхон Далайн бүсийн Хөгжлийн Мэдээллийн Хөтөлбөр. <http://www.apdip.net/publications/ict4d/ict4dlabelle.pdf>.

Lallana, Emmanuel C. 2004. МХХТ-ийн бодлогын ерөнхий танилцуулга болон сонгомол Азийн эдийн засгийн цахим стратегиуд. Банког: НҮБ-ын АНДБ-ийн Хөгжлийн Мэдээллийн Хөтөлбөр. <http://www.apdip.net/publications/ict4d/OverviewICTPolicies.pdf>.

Missika-Wierzba, Bathylle and Mark Nelson. 2006. Чадамж хөгжүүлэлтийн хувьсгал? Африкчууд хүнд асуултууд асуудаг. Washington, D.C.: World Bank Institute.
http://siteresources.worldbank.org/INTCDRC/Resources/CapDev_No16_5.3.06.pdf.

Stiglitz, Joseph. 2007. Даяарчлалын ажил хийх. Лондон: Оцон шувууны номнууд.

Tipson, Frederick S. and Claudia Frittelli. 2003. “Хөгжлийн төлөөх глобал цахим боломжуудын үндэсний стратеги” Markle Сан.
http://www.markle.org/downloadable_assets/gdoi_1223.pdf.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. Үнэлгээний газар. 2001. ХМХТ-ны технологи. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн чухал зүйлсүүд: Сурсан хичээлээс синтез хийх. New York: НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. <http://www.internetpolicy.net/practices/essentials5-web.pdf>.

2. ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ҮНДЭСНИЙ МХХТ-ИЙН БОДЛОГЫН ЭЛЕМЕНТҮҮД

Энэ бүлэг нь өргөн хүрээний үндэсний МХХТ-ийн бодлогын гурван элементүүд болох чадавхи бүрдүүлэх, эдийн засгийн МХХТ-ийн салбарыг бий болгох, болон цахим засаглалтай холбоотой асуудлуудыг онцлон авч үзэж, хэлэлцэнэ.

Бусад тоймчийн тэмдэглэн хэлснээр, “үндэсний МХХТ-ийн бодлогын үндсэн зорилго нь үндэсний хөгжлийн зорилготой нийцэх замаар өргөтгөсөн МХХТ-ийн хэрэглээний үр ашиг болон эрсдлийн тэнцвэрийг хангах”³⁴ юм. Тиймээс өргөн хүрээний МХХТ-ийн үндэсний бодлого нь зарим чухал элементүүдийг багтаах юм. Энэ хэсэг эдгээр гурван элементүүд болох хүний капиталыг хөгжүүлэх, МХХТ-н үйлдвэрлэл болон цахим засаглалыг байгуулах зэргийг хэлэлцэх юм.

Хэлэлцүүлэгт орохоос өмнө бид 2 чухал үндсэн асуудлыг авч үзье.

Нэгдүгээрт, МХХТ-ийн үндэсний бодлогыг хийх нь зөвхөн нэг удаагийн үйл ажиллагаа бус юм. Нэг баримт бичигт бүх ойлгомжтой үндэсний МХХТ-ийн зорилгуудад хүрэх төлөвлөгөө байх ёсгүй. Энэ тал дээр амжилт олсон улсууд өмнөх төлөвлөгөөнүүд тусгагдсан зүйлс дээр төвлөрөн шинэ төлөвлөгөөнүүдтэй цуврал МХХТ-ийн үндэсний бодлогуудыг хийсэн байдаг. Жишээ нь: БНСУ 2010 он гэхэд дэлхийн хэмжээний мэдээлэлжүүлэлтийн түшинд хүрэх зорилготойгоор Үндсэн Мэдээлэлжүүлэлтийг Дэмжих Төлөвлөгөө (1996-2000) –өөр эхэлсэн. Үүний дараа тэргүүлэх мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах зорилготойгоор Кибер Солонгос 21 (1999-2002) гарсан. Гуравдугаар төлөвлөгөө нь Цахим Солонгос Зөн 2007 (2002-2007) –г “Цахим Солонгосыг дэлхийд тэргүүлэгч” болгоно гэсэн зорилготойгоор гаргаж байсан. Хамгийн сүүлийн үндэсний төлөвлөгөө нь Өргөн зурвасын Мэдээллийн Технологийн Солонгос Зөн 2007 бөгөөд энэ нь ирээдүйн Солонгосыг дүр төрхийг тодорхойлох дараах зорилгуудтай:

- Төрийн үйлчилгээний үр дүнтэй байдал, ил тод байдлыг бэхжүүлэх цахим засаг
- Глобал өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх цахим шилжилт (e-Transformation)
- Өргөн зурвасын холбооны сүлжээг байгуулах болон өсөлтийн шинэ хөдөлгүүрийг олох
- Цахим нийгмийн хангамжийн төрийг ойлгох
- Глобал мэдээллийн технологийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх³⁵

Хоёрдугаарт, энэ хэсэг ҮТДБ-ийн хөгжлийг авч үзэхгүй, ҮТДБ нь тухайн улсын хэрэгцээний дагуу дуун, өгөгдөл, текст, зураг, видео мэдээллийг интерактив горимоор дамжуулах чадамжтай өргөн зурвасын сүлжээ юм. ҮТДБ-ийг хөгжүүлэх шаардлага нь тодорхой болсон. Ихэнх улсууд ХМХХТ-ийн бодлогодоо ҮТДБ-ийг хөгжүүлэх асуудлыг хамгийн нэгдүгээрт тавьсан байдаг. Харамсалтай нь ҮТДБ-ийн асуудал нь ХМХХТ-ийн бодлогын бусад элементүүдэд дарагдаж байдаг. Зарим талаараа дэд бүтцийн хөгжилд чухал байр сууринаас хандах оролдлого нь, орон зай, цаг хугацааны хязгаарлалт, цахилгаан холбооны хөгжил өмнөх хэсэгт аль хэдийн хэлэлцэгдсэн учраас, дараагийн хэлэлцүүлгүүдийн төвлөрөл ХМХХТ-ийн үндэсний бодлогын бусад чухал элементүүд болох чадавхи бүрдүүлэх, эдийн засгийн МХХТ-ийн салбарын хөгжүүлэлт, болон цахим засаглал дээр байх болно.

34 Association for Progressive Communications, “Part 3: Policy and regulation,” ICT Policy Handbook, http://rights.apc.org/handbook/ICT_11.shtml.

35 Dong-pyo Hong, presentation for Workshop on Technology Innovation and Economic Growth, Hangzhou, China, 25-26 May 2005, http://info.worldbank.org/etools/docs/library/144050/Development_of_ICT.pdf.

2.1.МХХТ-ИЙН ЧАДАВХИ БҮРДҮҮЛЭХ

Ихэнх Засгийн газрууд мэдээллийн дэд бүтцийн хөгжлийг нэн тэргүүний зүйл болгосон нь зөвхөн интернэтэд холбогдогдох байдлыг хангах гэсэн үг биш юм. Хэдийгээр интернэтийн холболт нийгэмд үнэгүй байхаар хийгдсэн ч, нийгмийн гишүүдийн хэн ч интернэтийг хэрхэн ашиглахыг мэддэггүй болохоор нийгмийн интернэтийн хандалт хэрэггүй зүйл болж байгаа юм. Bridges.org-ийн тэмдэглэн хэлснээр:

Хэрвээ хүмүүс ямар нэгэн технологийг тэдний өөрсдийн ажил, амьдралд хэрхэн үр дүнтэйгээр ашиглахаа мэдэхгүй бол тухайн технологи бол хүрэлцээгүй байна гэсэн үг. Учир нь тэд тухайн технологийг хэрэглэх талаар сургагдаагүй эсвэл тэднийг ашиглах боломжуудыг нь төсөөлж, сэтгэж чаддаггүй юм. Хүмүүс зөвхөн МХХТ-ыг тэдний амьдралд илэрхий эерэг нөлөө үзүүлж чадна гэдгийг мэдсэн үедээ л тэдгээр технологийг хэрэглэдэг. Цаашлаад энэ нь технологийн өргөн хүрээний боломжуудыг мэдэж, хэрэглэгчид өөрсдийгөө шинэчлэх эрхтэй болж, тухайн технологийг ямар нэгэн бодлого, төслөөр тодорхойлогдох бүтээлч замаар ашиглаж эхэлдэг.³⁶

Тиймээс МХХТ-ийн чадавхийг бүрдүүлэх нь ХМХХТ-ийн хүчийг илүү бэхжүүлэхээр оролдож байгаа ямар нэгэн улсын хувьд бодлогын чухал зорилт юм.

ОУЭХАБ “чадавхийг” тодорхойлохдоо хүмүүс, байгууллага, нийгэм бүхэлдээ өөрсдийн үйл ажиллагаагаа амжилттайгаар удирдахыг³⁷, харин “чадавхи бүрдүүлэлт” гэдгийг хүмүүс, байгууллага, нийгэм бүхэлдээ чадавхийг цаг хугацааны туршид илрүүлэх, хүчирхэгжүүлэх, үүсгэх, тохируулах, сахихыг³⁸ хэлнэ.

Бодлого боловсруулагчид МХХТ-ийн чадавхи бүрдүүлэлттэй холбоотой хоёр чухал ерөнхий асуудлуудтай тулгардаг. Нэгдүгээрт бүх иргэд мэдээллийн эрин үед амжилт олох чадваруудтай байх. Нөгөө асуудал нь МХХТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг хөгжүүлэх, ингэснээрээ тухайн улсын МХХТ-ийн салбар болон эдийн засаг тогтвортой хэлбэрээр өсөж чадна. Бид боловсролын МХХТ-ийн хэлэлцүүлэгт эхний хэсгийг авч үзнэ. Дараагийн хэсгийг МХХТ-ийн ур чадварыг хөгжүүлэх хэлэлцүүлэгт авч үзнэ.

Боловсролын МХХТ

Мэдээллийн нийгмийн амжилт нь аж үйлдвэрийн нийгмийн мэргэжлээс ялгаатай ур чадваруудыг шаарддаг. Олон улс орнууд өөрсдийн иргэддээ үндсэн МХХТ-ийн мэргэжлийг тодорхойлох чигт хөдөлж эхэлсэн. Жишээлбэл, 2008 оны 2 сард АНУ-ын МХХТ-ийн бичиг үсгийн бодлогын үндэсний зөвлөл нь бүх оюутнуудад зориулсан үндсэн МХХТ-ийн мэргэжлийг тодорхойлох МХХТ-ийн бичиг үсэг тайлах үндэсний стандартуудыг боловсруулсан³⁹. Энэ стандарт нь МХХТ-ийн бичиг үсэгт зориулсан үндэсний стандартын хамгийн анхны алхам нь байсан юм. Англи мөн “МХХТ-ийн амьдралын мэргэжлийн стандартыг” тодорхойлсон нь одоогийн байгаа насанд хүрсэн хүний бичиг үсэг болон насанд хүрсэн хүний тоо тоололд зориулсан стандартын дагуу болсон юм.⁴⁰

36 See “Real Access/Real Impact criteria,” bridges.org, http://www.bridges.org/Real_Access.

37 OECD, The Challenge of Capacity Development: Working Towards Good Practice (Paris: OECD, 2006), 12. <http://www.oecd.org/dataoecd/4/36/36326495.pdf>.

38 Ibid.

39 Reuters, “National ICT Literacy Standards Set” (21 February 2008), <http://www.reuters.com/article/pressRelease/idUS133743+21-Feb-2008+MW20080221>.

40 Department for Education and Skills, National Standard for Adult Literacy, Numeracy and ICT (London: Qualifications and Curriculum Authority, 2005), http://www.qca.org.uk/libraryAssets/media/14130_national_standards_for_adult_literacy_numeracy_ict.pdf.

Гэхдээ үндсэн МХХТ-ийн мэргэжлүүд нь зөвхөн мэдээллийн нийгэмд шаардлагатай мэргэжлүүд биш юм. Экспэртүүд мөн үүнийг 21-р зууны хөгжлийн стандартууд болох бүтээлч байдал, асуудал шийдвэрдэх чадварууд, мэдээллийн бичиг үсэг, холбооны мэргэжил болон бусад дээд дарааллын сэтгэх чадварууд үүнд багтана гэж тодорхойлсон.⁴¹

Аливаа улсын боловсролын систем нь МХХТ болон 21-р зууны мэргэжлүүдийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй байх ёстой бөгөөд ДБ-ны боловсролын санаачлагын МХХТ дэлхий дахинд явуулсан судалгаа нь дараах зүйлсийг гаргаж ирсэн байдаг:

- Хэрэглэгчид МХХТ-ууд нь эерэг өөрчлөлтийг авчирна гэдэгт итгэж байна
- МХХТ ялгаатай сургуулиудын хичээлд ялгаатай байдлаар хэрэглэгдэж байна
- Боловсролы МХХТ-ийн хэрэглээний эерэг нөлөөлөл батлагдаагүй
- Боловсролын МХХТ-ийн эерэг нөлөөлөл сурган хүмүүжүүлэх ухаантай холбогдсон үед л илүү гарч ирэх магадлалтай
- Компьютер ашигласан зааврууд зарим салбарын хувьд олон сонголт хийх, стандартчилсан тестчилэл хийх үйл ажиллагаанд оюутнуудын гүйцэтгэлийг бага багаар нэмэгдүүлж байна
- МХХТ нь хэрвээ түүний хэрэглээний зорилго нь тодорхой бус байх үед энэ нь бага үр дүнтэй байна
- Уламжлалт болон шинэ сурган хүмүүжүүлэх ухааны хооронд мөн хамгийн сүүлийн үеийн болон стардчилагдсан тетчилэлийн хооронд томоохон хүндрэл байна⁴²

ДБ-ны эдгээр ололтуудаас харахад зөвхөн технологи дээр төвлөрсөн боловсролын хөтөлбөрүүдийн МХХТ нь тодорхой байгаа бөгөөд бүтэлгүйтэх магадлалтай тохиромжтой сурган хүмүүжүүлэх ухаанаар баталгаажаагүй юм. Өөр нэг зугтаах ёстой хялбарчилсан хандлага нь МХХТ-ийн бичиг үсгийг заахад сургуулиудад компьютер ашиглахыг хязгаарлаж байгаа юм. Дараах зүйлс нь боловсролд МХХТ-ыг хэрэглэхэд бодлогын хувьд авч үзэх шаардлагатай асуултуудын заримаас орууллаа. Үүнд:


- Боловсролд МХХТ-ыг ашиглах хамгийн тохиромжтой нас хэд вэ?
- Тоон технологиуд болон мултимедиа агуулгын ашигтай талуудыг зааж байгаа аргуудаа бид хэрхэн өөрчилж чадах вэ?
- Математик эсвэл шинжлэх ухааныг заахад МХХТ хэрхэн ашиглагдах вэ?

Боловсролын МХХТ-ийн стратеги нь сургуулийн МХХТ-оос ялгаатай байх ёстой гэдгийг санах нь чухал юм. Албан бус, насанд хүрсэн хүний боловсролд МХХТ нь боловсролын үндэсний МХХТ-ийн бодлогын хэсэг нь байх ёстой. Англи улс боловсролын МХХТ-ийн сонирхолтой хандлагыг харуулж байна.

41 For further discussion of 21st century skills, see "Framework for 21st Century Learning," Partnership for 21st Century Skills, http://www.21stcenturyskills.org/index.php?option=com_content&task=view&id=254&Itemid=120.

42 Michael Trucano, Knowledge Map: ICT in Education (Washington, D.C.: infoDev / World Bank, 2005), 5-6, <http://www.infodev.org/en/Publication.8.html>.

Зураг 1. Английн e-Стратеги – Технологийг бэхжүүлэх нь: Хүүхдийн үйлчилгээ олон Сургалтын арга барилыг өөрчлөх



МХХТ-ийн ур чадварын хөгжил

Засгийн газрууд МХХТ-ийн ур чадвартай мэргэжилтнүүдийн ажиллах хүчийг үүсгэхэд туслах хөтөлбөрүүдийг боловсруулах хэрэгтэй юм. Эдийн засагт эрчимтэй орон нутгийн МХХТ салбар байлгахыг хангах төдийгүй, хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлж байгаа МХХТ-ийн төслүүдийн заримаас нь авах боломжтой байх юм. Урт хугацааны зорилт нь шинэ технологийн хэрэглээг эрчимжүүлснээр үндэсний өрсөлдөх чадварын давуу талуудыг бий болгох явдал байдаг. АНДО-д МХХТ-ийн мэргэжлийн шаардлага өсөж

байна.⁴³ МХХТ нийлүүлэлтийн зах зээлд нийт шаардлагатай байгаа мэргэжилтнүүдийн тоог хурдацтайгаар өсгөх, 2010 онд 17 саяд хүргэх шаардлага байна. МХХТ-ийн хэрэглэгчийн зах зээлд шаардлагатай байгаа мэргэжилтнүүдийн тоог 2010 онд 73 сая хүртэл өсгөнө.

Тусгай МХХТ-ийн мэргэжлээр, Computer world 2010 гэхэд дараах “халуун мэргэжлүүдийг” тодорхойлсон байна. Үүнд: үйлдвэрлэлийн архитектур, төслийн удирдлага, бизнесийн үйл явцыг дахин инженерчлэх, төслийн төлөвлөлт, санхүүгийн төлөвлөгөө хийх болон хуваарь гаргах, гуравдагч талыг хангах менежрүүд, системийн шинжилгээ, системийн зохиомж, сүлжээний дизайн, системийн аудит, мэдээллийн технологийн аюулгүй байдлын төлөвлөгөө болон удирдлага, хадгалалтын админ.⁴⁴ Үүнтэй адилхан сэтгүүл дараах мэргэжлүүдийг “хүйтэн мэргэжил” гэж тодорхойлсон байна. Үүнд: програмчлал, нийтлэг кодчилал, системийн тестчилэл, дэмжлэг үзүүлэх буюу тусламжийн ширээ, хуулийн мэргэжлүүд.

Харамсалтай нь МХХТ сургалтын одоогийн байгаа үндэсний институтууд нь МХХТ-ийн мэргэжилтнүүдийн шаардлагыг тоо хэмжээний хувьд ч, төгсөж байгаа мэргэжилтнүүдийн хувьд зохих чанар чансаагаараа хангаж чадахгүй байна.

Эрэлт, нийлүүлэлтийн цоорхойг нөхөхөд шаардлагатай үйл ажиллагаанууд нь:

- Эрх мэдэл бүхий үндэсний байгууллага МХХТ боловсролын хөтөлбөр, сурган хүмүүжүүлэх арга барилыг тогтмол шалгаснаар боловсролын чанарт хатуу чанга хяналтыг бий болгох
- Эрх бүхий хянан шалгагчийн шалгалтанд үндэслэсэн үндэсний болон бүс нутгийн мэргэжлийн гэрчилгээ олгодог төвүүдийг байгуулах. (Практикт гарч ажиллахын тулд гэрчилгээ авах шалгалтанд тэнцсэн байх)
- Тохиромжтой МХХТ-ийн мэдлэг, ур чадвар түүн дотроо танин мэдэхүйн ур чадварыг олгох курсуудыг хөгжүүлэх, зохиомжлохын тулд МХХТ үйлдвэрлэл, засгийн газар, сургалтын төвүүдийн хоорондын байнгын хамтын ажиллагаа⁴⁵

Энэ нь мөн шаардлагад нийцэхийн тулд шинэчилсэн сургалтын аргачлал шаардлагатай болно. МХХТ-ийн мэргэжлийг хөгжүүлэх хөтөлбөрүүд нь зайны сургалт, вэбын агуулгад суурилсан өөрөө сурах, цахим Сургалтын Удирдлагын Систем, мэдлэг солилцох бүлэг хүмүүс зэрэг нь эдгээрийг шийдвэрлэх стратегийн зорилт юм.⁴⁶

Энэ нь янз бүрийн эдийн засгийн салбарт ажиллаж байгаа, цаашлаад МХХТ-ийн салбарт шилжих хүсэлтэй байгаа ажилчдад МХХТ-ийн сургалтыг олгох хөтөлбөрийг боловсруулснаар боломжтой ур чадвартай МХХТ-ийн ажилчдын хүрээг өргөтгөхөд чухал юм.

Сингапурын МХХТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх төлөвлөгөө нь бодлого боловсруулагчдад тэд өөрсдийн төлөвлөгөөгөө хийхдээ юуг анхаарч авч үзэх ёстой талаархи загварыг өгдөг.

43 Ravi Raina, *APDIP e-Note 13 - ICT Skill Development in the Asia-Pacific Region - Part one: the gap between demand and supply* (Bangkok: UNDP-APDIP, 2007), 2, <http://www.apdip.net/news/apdipenote13>. The data cited in subsequent paragraphs, unless indicated otherwise, is from this publication.

44 Stacy Collett, "Hot Skills, Cold Skills: The IT worker of 2010 won't be a technology guru but rather a 'versatilist'," *Computerworld*, 17 July 2006, <http://www.computerworld.com/action/article.do?command=viewArticleBasic&articleId=112360&pageNumber=3>.

45 Ravi Raina, *APDIP e-Note 17 - ICT Skill Development in the Asia-Pacific Region - Part two: Bridging the gap between demand and supply* (Bangkok: UNDP-APDIP, 2007), 2, <http://www.apdip.net/news/apdipenote17>.

46 Ibid.



Сингапурын мэдээллийн технологийн⁴⁷ хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр

Мэдээллийн технологи сүүлийн хэдэн арван жилд тал бүрийн газар нутгийн байдлаа өөрчилсөн, мэдээлэл болон зах зээлд газар зүйн болон соёлын хүндрэлүүдээ устгаж, хүмүүсийн бодож, үйл ажиллагааг явуулж байгаа тэр замд үндсэн загварын шилжилтүүдийг хүчээр хийсэн. Энэ тоон хувьсгал нь мэдээллийн технологийн хийх боломжтой шинэчилсэн бизнесийн загварыг хайх байдлаар харагдаж, шинэ үеийн эдийн засгийн анхдагчдийг (Google, eBay, Skype шиг) үйлдвэрлэж байна.

Эргээд харахад мэдээллийн технологийн дэвшлийн хурдац эдийн засагт төдийгүй, компаниудад хүчирхэг өрсөлдөөний шахалтыг мэдрүүлж, өрсөлдөөнөөс өөрсдийгөө ялгах боломжтойд нь их хэмжээний өсөх боломжуудыг үүсгэж байна. Энд аливаа улс эсвэл компани амжилт олох нь мэдээллийн технологийг шинэ аргаар хөдөлгөж чадах чадварлаг ажиллах хүчийг хөгжүүлэх, өөртөө татах, ажиллуулах чадвараар тодорхойлогдоно.

Энэ нь тал бүрийн газар нутгийн байдалд Сингапурын зөн нь “ухаалаг” ажиллах хүчин, дэлхий дахинд өрсөлдөж чадахуйц мэдээллийн технологийн ажиллах хүчийг бэлдэж, үндэсний эдийн засгийн өрсөлдөөнт байдлыг жолоодохын тулд юм.

Зорилго

Энэ зөнг амжилттай болгохын тулд, IDA өөрийн зорилгыг тодорхойлсон. Энэ нь:

- 2015 он гэхэд мэдээллийн технологийн 55000 ажлын байрыг 170000 болгож өсгөх

Энэ нь мэдээллийн технологийн салбарт мэдээллийн технологийн бус 25000 ажлын байр бий болгох, эдгээр ажлыг байрны тоог ойролцоогоор 70000 болгох.

Нийтдээ, шинээр бий болгох нийт ажлын байрны тоо нь ойролцоогоор 80000 байх юм.

Стратеги зорилт

Энэ зөн болон зорилгыг хангахын тулд дараах стратеги шаардлагатай болно.

- **Голлох эдийн засгийн салбаруудад мэдээллийн технологийн чадварыг хөгжүүлэх**
Бизнесийн удирдлагуудад өөрсдийн байгууллагад нь мэдээллийн технологийн үнэ цэнийг ойлгуулах, тэдний итгэлийг нэмэгдүүлэх шаардлага байгаа төдийгүй ерөнхий ажиллах хүчний дунд мэдээллийн технологийн ур чадварыг түвшинг нэмэгдүүлснээр тэд бизнесийн үйлдвэрлэлийн бүтээмж болон өрсөлдөөнт байдлыг сайжруулах мэдээллийн технологийг шинэчлэн бэхжүүлж чадна.

Энэ стратегийн түлхэлтийн хөтөлбөрүүд нь бизнесийн удирдлагуудруу болон ерөнхий ажиллах хүчинд чиглэсэн бөгөөд дараах зорилготой байна: »

47 Infocomm¹ is the term Singapore uses for 'information and communication technology'.

- » А. Шийдвэр гаргагчдын дунд технологийг хүлээж авах зуршлыг бий болгох
В. Ерөнхий ажиллах хүчийг илүү боловсронгуй мэдээллийн технологийн ур чадваруудаар тоноглох

- **Дэлхий дахинд өрсөлдөх чадвартай мэргэжилтнүүдийг хөгжүүлэх**
Технологийн ноу-хау –ийн гүн мэдлэгтэй, бизнесийн сайн ойлголттой, оюуны өмч бүтээх чадавхитай мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг бий болгох шаардлага байна.

Энэ стратегийн түлхэлтийн зорилгын хөтөлбөрүүд нь мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд чиглэсэн бөгөөд дараах зорилттой байна:

- А. Технологийн стратеги боловсруулагчдыг хөгжүүлэх
- В. Технологийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх

- **Мэдээллийн технологийн авъяасыг хөгжүүлэх, татах, авч үлдэх**
Мэдээллийн технологи үйлдвэрлэлийн өсөлтийг жолоодох, ирээдүйн удирдагчид, ажиллах хүчин болох залуучууд өөрсдийн өдөр бүрийн амьдралд технологийн шинэчлэлийг хийх идэвхижүүлэлттэй байх шударга авъяастнуудыг өөртөө татдаг байх шаардлагатай байна.

Энэ стратегийн түлхэлтийн хөтөлбөрүүд нь оюутнуудад чиглэсэн дараах зорилготой байна:

- А. Мэдээллийн технологийн чиглэлийн ажилд дотоодын болон гадаадын чадварлаг оюутнуудыг татах
- В. Залуучуудад хаана ч хэрэглэж чадах мэдээллийн технологийн шинэчлэлүүдийг хэрэглэх шинэ санаачлагуудыг бий болгох

Дээр дурдсан гурван стратегийн түлхэлт дээр нэмээд, бид тоон хуваагдалд гүүр бий болгох, мэдээллийн технологи хөгшин, ядуу тарчиг, хөдөлмөрийн чадваргүй иргэдэд үр ашигтай байж чадах, бүрэн эрхтэй болгох хүчирхэг түвшинг тогтоох хэрэгслээр хэрэглэгддэг бүх зүйлийг агуулсан, багтаасан нийгмийг байгуулах зорилготой юм.

Энэ нь технологийн тав тухтай байдлыг мэдрэх, мэдээллийн технологид хандах боломжийг хангах, мэдээллийн технологийн ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний өөрсдийн ажил эрхлэлтийг бэхжүүлэх, үндсэн арга барилтай нэгтгэх, илүү бие даасан, таатай амьдралыг удирдах зэрэг хөтөлбөрүүдээр хийгдэх юм.

Эх сурвалж: Abridged from IDA Singapore, "Manpower," <http://www.ida.gov.sg/Manpower/20060414201723.aspx>.



Асуултууд

1. Яагаад МХХТ-ийн хүний нөөцийн хөгжил бодлоготой байх шаардлагатай вэ?
2. Мэдээллийн технологийн мэдлэгтэй ажиллах хүчинг хөгжүүлэхтэй холбоотойгоор танай улсын ямар зорилтууд байх ёстой талаар та ямар бодолтой байна вэ?



Дасгал

Чадавхи бүрдүүлэх урьтамжууд – маргаан А

Та танай Засгийн газрын хамгийн түрүүнд хийх ёстой зүйл нь аль нь гэж бодож байна – боловсролд МХХТ-ыг нэгтгэх эсвэл МХХТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадвар? Эхлээд шийдвэр гаргахаасаа өмнө хоёр талуудын хувьд шалтгаануудыг жагсааж бич.

Сургалтанд оролцогчид хоёр бүлэгт хуваагдаж: нэг бүлэг нь боловсролын МХХТ-ийн тохиолдлыг, нөгөө бүлэг нь МХХТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг авч хоорондоо мэтгэлцэж өрсөлдөх.

2.2.МХХТ-ИЙН АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ БАЙГУУЛАХ НЬ

Аливаа үндэстний МХХТ-ийн үйлдвэрлэл нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд томоохон эдийн засгийн салбар мөн нийт эдийн засгийн хувьд үйлдвэрлэлийн хөдөлгөгч хүч, сайжруулсан үйлчилгээний чанар гэдэг аль аль талаараа чухал байдаг. Өнөөдрийн глобал эдийн засгийн хувьд Засгийн газрууд үндэстний эдийн засаг, нийгмийн хөгжлийг хөдөлгөхөд өөрийн бүхий л үүргээрээ тоглож, хөгжүүлж байгаа энэ салбарын хувьд зөв орчноор хангаж байгааг хангахын тулд түргэн шуурхай, шийдвэртэйгээр хөдлөх хэрэгтэй юм.

МХХТ-ийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх энэ хэлэлцүүлэг нь гурван хэсэгт хуваагдана. 1) МХХТ-ийн үйлдвэрлэл, 2) Гадаад зах зээл, глобал програм хангамжийн хөгжүүлэлт 3) Контентын зах зээл.

МХХТ-ийн үйлдвэрлэл

МХХТ-ийн техник хангамжийн үйлдвэрлэлийн салбар нь дэлхийн хамгийн том, хамгийн өсөлттэй зах зээл юм.⁴⁸ Өсөлтийн ихэнх хэсэг нь шинээр аж үйлдвэржиж буй орнууд оршин байгаа Ази тивд бий болж байна. МХХТ-ийн үйлдвэрлэлд голлох үүрэгтэй болсон анхны улсууд нь Хятадын араас Сингапур, Тайван, Малайз, мөн Филиппин, Индонез, хамгийн сүүлд тооцогдож байгаа Энэтхэг зэрэг юм. Ази тив МХХТ-ийн үйлдвэрлэлийн төв бүс болоод байна.

Хятадын МХХТ-ийн үйлдвэрлэлийн тэргүүлэгч байдлаар харагдах нь эргээд харахад ач холбогдолтой юм. “Хүчирхэг Засгийн газрын бодлогын дэмжлэг” нь Хятадын энэхүү амжилтыг авчирсан гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

48 Irene Schipper and Esther de Haan, CSR issues in ICT Hardware Manufacturing Sector: SOMO ICT Sector Report (Amsterdam: SOMO, 2005), 11, http://www.somo.nl/html/paginas/pdf/ICT_Sector_Report_2005_NL.pdf.



Үндэсний МХХТ-ийн аж үйлдвэрлэлийн стратегийн Кэйс судалгаа - 1 Хятад улс – Дэлхийн МХХТ-ийн үйлдвэрлэлийн төв

Хятад улс дэлхийн МХХТ-ийн үйлдвэрлэлийн төв болсон. Мобайл төхөөрөмжийн зах зээл нь цахилгаан холбооны зах зээлийн талаас илүү хувийг эзэлдэг бөгөөд техник хангамжийн зах зээл нь Хятадын МТ-ийн үйлдвэрлэлийн 70 хувийг эзэлдэг. Хятадын компаниуд АНУ-ын МХХТ-ийн шилдэг компаниудын хувьд томоохон аюул болоод байна. Ялангуяа Хятадын Леново (Lenovo Group Limited) нь Ай би эм (IBM)-ийн персонал компьютерийн бизнесийг авснаас хойш энэ байдал эхэлсэн. Леново дэлхийн компьютерийн зах зээлд Дэлл (Dell) болон Hewlett Packard –ийн дараа гуравт ордог компани юм.

Энэхүү Хятад дахь жолоогүй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь анхандаа экспортыг хөдөлгөж, Хятадын цахилгаан холбооны аж үйлдвэрийн дотоодын зах зээл нь үнэндээ хүчирхэг экспортын нуруун дээр буурч байна. МХХТ-ийн экспорт нь Хятадын олон улсын худалдаанд чухал хэрэгцээтэй бөгөөд нийт экспортын 28,5 хувийг эзэлж байна. Компьютер болон цахилгаан холбооны төхөөрөмжүүд МХХТ-ийн экспортын 79 хувийг эзэлж байна. Гар утас нь Хятадын цахилгаан холбооны салбарын экспортын дан ганц хамгийн том бүрэлдэхүүн хэсэг нь болж байна.

Хятадын МТ-ийн програм хангамжийн зах зээл нь хөгжлийн шатандаа байгаа бөгөөд зах зээлд 90 гаруй хувь нь бүтээгдэхүүнийг хууль бусаар хэрэглэж байгаа юм.

Хятадын МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбарт нийт дотоодын хөрөнгө оруулалт нь маш их хэмжээгээр хийгддэг. Хятадын засгийн газар дотоодын хөрөнгө оруулалтын 30 хувийг энэ салбарт зориулдаг. Үйлдвэрлэлийн салбар нь нийт дотоодын хөрөнгө оруулалтын 21 гаруй хувийг нь эзэлдэг: ойролцоогоор энэ хөрөнгө оруулалтын 30 хувь нь програм хангамжийг сайжруулах чиглэлд ашиглагддаг. Цахилгаан холбооны салбар нь МТ-ийн тоног төхөөрөмж, системүүдэд томоохон хөрөнгө оруулагч болдог. Мобайл холбооны зах зээл нь 2005 онд хөрөнгө оруулалтын ихэнх хэсгийг авсан.

Засгийн газрын хүчирхэг бодлогын дэмжлэг

Хятадын засгийн газар өөрийн улсаа дэлхийд хамгийн том МХХТ-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэгч болгох хэд хэдэн бодлогуудыг хэрэгжүүлсэн.

Судалгаа шинжилгээний үйл ажиллагаанд гадны оролцоо оролцоонд татварын хөнгөлөлт болон зөвшөөрөл олгосон нь Хятадын МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбарт их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадсан юм. 10 дугаар таван жилийн (2001-2005) төлөвлөгөө нь судалгаа шинжилгээ, МТ-ийн салбарт цахим худалдааны шийдэл, LINUX дээр суурилсан аюулгүй байдлын програм хангамжуудын багцийн хөгжүүлэлтэн дээр үндэслэсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхийг онцолсон.



» 11 дүгээр таван жилийн төлөвлөгөө нь үндсэн програм хангамж, нэгдсэн систем, томоохон хэрэглээний програм хангамжийг хөгжүүлэх, дараа үеийн интернэтийн төслүүдийг бий болгох, мөн түүнчлэн дээд түвшний тооцоолол, терафлоп хурдтай компьютерийн систем, сүлжээн дээр суурилсан тооцооллын орчин, худалдааны зорилгоор бүтээгдсэн терафлоп хурдтай компьютерүүдийг хөгжүүлэх зэрэг салбарт технологийн үсрэлт хийх зэрэг дээр төвлөрдөг. Хятадын МТ-ийн аж үйлдвэрийн салбар нь аль хэдийнээ чөлөөт болсон буюу 2001 онд дэлхийн худалдааны байгууллагад элссэнээс хойш өрсөлдөөнт болсон юм. Хятад цахилгаан холбооны салбартаа гадны хөрөнгө оруулалт орж ирэх боломжийг нээж өгсөн. Цахилгаан холбооны зохицуулалтууд нь цахилгаан холбооны хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах цахилгаан холбооны зах зээлийг стандартчилах зорилготой юм. Засгийн газар нь гадаадын компаниудыг Хятадын компаниудтай хамтран ажиллах, дээд тал нь 49 хувийн хувьцаагаар үйлдвэрлэлээ явуулах боломжийг нээж өгсөн; нэмүү өртөгтэй мобайл үйлчилгээнд 50 хувийн хувьцаатайгаар үйлдвэрлэл явуулж болно гэж зөвшөөрсөн. Төрийн зохицуулалтыг халах нь гадаадын компаниуд зах зээлд нэвтрэх байдлыг хялбарчилж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх хандлагатай байна.

МХХТ-ийн худалдааг дэмжихийн тулд Хятадын засгийн газар бүх худалдааны тарифаас үйлдвэрлэлээ чөлөөлж, 50 гаруй өндөр түвшний технологийн худалдааны чөлөөт бүсийг байгуулсан. ЗӨАУХ-Хятадын худалдааны чөлөөт бүсийн хэсэг нь 2010 он гэхэд үйл ажиллагаа нь эхэлж, цахим-ЗӨАУХ-ны гэрээний дагуу гишүүн улсуудын хооронд мэдээлэл, технологийн чөлөөт урсгалыг дэмжих магадлалтай байна.

Хятадын засгийн газар бүх засгийн газрын байгууллагуудаа дотоодод үйлдвэрлэсэн МТ-ийн бүтээгдэхүүнийг хэрэглэхийг мөрдлөг болгосон. Энэ нь МХХТ-ийн дэд бүтцэд хийгдэх хөрөнгө оруулалтыг тогтмол байлгах төлөвлөгөө юм. Засгийн газар мөн хатуу чанга оюуны өмчийн эрхийн бодлогыг хэрэгжүүлж байна. Мөн энэ нь онлайн төрөл бүрийн засгийн газрын байгууллагуудад зориулсан хэрэглээг цахим засгийг ашиглан дэмжих зорилготой юм. Хятадын засгийн газар техникийн боловсролд хөрөнгө оруулж, дээд зэргийн ур чадвартай хөдөлмөрийн хүчийг бэлтгэх зорилгоор дээд боловсролын төвүүдийг байгуулж байна.

Эх сурвалж: Abridged from Frost and Sullivan, "Country Industry Forecast-VI," Businessworld, <http://www.businessworld.in/index.php/Country-Industry-Forecast-VI.html>.

Асуултууд



1. Хятадын МХХТ-ийн үйлдвэрлэлийн төв болгох засгийн газрын хөндлөнгийн оролцооны зорилго нь юу вэ?
2. Танай улсад Хятад улсын Засгийн газраас МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбарыг эрчимжүүлэхийн тулд баталсан бодлогын санаачлагууд хэрэгжих боломжтой юу?

49 E-Business Strategies, Inc., "Offshoring Statistics - Dollar Size, Job Loss, and Market Potential," <http://www.ebstrategy.com/Outsourcing/trends/statistics.htm>.

50 Plunkett Research, Ltd., "Outsourcing and Offshoring Overview," <http://www.plunkettresearch.com/Industries/OutsourcingOffshoring/OutsourcingOffshoringTrends/tabid/183/Default.aspx>.

Оффшоринг (Offshoring) болон глобал програм хангамжийн хөгжүүлэлт

Оффшоринг нь ажлын функцүүд гадаад орнуудад бага өртөгтэйгээр шилжиж байгаа чиг хандлага юм. Энэхүү чиг хандлага нь мэдээллийн хувьсгалаар хурдавчилж, ялангуяа өндөр хурдны өгөгдөл дамжууллын зардал хурдацтайгаар буурч байна. Forrester Research 2015 гэхэд 3,3 сая АНУ-ын ажил буюу ажлын хөлсний 136 тэрбум доллар хөрөнгө Хятад, Энэтхэг, Орос гэх мэт улсуудад шилжинэ гэсэн судалгааг гаргаад байна.⁴⁹

Аутсорсингийн (Outsourcing – дотоодын компаниар бус гадаадын компанийг хөлсөлж ажил гүйцэтгүүлэх) гурван зах зээл байна: (1) логик, нөөцлөлт, хуваарилалтын үйлчилгээ (2) мэдээллийн технологийн үйлчилгээ түүн дотроо програм хангамж бүтээх, компьютерын төвүүдийн удирдлага; (3) БПА-ийн салбар, жишээлбэл: дуудлагын төвүүд (call centres), санхүүгийн гүйлгээний боловсруулалт, болон хүний нөөцийн удирдлага.⁵⁰

Санхүүгийн үйлчилгээ нь оффшорыг ашигласан хамгийн анхны зүйлсүүдийн нэг нь юм. Дараах чиг хандлагууд энэ салбарт оффшорыг тодорхойлох зүйлсүүд юм:

- **Компаниуд нийлүүлэлтийн гинжин удирдлагад дөхөм болох үүднээс санхүү болон нягтлан бодох үйл ажиллагаануудаа оффшоринг хийж байна** – Транзакц боловсруулалтаа ялангуяа боловсруулалтын өртгөө нэмсэн санхүүгийн төлөвлөлт, шинжилгээг оффшориг хийхийн цаана, зарим компаниуд гадаад үйлдвэрлэгчдэдээ нягтлан бодох бүртгэлийн алдааг судлах төлөөлөгчтэй байна.
- **Газар зүй өөрчлөгдөж байна** – АНУ-д санхүү болон нягтлан бодох бүртгэлийн ажлаа оффшоринг хийх нь Энэтхэг болон бусад улсуудад хийхээс ялгаатай байна.
- **Хамтын ажиллагааны хэрэгслүүдийг ашиглах нь нэмэгдэж байна** – Автоматжуулалт болон технологид шинэ хамтын ажиллагааг ашиглах нь: Lotus тэмдэглэлийг ашиглах, Вэб чат, хэрэглэгч байгууллагууд болон нийлүүлэгчдийн хооронд хийсвэр цагаан самбар хамтын ажиллагаандаа ашиглах. Эдгээр гадаад сүлжээний техникуудийг ашиглаж эхэлснээр, гар аргаар болон аялаж зочлох үйл явцууд арилж байна.
- **Аутсорсингийн оролцогчид болон аутсорсингийн үйлчилгээний багц өсөж байна** – Хэдийгээр ялгаатай байдал байсаар байгаа ч ихэнх үйлдвэрлэгчид өөрсдийгөө нэг цэгийн дэлгүүр хэмээн нэрлэж байна.
- **Санхүүгийн гүйцэтгэгч байгууллага зовлонтой хичээл сурч байна: Та функц эсвэл үйл явцыг бүхэлд нь хасаж чадахгүй** – Компани болон тухайн компаний захиалгаар ажиллах компаний хоорондын тэнцвэржилтийг хангах нь сорилт болоод байна. Компаниуд өөрсдийн дэд бүтцийг дахин байгуулахыг хүсэхгүй байгаа үед, тэд хэр зэрэг дотооддоо чанар, үйлчилгээ, зардалдаа удаан тэсэх вэ?⁵¹

ГПХУ нь оффшорингийн нэг төрөл юм. Үүнийг тодорхойлохдоо “ижил цаг хугацааны хамтын ажиллагаагаар зохион байгуулалттай замаар үндэсний хил хязгаараар дамжин газар зүйн хувьд ялгаатай бүсийн байрлалд бие даан хийгдсэн програм хангамжийн ажил” гэж тодорхойлогдоно. Судалгаагаар “Fortune 500” компаний 40 хувь нь глобал програм хангамжийн үйлдвэрлэлийг хэрэглэдэг, 50 гаруй улс глобал програм хангамжийн үйлдвэрлэлд оролцож байна гэсэн байна. Ирландын програм хангамжийн зах зээлийн 80 хувь нь экспортлогдож байна.⁵²

Энэтхэг глобал програм хангамжийн үйлдвэрлэлийн төв болж байгааг дор авч үзье.

51 Kate O'Sullivan, “Top Five Trends in Offshoring,” *CFO.com*, 30 January 2008, <http://www.cfo.com/article.cfm/10607206>.

52 See Parastoo Mohagheghi, “Global Software Development: Issues, Solutions, Challenges” (trial lecture at the University of Science and Technology, Trondheim, Norway, 21 September 2004), 2, <http://www.idi.ntnu.no/grupper/su/publ/parastoo/gsd-presentation-slides.pdf>.



Үндэсний МХХТ-ийн аж үйлдвэрлэлийн стратегийн Кэйс судалгаа - 2 Энэтхэг – Глобал програм хангамжийн үйлдвэрлэлийн төв

Энэтхэгээс экспортлогдож байгаа програм хангамжийн өсөлт нь сүүлийн арван жилд жил бүр нийлмэл харьцаагаар 51 гаруй хувь болсон нь Энэтхэгийн бодлого боловсруулагчид өсөлтийн хөдөлгүүр, ажил эрхлэлт, гадаад валютын нөөцийн өсөлт, бусад ач холбогдолтой үр ашгуудыг харах хэрэгтэй болсон юм. Энэтхэгийн програм хангамжийн үйлдвэрүүд нь хурдацтайгаар өсөх боломжтой төдийгүй экспортоо их хэмжээгээр нэмэгдүүлснээр одоогоор аутсорсинг хийсэн програм хангамжийн үйлчилгээнүүдийн хувьд дэлхийн зах зээлийн тодорхой хувийг эзэмшиж байна.

Хэдийгээр 1980-аад оны дунд үе дэх олон улсын үйлдвэрлэлийн хөгжил Энэтхэгийг програм хангамжийн аутсорсингийн үндсэн төв болгоход тусласан ч, Энэтхэгийн хөгжил нь дотоодын хувь хүмүүсийн бизнес, оюун ухаан, нөөцөөр удирдагдсан юм. Их хэмжээний пүүсүүд зах зээлд орж ирсэн нь тэдний чадамжийг нэмэгдүүлж, үйл явцын чанарт олон улсын шилдэг туршлагауудад өөрсдийн үүргийг оруулах боломжийг нээж, тэдний бусад газар нутагт хүрэх боломжийг өргөтгөж, санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлчилгээг хүргэж буй үйл ажиллагааны салбарыг тэлсэн юм. Эхэндээ хэрэглэгчийн газарт ажлыг гүйцэтгэхийн тулд хүний нөөцийг гүйцэтгэгч нь бүрдүүлж байсан бол, програм хангамжийн хөгжил Энэтхэгт экспортлогчийн үндсэн гэр нь болох байдалд шилжиж байна. Мөн бүтээгдэхүүний нэмүү өртөг доогуур кодчилол болон програмчлалаас дээд түвшний зөвлөгөө болон багц програм хангамж руу шилжих шилжилт ажиглагдаж байна.

Үндэсний байр сууринаас харахад програм хангамж Энэтхэгийн ҮНБ-ний нэмэлт хувьцаанд тооцогдож, ДНБ-ны өсөлтийн ойролцоогоор 12 хувийг бүрдүүлсэн байна. Програм хангамж Энэтхэгийн экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээний 8-н хувийг бүрдүүлсэн байна. Зах зээл жил бүр 60-70 сая хүртэл дээд зэргийн авъяастай инженерүүдэд ажил нэмж байна. МТ ашигласан үйлчилгээнүүд болох офисийн үйл ажиллагаа, дуудлагын төвүүд, эмнэлгийн соронзон бичлэг зэрэг төслүүдийн хувьд авч үзвэл 2008 гэхэд 1 сая ажлын байрыг үүсгэсэн байна. Гэсэн хэдий ч, эдгээр ажлууд нь чөлөөтэй, бага ур чадвар шаарддаг юм. Тэд цалин хөлс нь их, амьдралын өртөг багатай газрууд руу шилжсээр байна.

Програм хангамжийн зах зээл нь хувиараа бизнес эрхлэх дотоодын нөөцийг өргөтгөх, мэдлэгт суурилсан аж үйлдвэрлэлд тухайн улсад брендийн эзэмшлийг үүсгэхэд туслаж байна. Түүний хөгжил нь энэтхэгт мэргэжилтнүүдэд ашигтай ажлын боломжуудыг олгосноор 1990 онд тархины хоосролыг буцаахад тусласан.

Тухайн улсад энэхүү зах зээлийг татсан үндсэн эх булаг нь сүүлийн хэдэн арван жилд хүний нөөцийн хөгжилд оруулсан хөрөнгө оруулалтаар үүссэн сургагдсан боловсон хүчний бүлэг юм.

Хожим засгийн газар мэдээллийн технологийн паркуудад байгуулагдсан дэд бүтцэд өндөр хурдны өгөгдөл дамжуулах холбоосуудыг олгосноор аж үйлдвэрийн хөгжлийг дэмжсэн юм. Зарим санаачлагууд засгийн газраар хэрэгжүүлэгдэж, аж үйлдвэр нь эргээд улсад олон улсын хөдөлмөрийн хүчний хуваарьт өөрийн орон зайгаа нэмэгдүүлэх сорилттой тулгарсан юм. Эдгээр нь боловсролтой боловсон хүчин болон бусад дэмжлэг үзүүлэх хэрэгслүүдийн нийлүүлэлтийг өсгөх арга хэмжээнүүдийг агуулдаг.



» Үйлдвэрүүд өөрсдөө оюун ухааныг олж авах, сайжруулах, авч үлдэх стратегиудыг баримталснаар эдгээр үүсэж буй сорилтуудад хариу үзүүлсэн. Хүний нөөцийн удирдлага Энэтхэгийн програм хангамжийн салбарт үйлдвэрийн стратегийн түлхүүр хүчин зүйл нь болж байгаа илэрхий нотолгоо харагдаж байна. Компаниуд оффшори хөгжүүлэлтрүү чиглэх, үйл ажиллагааны салбарын мэргэжлийн ур чадвар, дээд түвшний зөвлөгөө, өмчийн багцууд, өртгийг үнэлэх стратегиуд төвлөрөн нийлүүлэлтийн гинжин удирдлагыг хурдасгахаар оролдож байна.

Сүүлийн хэдэн арван жилийн Энэтхэгийн аж үйлдвэрийн хүчирхэг гүйцэтгэлийг үл хамааран сүүлийн үед түрэн орж ирж байгаа улсууд болох Хятад, Филиппин болон бусад улсуудад өрсөлдөөний талаас нь авч үзэхэд бардам байдалд ямар ч орон зай байхгүй. Энэтхэгийн програм хангамжийн үйлдвэрүүд үйл явцын боловсруулалтанд олон улсын стандартуудад хүрэх хэлбэрээр тэргүүлж эхэлсэн үед, өрсөлдөөн богино болон дунд хугацаанд доогуур нэмүү өртөгтэй үйлчилгээнүүд болох кодчиллол, уламжлалт програм хангамж, МТ-ашигласан үйлчилгээнүүдийн хувьд хатгаж эхэлнэ. Тиймээс Энэтхэгийн аж үйлдвэр өөрийн хүчин чадлаа бэхжүүлж, өөрсдийн бусад өрсөлдөгчдөөс тэргүүлж эхэлсэн давуу талаараа нийлүүлэлтийн гинжин удирдлагын үйл ажиллагааг хурдасгаж, өөрсдийгөө програм хангамжийн бүтээгдэхүүний тэргүүлэгч нөөц болгох шаардлагатай юм. Гэсэн хэдий ч бүтээгдэхүүний зах зээлд дээд зэргийн саадууд шинээр зах зээлд нэвтрэхэд хүндрэл учруулж байна. Энэ тохиолдолд дараах арга хэмжээнүүд үр дүнтэй болно:

- Судалгаа шинжилгээ болон бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд анхаарал хандуулах
- Глобал зах зээлийн суваг болон брэндүүдийг стратегийн зарчмаар олж авах
- Аж үйлдвэрийг дахин бүтэцчилэх, батжуулах
- Засгийн газрын дэмжлэг тусалцааны арга хэмжээнүүдийг дахин чиглүүлэх

Энэтхэгийн Засгийн газар 1960 оноос хойш мэргэшсэн хүний нөөцийг хөгжүүлэх, тооцоолол болон сүлжээний судалгаанд институтын дэд бүтцийг байгуулахад чухал санаачлагуудыг хэрэгжүүлснээр аж үйлдвэрийн хувьсгалд чухал үүргийг гүйцэтгэсэн юм. Засгийн газар зах зээлд Мэдээллийн технологийн паркууд болон бусад барилга байгууламжуудыг барьж байгуулснаар дэд бүтцийг хөгжүүлэхэд тусалцаа үзүүлсэн. Дээр нь програм хангамжийн экспортлогчид програм хангамжийн экспортоосоо ашигт зориулж орлогын татварын хөнгөлөлт авдаг байсан. Гэхдээ эдгээр татварын хөшүүргүүдийн хамаарлыг бодолцох шаардлагатай юм. Аж үйлдвэрийн зах зээлд Энэтхэг байгалиас заяасан харьцуулахуйц давуу талууд (бага зардалтай хүний нөөц) болох экспортууд жил бүр 50 гаруй хувиар өсөж байна, ашгийн хэмжээ орлогын 22 хувьд (улсын ямар нэгэн аж үйлдвэрээс хамаагүй илүү) нь байгаа нь эдгээр татваруудыг үгүй хийх нь тогтвортой төлөв дэх хамааралтай байдлыг харуулахгүй байгаа юм шиг байна.

Эх сурвалж: Adapted from Nagesh Kumar, Indian Software Industry Development in International and National Development Perspective (RIS-Discussion Paper # 19/2001), http://www.ris.org.in/dp19_pap.pdf.



Асуултууд

- Энэтхэгийн програм хангамжийн аж үйлдвэрийг хөгжүүлэх загвар нь танай орны нөхцөлд хамаарах уу?
- Энэтхэгийн жишээн дээр дурдагсан амжилтуудын аль нь танай орны хувьд байна вэ? Яагаад аль нь ч биш гэж?
- Эдгээр амжилтанд хүрэхэд ямар саад бэрхшээл тулгарч болох вэ?

Тоон контентын аж үйлдвэрийн салбар

Тоон контентын зах зээл нь эдийн засгийн үйл ажиллагааны нэг салбар бөгөөд уламжлалт агуулга, медиа, үзвэр, програм хангамж болон мултимедиа, электрон техник хангамж болон цахилгаан холбооны нэгдэл юм. Тоон контентын аж үйлдвэрийн салбар нь тоон бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн суурь нь болж байгаа технологиудыг үүсгэх, зохиомжлох, удирдах, тараах зэргээс бүрдэнэ. Тусгай салбаруудад визуал эффектүүд, болон хөдөлгөөнт дүрслэл, интерактив мултимедиа, компьютер болон онлайн тоглоомууд, боловсролын мултимедиа, цахим кино, ТВ үйлдвэрлэл, кино болон ТВ пост-үйлдвэрлэл зэрэг орно.

Тоон контентын зах зээл хурдацтай хөгжиж байна. Компьютер тоглоомуудын орлого 2001 онд киноны тасалбарын борлуулалтаас давсан, дэлхий дахинд буй орлогоороо бичигдсэн хөгжмийн зах зээлтэй ойролцоо байна.⁵³ МХХТ-ийн зөвлөгөө өгдөг пүүс болох PricewaterhouseCoopers (PwC) глобал тоглоомын зах зээл 2010 онд 46,5 тэрбум доллараар өснө гэсэн урьдчилсан судалгааг гаргажээ⁵⁴. Ялангуяа PwC төслүүд АНДБ тоглоомонд зарцуулах нийт зардлаараа тэргүүлэх байр суурьтай байна, 2005 онд 9,8 тэрбум доллар байсан бол 2010 он гэхэд 17,4 тэрбум доллар болж өснө гэсэн байна. Энэ нь өсөж буй өргөн зурвасын хандалт, өсөж буй компьютерийн мэдлэг, Засгийн газрын дотоодын тоглоомын зах зээл болон хэрэглээг дэмжиж байгаатай холбоотой юм.

Азийн компаниудын төвлөрч байгаа агуулгын хөгжлийн салбар нь тоон мобайл контент байна. Энэ нь мобайл мэдээ, мобайл зам тээврийн мэдээлэл, мобайл санхүүгийн мэдээллийн үйлчилгээ, мобайл тоглоомууд, мобайл хөгжим, дуу, дүрс татах, мобайл том хүний үзвэр, болон мобайл лавлахууд багтаж байгаа юм.

БНСУ болон Ирланд тоон контентын аж үйлдвэрийн зах зээлийг хөгжүүлэхэд идэвхитэй оролцож байгаа улсууд юм.

53 Donald J. Johnston, "The importance and role of digital content: Encouraging production and enhancing access" (presented at the Conference on The Future Digital Economy: Digital Content – Creation, Distribution and Access, Rome, Italy, 30-31 January 2006), 5, <http://www.oecd.org/dataoecd/16/47/36138740.pdf>.

54 Lora Kolodny, "Global Video Game Market Set to Explode," BusinessWeek, 23 June 2006, http://www.businessweek.com/innovate/content/jun2006/id20060623_163211.htm.



Үндэсний МХХТ-ийн аж үйлдвэрлэлийн стратегийн Кэйс судалгаа - 3 БНСУ – Хагас дамжуулагчаас мултимедиа хүртэл

Түүхийн хувьд авч үзвэл, БНСУ-ын семикондакторын аж үйлдвэрлэлийн хамгийн том давуу тал нь ДШХСО чипүүдийг (DRAM-Dynamic Random Access Memory chip) экспортын зорилгоор үйлдвэрлэх боломжтой байсан юм. 1983 онд эхэлснээс хойш, БНСУ-ын ихэнх томоохон корпорацууд – Самсунг (Samsung), Хуйндай (Hyundai), Эйлжи (LG) нар 1995 онд ДШХСО-н дэлхийн зах зээлд зэрэглэлээрээ нэгдүгээрт, дөрөвдүгээрт, долоодугаарт бичигдэж байсан. Зах зээлийн тэргүүлэгч Самсунгийн ДШХСО-оос өөрийн ашгийнхаа 90 хувийг бүрдүүлж байсан – 1996 онд ДШХСО-н зах зээл унахад Samsung-ын ашиг 93,4 хувиар буурч байсан нь аюултай нөлөөлөл байсан нь харагдаж байна. Хуйндай болон Эйлжи 1995 онд өөрсдийн ашгийнхаа 90 орчим хувийг алдаж байсан түүхтэй. Санах ойн чипний Самсунгийн амжилт нь яг зөв цагтаа зах зээлд орох эсэхээ шийдэх (АНУ болон Япон 1986 онд хагас дамжуулагчийн гэрээг үзэглэсэн) болон төрийн зорилгоос илүүтэйгээр амжилттай байсан юм. Учир нь Самсунг болон БНСУ-ын төрийн хоорондын давтагдашгүй харилцан хамаарлыг авч үзэх ёстой бөгөөд хагас дамжуулагчийн шинэ санаачлагын замын тусгай арга хэлбэрийг үүнд хамруулах хэрэгтэй. Компаниуд өөрсдийн бусад үйл ажиллагаануудаар (Жишээлбэл: ялангуяа Самсунгийн цахилгаан холбооны төхөөрөмж) олдог ашгийнхаа талаар ДШХСО-н зах зээлд нэвтрэх боломжтой байсан төдийгүй төрийн татаас чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ нь “улс төрийн харилцан хоёр талын татаас” гэж харагдаж хямд капитал солилцоход Самсунг дээд зэргийн экспортын үүрэг гүйцэтгэгч болно гэж амласанд байгаа юм. ДШХСО-нууд нь жижигрүүлэх дараалсан алхмуудтай холбоотой тодорхой тодорхойлсон замуудад хэрэглэгдэх үйл явцын шинэчлэлд БНСУ-д давуу байдлыг бий болгох тохиромжтой технологи нь байсан. Гүйцэж түрүүлэх зам нь тодорхой тодорхойлогдсон нь АНУ болон Япон дахь компаниудтай адил байсан юм. Элементүүд хоёулаа бид Самсунгийн засаглал гэж дуудаж болон загварт хамгийн тохиромжтойгоор нийцсэн нь ихэнх томоохон корпорацуудыг эрчимтэй жижиг болон дунд үйлдвэрлэлийн салбарийн хөгжлийн зардалд хамгийн түрүүнд урьтамж болгосон.

Бүх дөрвөн томоохон корпорацууд (Самсунг, Хуйндай, Эйлжи дээр нь нэмээд Даевүү (Daewoo)) мултимедиаг өөрсдийн электроникийн стратегидаа нэн тэргүүнд чухалчилж үзсэн. Гэхдээ мултимедагийн шинэчлэлийн арга зам нь эдгээр томоохон корпорацуудын туулсан замаас эрс ялгаатай юм. Нарийн үйлдвэрлэлд суурилсан шулуун замаас ялгаатайгаар мултимедиа нь тоон нэгдэн нийлэлтийн үйл явцуудаар ил болсон тодорхойгүй байдлуудаар тодорхойлогддог. Энэ нь төрөл бүрийн хувь хүмүүсийн салбарууд болох холбоо, тооцоолол, үзвэр, нийтлэл зэргээс нийлүүлэлтийн гинжин удирдлагын оролтуудыг элсүүлдэг.

Сүлжээжсэн мултимедиа нь дараах гол элементүүдэд хуваагддаг:

- Контент үүсгэх, багцлах, бас одоогийн байгаа форматуудыг цахимжуулах
- Тээвэрлэлт, сүлжээ(networking) болон салгах (switch) дэд бүтэц
- Хандалт, кодыг тайлах, шифрлэх, харилцагчийн удирдлага, төлбөр тооцоо
- Хэрэглэгчийн интерфэйс болон хэрэглүүрүүд (броуз хийх, програм хангамжийн хэрэгслүүдийг жолоодох)
- Хүргэлтийн орчин, түүн дотроо set-top нэмэлт мэдээлэл, цахим телевиз (TV-television), ширээний компьютер, сүлжээний компьютер



» Сүлжээжсэн мултимедиа нь техник хангамж, төрөл бүрийн програм хангамжийн эрэгслүүд, түүн дотроо хөтөлбөрийн материалууд, үйл ажиллагааны болон солих програм хангамжууд мөн интерфэйс болон өгөгдлийн сангийн бүтээгдэхүүнүүдийг шаарддаг. Шинэ үеийн бүтээгдэхүүнүүдэд санах ойн чипүүд шаардлагатай байгаа нь энэ нь цаашдаа арилах магадлалтай байгаа ч, ихэнх үнэ цэнэ нь тусгай хэрэглээний нэгдсэн гүйдэл ялангуяа мултимедиа дохио боловсруулах чипрүү шилжиж байгаа нь шинэчлэл үйлдвэрлэлийн үйл явц дээр гэхээсээ илүүтэйгээр зохиомж дээр нь төвлөрч байгааг харуулж байна. Гэхдээ ДШХСО-ын туршлага нь технологүүдыг дэлгэцийн чиглэлд эргүүлсэн бөгөөд бид Солонгосын пүүсүүдийг Thin Film Transistor дэлгэцүүдийн өсөж буй хэрэгцээг хангахад хамгийн тэргүүлэгч байж чадна гэдэгт найдаж байна. Дээр нь стандартчиглагдсан хэрэглэгчийн электрон бүтээгдэхүүнд – TV, VCR, CD- Солонгосын аж үйлдвэрийн зах зээлийн давуу талууд нь set-top box, сүлжээний компьютерүүд, бусад эцсийн терминалуудыг үйлдвэрлэхэд амархан байх болно. Програм хангамж болон сүлжээний технологүүд дахь сул талууд нь Солонгосын компаниудыг нийлүүлэлтийн гинжин удирдлагыг явуулах, хүргэлтийн орчны зах зээл нь ялангуяа доогуур үнэтэй бүтээгдэхүүн нийлүүлдэг Хятадын хувьд өрсөлдөөнт эмзэг байдал бий болгох магадлалтай юм.

Дүгнэж хэлэхэд бид их хэмжээгээр хадгалдаг хагас дамжуулагчдад тэргүүлэх чиглэлд амжилттай түлхэц хийсэн нь Солонгосын компаниудын хувьд давуу тал бий болгож, Засгийн газрын дэмжлэгийн хүрээнд урьдчилсан технологийн замчлалаа байгуулж чадсаныг харж байна. 1980 оны дунд үеэс эхэлсэн шижигнэсэн жилүүдэд нилээн их хэмжээний ашиг олсон нь томоохон корпорацуудыг урт хугацаанд дэлхий дахинд голлох тоглогч болгоход тусласан юм. Компаниуд одоогийн ДШХСО-н зах зээлийн уналтаас өмнө шинэ бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх стратегиа урьдчилан боловсруулсан ба аж үйлдвэрийн төрх байдал тоон нэгдэн нийлэлтийн үйл явцт орж байгаа тэрхүү шилжилтийг олж харсан юм. Компаниудын одоогийн давуу талууд нь үндсэн техник хангамж, тоон хүргэлтийн орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд төвлөрч байна. Энэ нь ирээдүйд чухал орлогын эх үүсвэрийг авчрах төдийгүй, компаниуд програм хангамж болон зохиомжинд өрсөлдөж эхлэх шаардлагатайгаа таньж мэдсэн юм.

Гэхдээ энд Солонгосын аж үйлдвэрийн дээд зэргээр төвлөрсөн жижиг шинэ компаниудын дутагдал нь бэрхшээл болж байгаа бөгөөд олонх нь үйл ажиллагааныхаа цар хүрээг АНУ-д тэлж байна. Юу үлдсэн бэ гэдгийг харахад амжилттай эдгээр компаниуд нь гүйцэж түрүүлэх шатандаа өөрсдийн туршлагаасаа шал ондоогоор шинэчлэлийн үйл ажиллагаануудын цогц сүлжээг удирдаж чадсан.

Эх сурвалж: Abridged from Alan Cawson and S. Ran Kim, "The Korean Electronics Industry — From Semiconductors to Multimedia," InfoWin Bulletin, 1997, <http://cordis.europa.eu/infowin/acts/ienm/bulletin/06-1997/korea.htm>.



Асуултууд

- БНСУ-ын хувьд тодруулсанчлан хагас дамжуулагчийн аж үйлдвэрийн зах зээл болон мултимедиагийн аж үйлдвэрийн зах зээлд амжилтын нөхцөл байдал хэрхэн ялгаатай байна вэ?
- Ялгаа нь юунд оршиж байна вэ?



Үндэсний МХХТ-ийн аж үйлдвэрлэлийн стратегийн Кэйс судалгаа - 4

Ирландын тоон контентын аж үйлдвэрийн зах зээлийн стратегиуд

Тоон контентын зах зээлд өндөр хөгжилтэй салбарын тоо ихтэй улс бол Ирланд улс юм. Эдгээр боломжуудыг хөшүүрэг болгосон амжилт нь маш олон чухал хүчин зүйлүүд дээр тогтдог. Эдгээр нь:

- Хөгжлийн агентлагууд болон Засгийн газраас хийсэн санаачлагатай, зорилттой хөгжил
- Мэргэжил болон зах зээлийн хөгжилд хурдасгуур болон үйлчлэх тусгай төслүүд/санаачлагуудыг засгийн газраас дэмжих
- Мэргэжлийн ур чадвар шаардлагатай байгаа газруудад боловсролын болон сургалтын байгууламжуудыг байгуулах
- Ирландын холбооны дэд бүтэц болон судалгаа шинжилгээний тогтвортой хөгжил
- Тоон контентын үйлдвэрүүдийн санхүү/ санхүүжилтад хандах
- “Мэргэжлийн тоон контентын” бизнесийн орчныг байнга дэмжих

Тусгай зөвлөмж

Санхүү болон санхүүжилт

- Хэрвээ тоон контентын үйлдвэрлэлийг дэмжих мэргэжлийн мэдлэг, туршлагатай ач холбогдол бүхий олон улсын шинэ үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалттай компани Ирланд улсад татагдах боломжийг судлах (Байгууллага Ирланд, IDA Ирланд)
- 2002 онд биотехнологийн салбарт оруулсан санхүүжилттэй адилаар тоон контентын аж үйлдвэрийн зах зээлд мэргэжлийн шинэ үйлдвэрт зориулсан хөрөнгө оруулалтын санхүүжилтыг бий болгох (Байгууллага Ирланд, IDA Ирланд, DETE)

Судалгаа, хөгжүүлэлт

- Тоон контентыг үүсгэх, зохиомжлоход судалгаа, хөгжүүлэлтийн мэргэжилтнүүдийг дэмжихийн тулд урлаг болон бүтээлч сэтгэлгээний мэргэжил эзэмшүүлдэг коллежуудыг дэмжих хөтөлбөрүүдийг танилцуулах (Байгууллага Ирланд, DETE, Ирландын шинжлэх ухаан, технологи, шинэчлэлийн зөвлөл)
- Контент хөгжүүлэлтийн төслүүдийг дэмжих Судалгаа, Технологи, Шинэчлэлийн санхүүжилтанд хандах шалгуур үзүүлэлтүүдийг дахин нягтлан үзэх (Байгууллага Ирланд, IDA Ирланд)

Хууль зохицуулалтын орчин

- Маркетингийн/боловсролын хөтөлбөр нь тоон контентын SME-ээр IP бүртгэлийг дэмжих зорилгоор боловсруулагдсан байх ёстой (Байгууллага Ирланд, IDA Ирланд)
- Нууц мэдээллийг хулгайлах хуулийг зөвлөмж болгосноор тоон контентын IP-д олгогдож байгаа хуулийн хамгаалалтыг нэмэгдүүлэх (Хууль зүйн яам)

Санхүүгийн орчин

- Бусад европын орнуудтай адил нэг шугаманд Ирландын нэмүү өртгийн татварын хэмжээг бууруурах (Сангийн яам, Орлогын комиссар)

Дэд бүтэц

- Голлохоролцогчдод зориулж үрдүнтэй олон улсын солилцоог байгуулахад хамтын ажиллагааг дэмжих чухал шаардлага байна (Холбооны операторууд, Бие даасан үйлчилгээ үзүүлэгчид, IDA Ирланд) »



Боловсрол болон мэргэжлийн ур чадвар

- Хөгжлийн төлөө чиглэсэн голлох салбаруудын мэргэжлийн ур чадварын нийлүүлэлт, эрэлтийн нарийвчилсан аудитыг хийх
- Оюутнуудад зориулсан олон улсын тэргүүлэх тоон контентын коллежууд болон олон улсын өрсөлдөхүйц сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдахын тулд тэтгэлэг олголтыг дэмжих

Байгууллагын хөгжил

- Forfas-аар дэмжигдсэн Бизнес, Худалдаа, Ажил эрхлэлтийн яам тусгай байрын салбарын стратегиудын хөгжүүлэлтийг чиглүүлэх, уялдуулан зохицуулах, энэ тайлан дахь үйл ажиллагаануудын хэрэгжүүлэлтийг гүйцэтгэх аж үйлдвэрийн салбарын хөгжлийн байгууллагууд болон холбогдох засгийн газрын байгууллагуудыг багтаасан тоон контентын удирдах комиссыг байгуулах
- Тоон контент дахь дээд зэргийн чанарын төвүүдтэй үр дүнтэй холбоосыг байгуулах стратегиуд нь олон улсын зарчмаар боловсруулагдаж, мөрдөгдсөн байх ёстой.
- Тоон төв нь Ирланд болон олон улсад корпорацийн зах зээлд тоон контент/медиа-гийн үр ашиг болон чадамжуудыг зах зээлд нийлүүлэхийн тулд тоон контентод зориулж “үзүүлэн” хэлбэрээр хөгжүүлэгдэх ёстой (Цахим медиа хөгжүүлэлт, Байгууллага Ирланд, IDA Ирланд)

Нийтийн салбарын төслүүд

- Нийтийн салбар нь Ирланд улсад тоон контентын технологиуд болон үйлчилгээнүүдэд зориулсан зах зээлийг үүсгэхэд тэргүүлэх үүрэгт байх ёстой бөгөөд үүнийгээ үзүүлэх төслүүд хэлбэрээр үйлчлэх “цахим номын сан”-ын даалгавраар болон тоон контентын үр ашгийг ухамсарлах байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр байна (Урлаг, Спорт, Аялал жуулчлалын яам).
- Одоогийн байгаа тоон контентын компаниуд болох өргөн нэвтрүүлгийн, медиа, нийтлэлийн аж үйлдвэрүүд, ялангуяа төрийн эзэмшлийн компаниудыг тоон контентыг үүсгэх, удирдах, өөрсдийн контентыг хувиарлах байдлыг дэмжих (Холбооны яам).

Эх сурвалж: Abridged from Forfas, A Strategy for the Digital Content Industry of Ireland (2005), http://www.forfas.ie/publications/digitalcontent02/021105_digital_content_report_s.pdf.



Асуултууд

- Ирландын тоон контентын аж үйлдвэрийн амжилтын онц чухал хүчин зүйлүүдтэй адилаар та өөрийн улсдаа эдгээр амжилтын хүчин зүйлүүдийг ашиглах уу? Яагаад эсвэл яагаад үгүй?
- Эдгээр амжилтын хүчин зүйлүүдийн аль нь танай нөхцөлд хамгийн чухал вэ?



Дасгал

- МХХТ-ийн аж үйлдвэрлэлийн салбаруудад зэрэглэл тогтоох,
- Танай засгийн газар хөгжүүлэх ёстой МХХТ-ийн гурван дэд салбарт зэрэглэл тогтоох (үйлдвэрлэл, оффшоринг/глобал програм хангамжийн хөгжил, контентын зах зээл). Өөрийн жагсаалтыг гарга.

Нэг улсаас ирсэн оролцогчдыг нэг бүлэг болгон энэ дасгалыг гүйцэтгүүл.

2.3. ЦАХИМ ЗАСАГЛАЛ

Цахим засаглал нь МХХТ-г нийгмийн “чухал ач холбогдолтой удирдах функцээр” ашиглах гэдгээр тодорхойлогддог. Түүндотроо уялдаа холбоо, арбитр, сүлжээ, зохицуулалт зэргийг агуулна.⁵⁵ Илүү нарийвчилсан тодорхойлолт нь: цахим засаглал гэдэг нь захиргааны үйл ажиллагааны салбарт (төрийн үйлчилгээг хүргэх, зохицуулалт, хууль сахиулах, аюулгүй байдал, хүнд суртлыг арилгах, бодлого боловсруулалтыг сайжруулах), улс төрийн үйл ажиллагааны салбарт (хэрхэн нийгэм шийдвэр гаргаж байгаатай хамааралтай төрөл бүрийн ажиллагаа болон гишүүдийг нэгтгэж байгаа үнэ цэнийг байгуулах) орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, дэлхий нийтийн түвшинд хэрэглэхийг хэлнэ.

Засаглалын төлөвийг хэрэглэх нь төрийн бодлого боловсруулахтай холбоотой нэг хэвийн харилцан хамаарлыг онцолдог төдийгүй засаглахад нийгмийн харилцан хамаарлыг мөн онцолдог. Цахим засаглал нь төрийн үйлчилгээг сайнаар хүргэхэд МХХТ-ийн хэрэглээг нарийн өнцгөөс харахаас шийдвэр гаргахад иргэд оролцох МХХТ-ийн хэрэглээг илүү өргөн хүрээгээр авч үзэх чиг хандлагатай байна.

Гэсэн хэдий ч цахим засаг эсвэл төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд МХХТ-ийг хэрэглэхийг авч үзэх нь чухал байсаар л байна.⁵⁶ ХМХХТ-ийн бодлого боловсруулагчид цахим засагт сонирхолтой байдаг учир нь Засгийн газрын МХХТ-ийн гаргаж буй зарлага нь дотоодын МХХТ-ийн аж үйлдвэрийн зах зээлийн нийт хөгжилд нөлөөлж чадах ба мөн цахим засаг нь сайн засаглалыг амладаг учраас юм.

Ихэнх улсуудад, засгийн газар нь МХХТ-ийн бараа үйлчилгээний хамгийн том дан ганц хэрэглэгч нь байдаг. Хөгжингүй орнуудад, Засгийн газрууд нь ерөнхийдөө төрийн мэдээллийн технологийн системүүдэд ДНБ-ны 1-1,5 хувийг зарцуулдаг⁵⁷. Глобал судалгаа, зөвлөгөөний компани болох Government Insights-аар “Баруун өрнөдийн европын засгийн газарт зориулагдсан нийт МТ-ийн зарлага нь 2006 онд 43 тэрбум доллар байсан бол 2011 онд 56 тэрбум доллар болж өснө гэсэн байна.” Багц програм хангамж дунджаар 7 хувиар өсөж байгаа хамгийн өсөлттэй байгаа энэ үед мэдээллийн технологийн үйлчилгээний зарлага нь Засгийн газрын мэдээллийн технологийн зарлагын хамгийн их хувийг эзэлж байна⁵⁸. АНДБ-д Засгийн газрууд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлчилгээндээ 2007-2011 онуудад тогтмол 7,9 хувийн жил бүрийн өсөлттэй зарцуулалтыг хийсээр байна.⁵⁹ Техник хангамж дээр их хэмжээгээр мөнгө зарж байгаа нь нийт зардлын техник хангамжийн хувьцаанд 2007 онд 57,5 хувиас 2011 онд 54 хувь болж буурах бага зэргийн бууралт бий болно. Өөрөөр хэлбэл, үйлчилгээ, түүн дотроо програм хангамж дээр зардал нь эдгээр цаг хугацааны мөчлөгт бага багаар өсөх магадлалтай байна.⁶⁰

55 Gianluca C. Misuraca, e-Governance in Africa: From Theory to Action: A Handbook for ICTs for Local Governance (Ottawa: IDRC, 2007), http://www.idrc.ca/en/ev-113398-201-1-DO_TOPIC.html.

56 Richard Heeks, “eGovernment for Development: Success and Failure in eGovernment Projects - What is eGovernment?” Institute for Development Policy and Management, University of Manchester, <http://www.egov4dev.org/egovdefn.htm>.

57 Patrick Dunleavy, Helen Margetts, Simon Bastow and Jane Tinkler, Digital Era Governance: IT Corporations, the State, and e-Government (Oxford: Oxford University Press, 2006), 1.

58 Government Insights, “Press Release: Government Insights Predicts IT Spending in the Western European Government Sector Will Grow from \$43 B in 2006 to \$56 B in 2011,” <http://www.government-insights.com/GI/getdoc.jsp?containerId=prIT20785507>.

59 Government Insights, “Press Release: Government Insights Predicts APEJ Public Sector Market IT Expenditure Will Increase 7.9% CAGR,” <http://www.government-insights.com/GI/getdoc.jsp?containerId=prSG20779307>. Japan is not included in this estimate.

60 Ibid.

Төлбөргүй, нээлттэй эхийн програм хангамж

Олон Засгийн газрууд эхэндээ ҮБНЭПХ-д татагдсан байсан учир нь тэдний хэрэглээний програм хангамжийг авах зардлыг багасгах байсанд юм. Гэхдээ FOSS (төлбөр төлдөггүй эсвэл нэг удаагийн төлбөртэй) нь үнэгүй биш програм хангамж юм. Энэ нь эх код нь нээлттэй, өргөтгөж болох, үнэгүй тараах боломжтой програм хангамж юм. Түүний дэмжигчид нь түүний нээлттэй төлөв нь хурдтай, илүү үр дүнтэй нягтлал хийх, тэвчлэх боломж олгосноор түүнийг илүү тогтвортой, найвартай програм хангамж болгож байгаа юм. FOSS-ийн талаар илүү их мэдээллийг авахыг хүсвэл Модуль 4-г үз.

Хөгжиж буй орнуудын хувьд FOSS-ийг сонгох стратегийн, эдийн засгийн, нийгмийн ашиг байгаа юм.

Стратегийн үр ашиг

- Дотоодын чадавхи/аж үйлдвэрийг хөгжүүлэх
- Импортын гадаад валютыг бууруулах
- Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх
- Зохиогчийн эрхийн зөрчлүүдийг багасгах
- Нутагжуулалтыг нээж өгөх

Эдийн засгийн үр ашиг

- Өрсөлдөөнийг нэмэгдүүлэх
- Эзэмшлийн нийт зардлыг багасгах
- Аюулгүй байдлыг бэхжүүлэх
- Үйлдвэрлэгчийн бие даасан байдлыг хангах

Нийгмийн үр ашиг

- Мэдээлэлд хандах хандалтыг нэмэгдүүлэх⁶¹

Зүүн Өмнөд Азид, Камбожи, Индонез, Малайз, Вьетнам FOSS дээр Засгийн газрын бодлоготой байдаг.⁶² Сингапур бүх салбаруудын хувьд Засгийн газрын нээлттэй эхийн бодлого байхгүй. Тайланд Засгийн газрын байгууллагууддаа LINUX-ыг хэрэглэхийг зөвшөөрсөн байдаг. Төгсгөлийн цэгээс харахад, Филиппин нээлттэй эхийн бодлого байхгүй. Гэхдээ ЗӨАУХ-ны эдгээр бүх улсууд маш олон сургалтын хөтөлбөрүүд болон програм хангамжийн төслүүдтэй нь илүү хүчирхэг FOSS сонголтонд түлхэц болох орчныг байгуулахад маш чухал юм.

Малайз сонирхолтой нээлттэй эхийн бодлогын загвартай.

61 Kenneth Wong, *Free/Open Source Software: Government Policy* (Bangkok: UNDP-APDIP e-Primers on Free/Open Source Software, 2004), <http://www.iosn.net/publications/foss-primers/government/foss-government-primer>.

62 Joshua L Mindel, Lik Mui and Sameer Verma, "Open Source Software Adoption in ASEAN Member Countries," in *Proceedings of the 40th Hawaii International Conference on System Sciences* (Washington, D.C.: IEEE Computer Society, 2007), <http://csdl2.computer.org/comp/proceedings/hicss/2007/2755/00/27550226b.pdf>. Subsequent information on free and open source software in ASEAN is taken from this article.



Малайзын нээлттэй эхийн програм хангамжийн мастер төлөвлөгөө

Малайзын Засгийн газар Нээлттэй эхийн програм хангамжийн хөгжил, хэрэгжилтийг дэмжихээр шийдэж, Малайзын Захиргааны Дэвшил болон Удирдлагын Төлөвлөгөөны алба төрийн албанд эдгээр санаачлагуудыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг авсан.

Зорилтууд

- Эзэмших эрхийн нийт зардлыг бууруулах
- Програм хангамжийн хэрэглээний сонголтын эрх чөлөөг нэмэгдүүлэх
- Системүүдийн хоорондын харилцан холбоог сайжруулах
- МХХТ-ийн аж үйлдвэрийн салбарын өсөлтийг нэмэгдүүлэх
- Нээлттэй эхийн програм хангамжийн аж үйлдвэрийн зах зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх
- Нээлттэй эхийн програм хангамжийн хэрэглэгч болон хөгжүүлэгчдийн бүлгийн өсөлтийг нэмэгдүүлэх
- Тоон хуваагдлыг арилгах

Үндсэн зарчмууд

- Зорилгод нийцэх
- Үйл ажиллагаанд хамгийн бага тасалдалтай
- Бусад хуулийн өмчлөлийн системтэй амьдрах
- Одоогийн байгаа байгууламж, техник хангамж, програм хангамж, туршлагыг хөшүүрэг хэрэглэх
- Техник хангамж болон програм хангамжийн үйлвэрлэгчдээр хянагдаагүй, удирдуулагдаагүй байх

Төрийн салбарын нээлттэй эхийн програм хангамжийн мастер төлөвлөгөө

- Стратегийн чиглэл болон ерөнхий бүтцийг байгуулах
- Төлөвлөгөө болон газрын зургийг боловсруулах, хэрэгжүүлэх
- Төрийн салбарт нээлттэй эхийн програм хангамжийн хэрэгжүүлэлтийг дэмжих Нээлттэй Эхийн Чадварын Төвийг байгуулах
- Бодлого, стандарт, зөвлөмжүүдийг томъёолох

Малайзын Төрийн Салбарын Нээлттэй Эхийн Програм Хангамжийн Үндсэн Бүтэц

Нээлттэй Эхийн Програм Хангамжийн Үндсэн Бүтэц нь төрийн салбарын нээлттэй эхийн програм хангамжийн зөн болон зорилтуудыг хангах зураг байдлаар үйлчилнэ.

Төрийн салбарын МХХТ-ийн Алсын хараа

МХХТ-ыг ашиглан үр дүнтэй, чанартай үйлчилгээг хүргэх

Нээлттэй Эхийн Програм Хангамжийн Алсын хараа

Үр дүнтэй, аюулгүй, чанартай үйлчилгээг олгосноор төрийн салбарын МХХТ-ийн үндсэн бүтцийн хүрээнд нээлттэй эхийн програм хангамжийг хэрэглэснээр үнэ цэнийг бий болгох, бэхжүүлэх.

Нээлттэй Эхийн Програм Хангамжийн Зорилтууд

- Програм хангамжийн хэрэглээний сонголтыг нэмэгдүүлэх
- Харилцан уялдаа холбоог сайжруулах
- Програм хангамжийг дэмжих, сайжруулах чадамжийг нэмэгдүүлэх
- Эзэмшлийн нийт зардлыг бууруулах
- Худалдагчийн цоож хийхийг бууруулах
- Аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, тусгаар тогтнолыг албадах



» **Шийдлийн хэсэг**

Мэдээллийн технологийн үнийн гинж дэх батлагдсан нээлттэй эхийн програм хангамжийн шийдлүүд нь төрийн салбарт хэрэгжүүлэгдэж болно

Хэрэгжилтийн үе шатууд

Богино, дунд, урт хугацаанд төрийн салбарт зориулсан нээлттэй эхийн програм хангамжийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах

Мэдлэгийн банк

Байгууллагуудын дунд нээлттэй эхийн програм хангамжийн мэдлэг болон туршлага солилцохыг дэмжих

Холбогдох Орчныг бий болгох

Төрийн салбарт нээлттэй эхийн програм хангамжийн хэрэгжилтийг амжилттай болгохын тулд нээлттэй эхийн програм хангамжтай холбоотой санаачлагуудад нөлөөлөх бүрэлдэхүүн хэсгүүд

Эх сурвалж: Abridged from Malaysian Administrative Modernization and Management Planning Unit, "Malaysian Public Sector Open Source Software Portal," <http://www.oscc.org.my/content/view/33/38/> and <http://www.oscc.org.my/content/view/34/40/>.



Асуулт

1. Аливаа улс төлбөргүй, нээлттэй эхийн програм хангамжийн бодлоготой байх ёстой юу? Яагаад эвсэл яагаад үгүй гэж?
2. Төлбөргүй, нээлттэй эхийн програм хангамжийн тухай танай улсын бодлого юу вэ? Энэ бодлогын тохиромжтой, үр дүнтэй байдлын хувьд таны үнэлгээ ямар вэ?

Хамтран ажиллах чадвар

НҮБ-ийн цахим засаглалын 2008 оны судалгаанд хоёрдахь үеийн цахим засаглалын санаачлагуудын шинж чанарыг ялгах зорилгоор “холбогдсон засаглал”-ын тухай тэмдэглэжээ. Энэхүү холбогдсон засаглалыг “нийгмийн бүх салбарын бүтээлч хичээл зүтгэлийг оролцуулснаар нийгмийн сайн сайхныг бий болгох Засгийн газрын хамтын үйл ажиллагаа”⁶³ гэж тодорхойлжээ. Тайланд холбогдсон засаглалд Засгийн газрын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг онцолж “иргэдтэй идэвхитэй, үр дүнтэй зөвлөлдөлж, тэдний оролцоог хангахын зэрэгцээ оролцогч талуудтай бүс нутаг, олон улсын хүрээнд илүү нягт хамтрах” –ыг авч үздэг.⁶⁴

Хамтран ажиллах чадвар буюу “хоёр ба түүнээс дээш тооны системүүд мэдээлэл солилцох болон солилцсон мэдээллийг хэрэглэх чадварууд” нь холбогдсон засаглалыг тодорхойлж өгдөг. Хамтран ажиллах чадваргүйгээр Засгийн газрын байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох нь илүү хэцүү бөгөөд гарын үсэг, нэг цонх, нэгдсэн цахим засгийн портал систем зэрэг үйлчилгээ хүнд сурталтай хэвээр үлдэнэ.

Бразил улсын жишээнээс хамтран ажиллах чадварын хүрээнд холбогдсон засаглалаар өөрийн зорилгуудыг хэрхэн биелүүлж байгааг харж болно.

63 Department of Economic and Social Affairs, Division for Public Administration and Development Management, UN e-Government Survey 2008: From e-Government to Connected Governance (New York: United Nations, 2008), xv, <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/UN/UNPAN028607.pdf>.

64 Ibid.



Бразил дахь хамтран ажиллах чадвараар нийтийн аюулгүй байдал

Нийтийн аюулгүй байдлын салбар нь e-PING (Бразилийн Засгийн газрын хамтран ажиллах чадварын үндсэн бүтэц)-ээс зөвлөмж болгосон зарчмууд болон тодорхойлолтыг практикт хэрэгжүүлсэн анхны салбар юм. Төслийг Хууль зүйн яамны Шүүхийн болон нийтийн аюулгүй байдлын мэдээллийн нэгтгэлийн үндэсний систем буюу Nosegay гэж нэрлэдэг. Энэ нь Бразилийн улсуудын нийтийн аюулгүй байдлын системүүдийг нэгтгэсэн. Энэ систем нь иргэн, цэрэг цагдаа хүчнийхэн, хянан шалгагчдад хүссэн үедээ моторт дугуйнуудын бүртгэл, шүүхээс баривчлах тушаал гарсан хүмүүсийн бүртгэл болон бусад мэдээлэлд хандах эрхтэй болно.

Ялгаатай төрийн нийтийн аюулгүй байдлын системүүдийг нэгтгэснээр Recife-д цагдаагийн хэлтэст замын зөрчил гаргасан талаар байцаагдаж байгаа Parana –аас зугтаж байгаа гэмт хэрэгтнийг тогтоох боломжтой болсон юм. Nosegay Автомашин Ундэсний бүртгэл (Renavam), Жолооны үнэмлэхний үндэсний бүртгэл (Renach), Зэр зэвсгийн бүртгэлийн систем (Sinarm), гэмт хэрэгтэн хэмээн тодорхойлогдсон хүмүүсийн жагсаалт зэрэг өгөгдлүүдтэй нийтийн аюулгүй байдлын системээс шууд лавлагаа хийх боломжийг нээж өгсөн. Нийтийн аюулгүй байдлын үндэсний сүлжээ, Гэмт хэргийн шүүхийн статистик мөн Nosegay-д багтсан. Нэгтгэл хурдтай, аюулгүй, найдвартай замаар хийгддэг. XML, Веб үйлчилгээ (Web services), Интернет протоколууд, интернет хөтчүүдийн сонголт нь Nosegay-д хандах үндсэн утга учир нь юм.

Nosegay (янз бүрийн Бразилийн муж улсуудын одоогийн байгаа нийтийн аюулгүй байдлын системүүдийн хооронд нь холбох)-ийн зардал нь 8,5 сая BRL. Энэ нь өөр нэг арга болох дан ганц нэгдсэн систем байгуулахад тооцоологдсон хөрөнгө болох 4 тэрбум BRL-ын нэг хувиас нь ч бага юм. Nosegay-ээс өмнө 2003 оны сүүлч үед зөвхөн 4-н улс нийтийн мэдээллийн системд өөрсдийн нэмэгдэл мэдээллийг оруулж байсан. Өнөөдөр, Nosegay 200 гаруй холбооны болон төрийн нэгжүүдэд ойролцоогоор 30000 бүртгэгдсэн хэрэглэгчидтэй байна.

Эх сурвалж: Abridged from UNDP, e-Government Interoperability: Guide (Bangkok: UNDP Regional Center, 2007), 2, <http://www.apdip.net/projects/gif/GIF-Guide.pdf>.



Асуулт

1. Нийтийн аюулгүй байдлыг хамтран ажиллах чадвар хэрхэн сайжруулах вэ?
2. Хамтран ажиллах чадвараас өөр ямар үр ашиг бий болж болох вэ?
3. Таны бодлоор хамтран ажиллах чадварт хамгийн том сорилт нь юу вэ?, ялангуяа танай улсын хувьд?

Хамтран ажиллах чадвар нь стандартууд эсвэл архитектурын хүрээнд үүсэн бий болно.

Стандартыг мөрдөх хүрээнд бий болгох хамтран ажиллах чадвар нь Засгийн газраас үндсэн бүтцийн томъёолол, сонголтыг шаарддаг. Засгийн газрын энэхүү хамтран ажиллах чадварын бүтэц нь өөрийн байгууллагууд, иргэд, хамтрагчид бие биетэйгээ хэрхэн харилцан үйлчлэлцэх тэр л замыг тодорхой заах стандарт болон зөвлөмжүүдийн багцыг засгийн газар хэрэглэдэг. Засгийн газрын хамтран ажиллах чадварын ерөнхий бүтэц нь дараах зүйлсийг агуулдаг: 1) дээд түвшний бодлогын илэрхийлэл 2) техникийн агуулга 3) үйл явцын баримтжуулалт 4) хэрэгжүүлэлт 5) нийцлийн дэглэмүүд.

Архитектураар хамтран ажиллах чадвар нь засгийн газар эсвэл үндэсний үйлдвэрлэлийн архитектурыг шаарддаг. Засгийн газрын үйлдвэрлэлийн архитектур нь “төрийн мэдээллийн технологийн системүүдийн хоорондын ерөнхий уялдаа холбоо хангах нийтлэг үндсэн бүтэц” юм. Marjin Janssen, Kristian Hjort-Madsen нар Үндэсний Үйлдвэрлэлийн Архитектурыг тодорхойлохдоо Засгийн газрын МХХТ-ийн төслүүдийн харилцан хамаарлыг тайлбарлах, өөрчлөлтийг удирдах үндсэн бүтэц эсвэл шүхэр хэмээн тодорхойлдог.⁶⁵ NEA аюулгүй хамтран ажиллах чадварт тусладаг төдийгүй хүнд суртлыг багасгадаг. Тиймээс энэ нь эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, орлогод урт хугацааны эерэг үр дүнтэй байдаг.

Стандарт эсвэл архитектураар хамтран ажиллах чадварыг олох сонголт нь цахим засгийн зорилтуудад тулгуур болдог төдийгүй мөн түүнчлэн Засгийн газрын техникийн боловсон хүчний чадамжинд нөлөөлдөг.

Анхааруулга, Санамж

Бодлого боловсруулагчид нь цахим засаглалын хөтөлбөрүүдийг боловсруулахдаа хөгжиж буй орнуудын цахим засаглалын төслүүдээс өгсөн сургамжтай асуудлуудыг нухацтай авч үзэх шаардлагатай. Нэг судалгаагаар, зөвхөн хөгжиж буй орнуудын цахим засгийн санаачлагуудын 15 хувь нь л амжилт олсон байдаг. Их хэмжээнийх нь хагас бүтэлгүйтэл (50 хувь) эсвэл нийт бүтэлгүйтэл (35 хувь) байна.⁶⁶ Бодлого боловсруулагчид тэдний өөрсдийн амжилтыг нэмэгдүүлэхийн тулд бүтэлгүйтсэн цахим засгийн төслүүдийн алдаанаас зугтаах ёстой. (Нэмэлт мэдээлэл 5-г хар)

65 Marjin Janssen and Kristian Hjort-Madsen, “Analyzing Enterprise Architecture in National Governments: The cases of Denmark and the Netherlands,” in Proceedings of the 40th Hawaii International Conference on System Sciences (Washington, D.C.: IEEE Computer Society, 2007), <http://csdl2.computer.org/comp/proceedings/hicss/2007/2755/00/27550218a.pdf>.

66 Richard Heeks, “eGovernment for Development: Success and Failure in eGovernment Projects - Success and Failure Rates of eGovernment in Developing/Transitional Countries: Overview,” Institute for Development Policy and Management, University of Manchester, <http://www.egov4dev.org/success/sfrates.shtml>.

Нэмэлт мэдээлэл 5. Цахим засаглалын төслүүдээс гарсан сургамжууд

1. Дотоод хөдөлгөгч хүчнүүдийн дутагдал - ямар нэгэн дотоодын эзэмших эрх байхгүйгээр зөвхөн МТ-ийн аж ахуйн нэгжээс дарамт шахалт ирдэг, (эсвэл цахим засаглалын ойлголтгүйгээр)
2. Алсын хараа болон стратегийн алдаа дутагдал – ямар нэгэн урт хугацааны төлөвийн алдаа дутагдал, үндсэн чиглэлийн дулимаг байдал, төгсгөлүүд болон дунд шугамуудын хоорондын холбооны дутагдал; өөрчлөгдөж байгаа ахлах албан хаагчаас шалтгаалж магадгүй юм, мөн өөрчлөгдөж буй бодлого, улс төрийн орчноос шалтгаалж болно.
3. Төслийн муу удирдлага – Төслийн маш олон эзэмшлэлд хамаарах тархсан үүрэг хариуцлагууд; хяналтуудын дутагдал эсвэл сул талууд; үр дүнгүй нийлүүлэлт.
4. Өөрчлөлтийн дутуу дулимаг удирдлага – Ахлах албан тушаалтнаас үзүүлэх дэмжлэгийн дутагдал (нөөцийн хуваарьлалтын дутагдал бий болох болон бусад бүлгүүдэд сөрөг мессеж илгээх); оролцогч талуудын оролцоо, хамаарлын дутагдал.
5. Улс төр болон өөрийн сонирхлын давамгайлал – Хувийн зорилго, шаардлага дээр голлох оролцогчид төвлөрөх, голдуу “улс төрөөр тоглох”-той хамааралтай дотоодын тэмцэл шиг тэмдэгтэй, хүчний дутагдал айдас хүргэж байгаа эсэргүүцэл, “би бас” зураглалын зорилгоор цахим засгийн шийдлүүдийг хуулбарлах, сонгуулийн нөлөөлөл болон богино хугацааны шагнал, болон авилгалд автах.
6. Болхи/бодит бус зохиомж дизайн– Ялангуяа голлох оролцогч талуудын дутагдлаас үүдэлтэй зохиомжууд нь техникийн илүүдэл, амбицийн илүүдэл, эсвэл дотоодын орчин нөхцөл, шаардлагад тохироогүй; гадаадын донорууд, кинонууд, зөвлөгчид оролцсон. Бусад зохиомжийн асуудлууд нь: загварын дутагдал, байгууллагын бүтцэд тохирохгүй байх зэрэг.
7. Чухал хэрэгтэй ур чадваруудын дутагдал – хөгжүүлэгчид, ажилтнууд, хэрэглэгч/операторууд МТ-ийн мэдлэг ур чадвар дутмаг; хөгжүүлэгчдийн дунд дотоодын мэдлэг дутуу.
8. Хүрэлцээгүй технологийн дэд бүтэц – Хангалттай компьютерүүд эсвэл сүлжээнүүд дутуу
9. Технологийн үл зохицох байдал – Компьютержсэн систем өгөгдөл солилцох боломжгүй байх

Эх сурвалж: Adapted from Richard Heeks, “eGovernment for Development: Success and Failure in eGovernment Projects - Evaluation,” Institute for Development Policy and Management, University of Manchester, <http://www.egov4dev.org/success/evaluation/factormodel.shtml>.



Асуулт

1. Цахим засгийн төслүүд бүтэлгүйтэх шалтгаан болж байгаа хүчин зүйлүүдийн аль нь дотоод, аль нь гадаад байна вэ?
2. Танай улсын хувьд хамгийн бага хамааралтайгаас Heeks(Нэмэлт мэдээлэл 5)-ын гаргасан цахим засгийн бүтэлгүйтлийн шалтгаануудад зэрэглэл тогтоо



Дасгал

Цахим засаглалын төслийн сургамжууд, учир шалтгаан

- Өөрийн улсдаа цахим засгийн бүтэлгүйтсэн төслүүдээс нэгийг нь сонго, бүтэлгүйтлийн шалтгааныг хэлэлц.
- Сургалтанд оролцогчид үүнийг тухайн улсын бүлгээр дасгал болгон ажиллах



Өөрийгөө шалгах нь:

1. ХМХХТ-той хамааралтай хүний капиталын хөгжүүлэлтийн 2 ерөнхий асуудал юу вэ?
2. Боловсрол дахь МХХТ-ийн ДБ-ны судалгаанд ямар гол асуудлууд гарч ирсэн бэ?
3. МХХТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн цоорхойг бөглөхийн тулд засгийн газар юу хийх ёстой вэ?
4. Хятадын дэлхийн МХХТ-ийн үйлдвэрлэлийн төв болоход ямар бодлогууд хэрэгжүүлсэн бэ?
5. Энэтхэгийг дэлхийн програм хангамж хөгжүүлэлтийн аварга том төв болгоход юу хийгдсэн бэ?
6. Цахим агуулгын хөгжилд Ирландын стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь юу вэ?
7. Цахим засаглал болон цахим засгийн хоорондын ялгаа нь юу вэ? Энэ өөрчлөлт бодлого болон стратегид хэрхэн тусгагдах вэ?
8. Яагаад засгийн газар үнэгүй болон нээлттэй эхийн програм хангамжийг хэрэглэхийг авч үзэх ёстой вэ?
9. Цахим засгийн хамтран ажиллах чадварын гол чухал нь юу вэ?
10. Яагаад цахим засгийн төслүүд бүтэлгүйтээд байна вэ?

Нэмэлт материалууд

Conklin, Wm. Arthur. 2007. Цахим засгийг сонгоход гарах хүндрэлүүд. Системийн шинжлэх ухааны 40 дүгээр Хавайн олон улсын бага хурлын ажилд. Вашингтон, D.C.: IEEE Компьютерийн шинжлэх ухаан. <http://csdl2.computer.org/comp/proceedings/hicss/2007/2755/00/27550098a.pdf>.

Эдийн засаг, нийгмийн асуудлын яам, Төрийн захиргаа болон хөгжлийн удирдлагын газар. 2008. НҮБ-ын цахим засгийн судалгаа 2008:Цахим засгаас холбогдсон засаглал. New York хот: АНУ. <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/UN/UNPAN028607.pdf>.

Европын комисс. Цахим засгийн амжилтын үзүүлэн. Европын мэдээллийн нийгмийн сэдэвчилсэн портал. http://ec.europa.eu/information_society/activities/egovernment/implementation/index_en.htm. Heeks, Richard. 2006. Цахим засгийг стандартчилах : Цахим засгийн үндэсний болон олон улсын арга хэмжээнүүд, үнэлгээ, харьцуулалтуудыг сайжруулах. iGovernment Ажлын Хэсэг Цуврал № 18. http://www.sed.manchester.ac.uk/idpm/research/publications/wp/igovernment/igov_wp18.htm.

Ардчилал болон технологийн infoDev болон төв. 2002. Хөгжиж буй орнуудад зориулсан цахим засгийн гарын авлага. <http://www.infodev.org/en/Publication.16.html>.

Lafond, Renald, Chaitali Sinha, eds. 2005. Азийн нөхцөлд цахим худалдаа: Сонгогдсон жишээн дээр суралцах. Сингапур: Зүүн өмнөд азийн судалгаа болон Оттавагийн институт: Олон улсын хөгжлийн судалгааны төв. http://www.idrc.org/en/ev-72689-201-1-DO_TOPIC.html.

Narayana, M.R. “МХХТ-ийн салбар болон бүс нутгийн эдийн засгийн хөгжил: Karnataka улсын нотолгооноос” (Шинэчилсэн хувилбар).Хөгжлийн гарцын сан. <http://ict.developmentgateway.org/Content-item-view.10976+M57819bce2bb.0.html?&L=0>.

ОУЭЗХАБ. 2006. Чадавхи хөгжүүлэлтийн сорилт: Сайн практикийн зүгт ажилла. Парис: ОУЭЗХАБ. <http://www.oecd.org/dataoecd/4/36/36326495.pdf>.

Trucano, Michael. 2005. Мэдлэгийн газрын зураг:Сургалт болон ололт амжилтанд дээр МХХТ-ийн нөлөөлөл. Вашингтон, D.C.: infoDev / ДБ. <http://www.infodev.org/en/Publication.154.html>.

UNCTAD. 2006. Хамгийн бага хөгжсөн улсуудын тайлан 2006:Бүтээлч чадавхийг хөгжүүлэх. New York, Geneva: НҮБ. <http://www.unctad.org/Templates/webflyer.asp?docid=7011&intlItemID=3881&lang=1&mode=downloads>.

UNESCO. Бодлого боловсруулагч, төлөвлөгчид, хувиараа ажил эрхлэгчдэд зориулсан боловсролын МХХТ-ийн хэрэгслүүдийн цуглуулга. <http://www.ictinedtoolkit.org/usere/login.php>.

Дэлхийн Банк. 2005.Цахим Стратегууд: Хэрэгслүүдийн цуглуулгыг ажиглах, үнэлэхт. http://siteresources.worldbank.org/INTEDEVELOPMENT/Resources/estrategiesToolkit_Jan2005.pdf.

3.МХХТ-ИЙН ЗАСАГЛАЛ

Энэ хүү бүлгийн зорилго нь:

- МХХТ-ийн засаглалыг тодорхойлох
- МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийг тодорхойлох
- МХХТ-ийн хөрөнгө оруулалтуудыг зохицуулах зарчмуудыг хэлэлцэхэд оршино.

МХХТ-ийн засаглал нь “МХХТ-ыг хэрэглэхэд тустай зан байдлыг урамшуулах шийдвэр гаргах эрх болон үүрэг хариуцлагын үндсэн бүтцийг тусгайлан тодорхойлох” –ыг хэлнэ.⁶⁷ Энэ нь “байгууллага эсвэл байгууллагын алба өөрийн зөв үйл ажиллагааг явуулахад үр дүнтэй санаачлагатай байх” корпорацийн засаглалын нэг хэсэг юм.⁶⁸ МХХТ-ийн засаглал нь байгууллагын хувьд хэн хамгийн сүүлийн шийдвэрийг гаргаж байна гэдгээр тодорхойлогддог, энэ тохиолдолд засгийн газар байж болно. Энэ нь МХХТ дээрхи сүүлийн шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, хийх үйл явц болох МХХТ-ийн “удирдлага” –аас ялгаатай юм.

МХХТ-ийн засаглалын гурван үндсэн зорилтууд байдаг: 1) тухайн байгууллага, түүний хэрэгцээ, дарамт шахалтын нөхцөлд МХХТ-г үнэлэх 2) МХХТ-ийн санал болгосон төлөвлөгөө болон бодлогууд 3) Бодлогуудтай тохирох байдал, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянан шалгах.⁶⁹ Хувийн хэвшлийн салбарт, МХХТ-ийн засаглалын бүхий л зорилтууд нь МХХТ-ийн засаглалын институтын хэлсэнчлэн:

МТ-ийн асуудлууд, стратегийн чухалчлалыг ойлгох, ингэснээр байгууллага өөрийн үйл ажиллагааг тогтвортой авч үлдэж, ирээдүйн үйл ажиллагаагаа өргөтгөх шаардлагатай стратегиудыг хэрэгжүүлж чадна. МТ-ийн засаглал нь МТ-ийн хүлээлттэй тохирч, МТ-ийн эрсдлүүд багассан байх явдлыг хангахад чиглэгддэг.⁷⁰

Мэдээллийн технологийн удирдлагын нийгэм, төрийн салбарын МХХТ-ийн менежерүүдийн Английн нийгэмлэг төрийн салбарын МХХТ-ийн засаглал нь дараах гэсэн саналуудыг гаргасан. Үүнд:

- Оролцогч талуудын холбоо хэлхээ болон төлөөлөл
- Мэдээлэл, технологийн хөрөнгө оруулалт, нийлүүлэлт, суурилуулалтын стратегийн төлөвлөгөө
- Бодлого боловсруулах болон зөвшилцөлд хүрэх
- Хөтөлбөр хүргэлтийг дээд түвшинд ажиглан шалгах
- “Бизнес бол байдаг л зүйл” гүйцэтгэлийн хянан шалгалт
- Стандартуудыг сонгох, хэрэгжүүлэх
- Эрсдлийн удирдлага
- Хууль, зөв зохистой хэрэглээтэй нийцэх бодлого, стандартыг боловсруулах⁷¹

67 Peter Weill and Jeanne W. Ross, *IT Governance: How Top Performers Manage IT Decision Rights for Superior Results* (Boston: Harvard Business School Press, 2005), 8.

68 Richard Ziolkowski and Eugene Clark, “Standards of ICT Governance: The Need for Stronger Epistemological Foundations in Shifting Sands,” *The Asia Pacific Journal of Public Administration* Vol. 26, No. 1 (June 2005), 77, <http://sunzi1.lib.hku.hk/hkjo/view/51/5000806.pdf>.

69 Ibid., 79.

70 IT Governance Institute, *Board Briefing on IT Governance*, 2nd Edition (Illinois: IT Governance Institute, 2003), 7, http://www.isaca.org/Content/ContentGroups/ITGI3/Resources1/Board_Briefing_on_IT_Governance/26904_Board_Briefing_final.pdf.

71 Society of Information Technology Management, “ICT governance,” <http://www.socitm.gov.uk/socitm/Events/ICT++governance.htm>.

3.1.МХХТ-ИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН БҮТЭЦ

Засгийн газрууд МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийг хөгжүүлэхийн тулд хөгжлийн зорилгын дагууд МХХТ-ийн хэрэглээг хамгийн их байлгах ажиллаж байна. Энэ үндсэн бүтэц нь дараахаас бүрдэнэ. 1) Зарчмууд, 2) Шийдвэр гаргах шатлан захирах ёс 3) Тайлагнах болон ажиглах үйл явцыг харуулсан загвар.⁷²

Зарчмууд

МХХТ-ийн зарчмууд нь МХХТ-ыг хэрэглэх тухай дээд түвшний мэдэгдлүүдийн хамаарсан болно. МХХТ-ийн засаглалын үндсэн бүтэцэд зориулсан зарчмуудын нэг жишээ нь Австралийн МХХТ-ийн засаглалын зарчмууд юм. Үүнд:

1. МХХТ-т зориулсан тодорхой ойлгогдох үүрэг хариуцлагуудыг бий болгох – Байгууллагын хүрээнд хувь хүмүүс болон бүлэг хүмүүс МХХТ-ийн өөрсдийн үүрэг хариуцлагуудыг ойлгож, хүлээн авч байгааг хангах.
2. Байгууллагын шаардлагуудыг хамгийн сайн дэмжих МХХТ-г төлөвлөх – МХХТ-ийн төлөвлөгөөнүүд нь байгууллагын одоогийн шаардлагуудтай тохирох байдлыг хангах, МХХТ-ийн төлөвлөгөөнүүд нь корпорацийн төлөвлөгөөнүүдийг дэмждэг байх.
3. МХХТ-ийн үндэслэлийг олж авах – МХХТ-г олж авах нь зөв замаар, зөв шалтгаанаар, зохистой, одоогийн үргэлжилж буй дүн шинжилгээн дээр хийгдсэн байхыг хангах. Зардлууд, эрсдлүүд, урт болон богино хугацааны үр ашгуудын хооронд зохистой тэнцвэрт байдлыг хангах
4. Шаардлагатай үед МХХТ сайн гүйцэтгэл үзүүлдэг байдлыг хангах – МХХТ байгууллагыг дэмжих зорилгуудтай нийцсэн байх, өөрчлөгдөн буй бизнесийн шаардлагуудтай тохирч, түүний дагуу өөрчлөгдөж байх, бизнест шаардлагатай үед нь бүхий л цаг хугацаанд бизнест дэмжлэг өгдөг байх.
5. МХХТ-ийн зохицолдлогоог хангах – МХХТ нь бүх гадаад зохицуулалтуудтай зохицдог, бүх дотоод бодлого, практик туршлагаудтай нийцдэг байдлыг хангах
6. МХХТ-ийн хэрэглээ хүний хүчин зүйлийг тусгадаг байх – МХХТ нь үйл явцын бүх хүмүүсийн одоогийн болон шинээр үүсэж буй шаардлагуудтай тохирдог байх.⁷³



Дасгал

МХХТ-ийн зарчмуудад зэрэглэл тогтоо

Танай улсын хувьд хэрэгжүүлэхэд Австралийн МХХТ-ийн засаглалын зарчмуудыг хамгийн хэцүүгээс нь хамгийн амархан луу нь жагсааж, зэрэглэл тогтоо.

72 National Computing Centre, "IT Governance," http://www.nccmembership.co.uk/pooled/articles/BF_WEBART/view.asp?Q=BF_WEBART_298897.

73 Standards Australia Limited, "Australian world-first ICT governance Standard," <http://www.standards.org.au/cat.asp?catid=66&ContentId=82&News=1>.

Шийдвэр гаргах шаталсан бүтэц

МХХТ-ийн засаглалын дараагийн элемент нь шийдвэр гаргах шаталсан бүтэц юм. Weill & Ross-ийн төрийн салбарт зориулсан МТ-ийн засаглалын загвар⁷⁴ нь бидэнд шийдвэр гаргах шаталсан бүтцийн жишээнүүдийг өгдөг. МХХТ-ийн засаглалын загварууд нь:

- **Бизнесийн хаант засаглал** – Сайд/Нарийн бичгийн дарга эсвэл Ерөнхий нарийн бичгийн дарга (бизнесийн төлөөллийн Засгийн газрын оролцоо эсвэл хувь хүмүүсийн төлөөлөл) МХХТ-ийн шийдвэрүүдийг гаргадаг.
- **Мэдээллийн технологийн хаант засаглал** – Засгийн газрын МТ-ийн мэргэжилтнүүд (Засгийн газрын мэдээллийн ахлах ажилтан шиг) шийдвэр гаргадаг
- **Фёодал** – Үйл ажиллагааны албаны дарга (салбарууд, хэлсүүд, газрууд) МХХТ-ийн шийдвэр гаргадаг
- **Холбоот улс** – Яам/Газрын ахлах мэргэжилтнүүд эсвэл шийдвэр гаргадаг газрын дарга; мөн МТ-ийн гүйцэтгэгчид нэмэлт оролцогч байдлаар оролцох
- **МТ-ийн олигархи** – МХХТ-ийн гүйцэтгэгчид болон нэг бусад бүлэг МХХТ-ийн шийдвэр гаргадаг.
- **Анархи** – Хувь хүн бүр шийдвэр гаргадаг



Дасгал

МХХТ-ийн шийдвэрийг Хэн гаргадаг вэ?

Өөрийн байгууллагын МХХТ-ийн шийдвэр гаргах бүтцийг Weill, Ross-ийн гаргасан засаглалын загварыг ашиглан оншил

МХХТ-ийн шийдвэр гаргах шаталсан бүтцийг үүсгэх нь Засгийн газруудад шинэ зүйл биш юм. Олон Засгийн газрууд аль хэдийн МХХТ-ийн өөрчлөлтөнд үндэсний хэмжээний байгууллагатай болсон. Одоогийн байгаа туршлагаас харахад бид хамгийн багадаа МХХТ-ийн шийдвэр гаргах 4-н биеийг байгуулж чадна: Яам, Комисс, Газар, Зөвлөл. Хүснэгт 1 Азид байгаа МХХТ-ийн байгууллагуудын тодорхойлолтыг гаргалаа.

⁷⁴ Based on Weill and Ross, IT Governance, 58-63.

Хүснэгт 1. Азийн МХХТ-ийн байгууллагуудын харьцуулсан матрикс

МХХТ-ийн байгууллагуудын нэрс	Үйл ажиллагаа	Бусад үндэсний Засгийн газрын байгууллагуудтай харилцан хамаарал
<p>ЯАМ</p> <p>Мэдээллийн технологийн яам, Мэдээлэл Холбооны яам (Энэтхэг)</p>	<p>MT-той холбоотой бодлогын асуудлууд; Электроник, болон интернэт (Интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийг гэрчилгээжүүлэхээс авхуулаад бүх асуудал).</p> <p>Интернэт, MT, MT-ашигласан үйлчилгээнүүдийг дэмжих. Цахим засаглалыг дэмжихтэй холбоотой бусад яамдуудад тусламж үзүүлэх, Цахим худалдаа, цахим эмнэлэг, цахим дэд бүтэц, гэх мэт.</p> <p>MT-ийн боловсрол, MT-дээр суурилсан боловсролыг дэмжих.</p> <p>Кибер хуультай холбоотой асуудлууд, Мэдээллийн Технологийн АКТ 2000 (2000-ын 21) болон бусад MT-той холбоотой хуулиуд.</p> <p>Хагас дамжуулагчийн төхөөрөмжийн үйлдвэрлэлийг дэмжих, Semiconductor Complex Limited Mohali- тай холбоотой асуудлаас бусдыг нь авч үзэх; Хагас дамжуулагчийн нэгдсэн гүйдлийн зохион байгуулалтын зохиомжийн акт 2000 (2000-ын 37).</p> <p>Олон улсын байгууллагуудтай MT-той холбоотой асуудлуудаар харилцан ажиллах – Жишээ нь: Internet for Business Limited, Institute for Education in Information Society and International Code Council.</p> <p>Тоон хуваагдлыг арилгах санаачлага: Media Lab Asia-тай хамааралтай асуудлууд.</p> <p>Стандартжуулалтыг дэмжих, MT-ийн тестчилэл, чанар, MT-ийн хэрэглээ болон зорилтуудад зориулсын процедурын стандартчилал.</p>	<p>Яамны үндсэн чиглэлүүдийн нэг болох Засгийн газарт цахим засаглалын багцуудыг сонголтыг хурдасгах, дэмжих, Цахим засаглалын үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжүүлэлтийг холбогдох байгууллагуудад олгох</p> <p>Түүний 10 онооны агуулга нь:</p> <ul style="list-style-type: none"> • Захиргаанд ил тод байдлыг бий болгох, Засгийн газрын үйл ажиллагааг илүү иргэнд төвлөрсөн болгох, Яам цахим засаглалын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд анхаарал тавих. • Шинэ интернэтийн протокол IP6 луу шилжих - IP6 луу шилжихийн тулд сүлжээний үйлчилгээг үзүүлэгчдэд боломж олгох тухайн улсад дэмжлэг тусалцааны арга хэмжээнүүдийг өгөх, бодлогын үндсэн суурийг бий болгох. • Аюулгүй байдал болон Тоон гарын үсэг – Кибер дэд бүтцийн хамгаалалтанд төвлөрөх, санхүү, шүүх, боловсролын салбарт тоон гарын үсэг хэрэглэхийг дэмжих.

»

»

МХХТ-ийн байгууллагуудын нэрс	Үйл ажиллагаа	Бусад үндэсний Засгийн газрын байгууллагуудтай харилцан хамаарал
	<p>Электроникийн экспорт болон компьютерийн програм хангамжийг дэмжих зөвлөл. Үндэсний информатекийн төв. Техник хангамж/програм хангамжийн зах зээлийг хөгжүүлэх санаачлагууд түүн дотроо мэдлэгт суурилсан үйлдвэрлэл, МТ-ийн экспортыг дэмжих арга хэмжээнүүд болон аж үйлдвэрийн салбарын өрсөлдөөнт байдал. Яамны удирдлаган доорхи боловсон хүчинтэй холбоотой асуудлууд</p>	
<p>КОМИСС МХХТ-ийн дээд түвшний комисс (Нефал)</p>	<p>Үндэсний МТ-ийн бодлого, стратегийн хэрэгжүүлэлтийг хянах, засгийн газарт стратегийн бодлогын чиглэл, дэмжлэг өгөх Хөгжил, эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулахад МХХТ-г бэхжүүлэхийн тулд МХХТ-ийн салбарт зориулсан зохистой бодлогын арга хэрэгслүүдийг томъёолоход голлох байр суурьтай оролцох</p>	<p>Хувийн хэвшил, их сургуулиуд, донорын нийгэмлэгтэй ойр дотно харилцан хамааралтай байдлыг сахиснаар Нефалын засгийн газарт байнгын бодлогын дэмжлэг, санал хүсэлт өгөх Засгийн газарт чанарын удирдлагын дэмжлэгийг хувийн салбар, төр-хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан боловсролын байгууллагуудтай хамааралтай МХХТ-ийн чанарын стандартуудыг тодорхой болгох, мөрдүүлэхэд туслах Хаант улсын хүрээнд физик болон хийсвэр одоогийн байгаа болон ирээдүйн МТ-ийн паркуудыг удирдах, байхгүй тохиолдолд байгуулах, хөгжүүлэх, туслах Үндэсний төлөвлөлтийн комисстой хамтран Засгийн газрын яамдууд, хувийн хэвшил, донорын нийгэмлэг, мэргэжлийн байгууллагууд, их сургуулиуд, судалгааны хүрээлэнгүүд, үндэсний МТ-ийн төлөвлөгөө/хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх</p>

»

» МХХТ-ийн байгууллагуудын нэрс	Үйл ажиллагаа	Бусад үндэсний Засгийн газрын байгууллагуудтай харилцан хамаарал
		Чухал шаардлагатай хууль, зохицуулалт, үйлжиллагааны арга хэрэгслүүдийг акт, зохицуулалт, зөвлөмж хэлбэрээр улсын МХХТ-ийн салбарын өсөлт, хөгжлийн хүрээнд боловсруулахад туслах
ГАЗАР Үндэсний мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжлийн газар (NIDA) (Камбожи улс)	Богино, дунд, урт хугацааны МТ-ийн дэмжлэг, хөгжлийн бодлого боловсруулах. Эдийн засгийн өсөлтийг хамгийн дээд түвшинд хүргэх МТ-ийн бодлогыг хэрэгжүүлэх. Камбожийн нэгдсэн вант улсад бүх МТ-той холбоотой төслүүдийг хянан шалгаж, аудит хийх. NiDA нь зохицуулагч бөгөөд бас дэмжигч юм. Эдгээр нь зөрчилдөөнтэй үүргүүд биш бөгөөд харин зохицуулалтын үүрэг хөгжлийн зорилгуудтай нийцэж байгааг хангах нэгдсэн арга барил юм. (вэб сайтанд өгөгдсөн).	Төв засгийн газраа виртуалаар холбосон, дараагийнх нь дотоодын засгийн газруудаа холбох – баримт бичгүүд онлайнаар боловсруулагдана, дараах үйлчилгээнүүд онлайн болно: автомашины дугуй, үл хөдлөх хөрөнгө, иргэний бүртгэл. Төрийн байгууллагын ажилтнуудад МТ-той холбоотой сургалт/ойлголт мэдлэг өгөх семинаруудыг зохион байгуулна.
ЗӨВЛӨЛ Бруней Дарусаллам МТ-ийн зөвлөл (Brunei Darussalam IT Council)	Үндэсний хэмжээнд МХХТ-ийн манлайлал, чиглэлийг бий болгох, хангах. Төрийн болон хувийн хэвшлийн салбарт МХХТ-ийн хөгжлийн холбоосууд, харилцан ажиллагаагаар хангах. Одоогоор Засгийн газрын байгууллагуудаар хэрэгжүүлэгдэж байгаа, хувийн хэвшлийн шаардлагатай оролцогчид хандах төрөл бүрийн МХХТ-ийн санаачлага, хөтөлбөр, төслүүдийг нэгтгэх.	Судалгаа, хөгжүүлэлт, тараалтаар Бруней Дарусалламд стратегийн, тэргүүлэх ирмэг МТ-ыг хайх, тэдний хүчин чармайлтыг дэмжих. Засгийн газрын байруудад цахим засгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх алхмуудыг үнэлэх, судалгаа хийх, цаашлаад санал болгох. Холбогдох байгууллагуудаар МТ-ийн хэрэглээ, стратегийн хөгжүүлэлтийг дэмжих үндсэн бүтэц, арга хэмжээ, үйл ажиллагаануудыг байгуулах, зохистой бодлогыг томъёолох.

Одоогоор МХХТ-ийн агентлагтай байгаа улсуудын хувьд нэг асуудал нь одоо барьж байгаа удирдлага нь тэдний шаардлагад үр дүнтэй байгаа эсэхэд юм. МХХТ-ийн агентлаггүй улсуудын хувьд, асуудал нь үр дүнтэй МХХТ-ийн засаглалыг хэрэгжүүлэхэд тохиромжтой санхүүжилтыг хийхэд оршиж байна.

Тайлан болон хяналт шалгалтын үйл явц

МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийн гуравдугаар элемент нь тайлагнах болон хянан шалгах явцыг тохируулсан багц юм. Австралийн Засгийн газрын Мэдээллийн менежментийн газрын боловсруулсан МХХТ-ийн хөрөнгийн удирдлагын шилдэг практикийн зүйлсийн жагсаалт нь МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийн гуравдагч бүрэлдэхүүн хэсгийн нэгэн жишээ нь юм.

Сайн практик зүйлсийн жагсаалт – МХХТ-ийн хөрөнгийн удирдлага⁷⁵

Ерөнхий асуулт:

- Та хөрөнгийн удирдлагын амьдралын циклийг ойлгож байна уу?
- Та хөрөнгийн удирдлагын зарчмуудтай дотно байна уу?

МХХТ-ийн удирдлагын үндсэн бүтцийг хөгжүүлэх нь

- Та МХХТ-ийн хөрөнгийн удирдлагыг хамрах бодлогуудыг боловсруулсан уу?
- Та хөрөнгийн бүртгэлүүдийг нийлүүлэлт болон байршлын үйл явцуудтай холбосон уу?
- Та хүрээлэн буй орчинд таатай олж авах, байршлын сонголтуудыг хийсэн үү?
- Та зөөврийн компьютер болон бусад зөөврийн хэрэгслүүдийн хэрэглээний бодлогыг боловсруулсан уу?
- Та системийн аюулгүй байдлын асуудлуудыг авч үзсэн үү?
- Та МХХТ-ийн хөрөнгийн удирдлагыг бэхжүүлэхийн тулд дээд түвшний системүүдийг хэрэглэхийг зөвшөөрсөн үү?
- Та МХХТ-ийн хөрөнгийн удирдлагыг хялбарчлах шинэчилсэн арга барилыг авч үзсэн үү?
- Та хурдацтай хяналтын үндсэн бүтцийг байгуулсан уу?

Хөрөнгийн бүртгэлийг байгуулах, удирдах

- Та хэн хөрөнгийн бүртгэлийн удирдлагын үүрэгтэй гэдгийг тодорхойлсон уу?
- Та бүх физик болон баригддаггүй МХХТ-ийн хөрөнгүүдийг бүртгэх хөрөнгө бүртгэлийг үүсгэсэн үү?
- Та хөрөнгө бүртгэл дээрхи, мэдээллийн өмч хөрөнгө болон оюуны өмчөөс бусад бүх МХХТ-ийн хөрөнгүүдийг бүртгэсэн үү?
- Та нэгдсэн програм хангамжийн хөрөнгийн бүртгэл бий болгосон уу?
- Та хувийн асуудалтай холбоотой төрлийн бүртгэл үүсгэсэн үү?
- Та зөвөрлөх боломжтой хөрөнгөнд хэрэглээний бодлого боловсруулсан уу?
- Та хөрөнгө бүртгэлийн сахих, нийцүүлэх тооллогын арга механизмыг боловсруулсан уу?

МХХТ-ийн өмч хөрөнгийн аудит

- Та бодлого, зохицуулалтуудын нийцлийг шалгасан уу?
- Та програм хангамжийн нийцлийг шалгасан уу?

Энэхүү МХХТ-ийн хөрөнгийн удирдлагын ажлын жагсаалт нь Засгийн газрууд үр дүнтэй МХХТ-ийн засаглалын үндсэн бүтэцтэй байх зорилгоор боловсруулж, хэрэгжүүлэх ёстой маш олон тайлан, шалгалтын аргуудын зөвхөн нэг нь л юм.

⁷⁵ Australian Government Information Management Office, Better Practice Checklist – 24. ICT Asset Management (Commonwealth of Australia, 2007), <http://www.finance.gov.au/e-government/better-practice-and-collaboration/better-practice-checklists/asset-management.html>.

3.2. МХХТ-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУДЫГ УДИРДАН ЗОХИЦУУЛАХ НЬ

МХХТ-ийн засаглалын нэгэн чухал асуудал бол МХХТ-ийн хөрөнгө оруулалтуудад зэрэглэл тогтоох юм. Санхүүжилт шаардлагатай маш олон хэрэгтэй, зайлшгүй шаардлагатай МХХТ-ийн төслүүд байгаа ч хангалттай санхүүжилт алга байна. Нөхцөл байдал бүр нь давтагдашгүй байгаа нь тодорхой үед асуудлуудыг шийдэхэд туслах ерөнхий журмууд байна.

МХХТ-ийн хөрөнгө оруулалтыг тодорхойлох нэг арганы NEA-г санхүүжилтийн тодорхойлогч хүчин зүйлээр хэрэглэх явдал юм. Өмнө нь тайбарласан члан NEA бол Засгийн газрын төслүүдийн хоорондын харилцан хамаарал, өөрчлөлтийг удирдахыг тайлбарладаг үндсэн бүтэц нь юм.⁷⁶ Данийн засгийн NEA-г “системүүд дотоод шаардлагын хүрээнд нийцсэнтэй адилаар ижил хугацаанд төрийн салбарын МТ-ийн системүүдийн хоорондын ерөнхий зохицолдлогоог хангах нийтлэг үндсэн бүтэц” гэж тодорхойлсон байдаг.⁷⁷ Энэ хандлагын хувьд NEA-тай тохирох зөвхөн МХХТ-ийн төслүүд л санхүүжүүлэгдэнэ.

МХХТ-ийн зарлагын зэрэглэлийг тогтоох өөр нэг арга нь тухайн төслийн аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлт, үйл явцыг тодорхой заадаг “МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчим”-ыг авч хэрэглэснээр юм. Австралийн Бүх Засгийн газрын МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчмууд (Нэмэлт мэдээлэл 6) нь МХХТ-ийн зарлагуудад зэрэглэл тогтоох зорилгоор илүү сайн аргуудыг хайж байгаа бодлого боловсруулагчдад хэрэгтэй зөвлөмж болно.

Нэмэлт мэдээлэл 6. Австралийн Бүх Засгийн газрын МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчмууд

Зарчим 1: Засгийн газар МХХТ ашигласан бизнесийн өөрчлөлтийн хөтөлбөр болон төслүүдийн санхүүжилтийг зохистойгоор хувиарлах боломжийг нээхийн тулд агентлагаас болон бүхий л Засгийн газрын өнцгөөс хангалттай хэмжээний мэдээллээр хангагдсан байх хэрэгтэй.

Зарчим 2: Агентлагууд засгийн газрын шаардлагуудыг хүргэхийн тулд нөөцүүдийн үр дүнтэй, бүтээмжтэй, ёс зүйтэй хэрэглээг анхаарч ажиллана..... Агентлагууд энэ зорилтыг хангахын тулд хангалттай засаглалын болон хянан шалгалтын үйл явцуудтай байдлыг хангана.

Зарчим 3: МХХТ-той хамаарах шинэ бизнесийн чадамж дахь хөрөнгө оруулалтууд нь зардал болон үр ашгийн дагуу тайлбарлагдана.

Зарчим 4: Агентлагууд МХХТ-ийн бий болгосон үр дүн, МХХТ-ийн хөрөнгө оруулалтанд ногдох ашгийн үр дүнг үнэлэх, эдгээр суралцсан зүйлсээ төсөл бүрийн амьдралын циклийн туршид засгийн гарын дагуу гол цэгүүдэд хуваалцана.

Зарчим 5: Сангийн яам агентлагуудтай хамтран Австралийн Засгийн газрын МХХТ-ийг үр дүнтэй, бүтээмжтэйгээр хэрэглэх байдлыг хангахад туслах үндсэн бүтцүүдийг боловсруулна. Сангийн яам дараах байдлаар боловсруулна: дахин ашиглалтыг дэмжсэнээр, хамтран ажиллах чадвараар, солилцох болон хамтын ажиллагаагаар, стандартуудыг хэрэглэхийг урамшуулснаар, МХХТ-ийн хөрөнгө оруулалтан дээр засгийн газарт зөвлөгөө өгөх, агентлагуудад стратегийн зөвлөмж өгөх зэргээр хэрэгжүүлнэ.

Зарчим 6: Гол агентлагууд бусад агентлагуудыг мэдээлэл, хэрэгсэл, сургалтаар ханган уялдуулан зохицуулснаар МХХТ-ийн хөрөнгө оруулалтыг удирдахад шаардлагатай үр чадвараар дэмжлэг үзүүлнэ.

76 UNDP, e-Government Interoperability: Guide (Bangkok: UNDP Regional Center, 2007), 23, <http://www.apdip.net/projects/gif/GIF-Guide.pdf>.

77 Ibid.



Асуулт

1. МХХТ-ийн хөрөнгө оруулалтанд бүхий л засгийн газрын арга барилын давуу талууд нь юу вэ?
2. МХХТ-ийн хөрөнгө оруулалтанд танай засгийн газрын бодлого юу вэ?

Харамсалтай нь МХХТ-ийн засаглалын чухал зүйлсийг үл харгалзвал, цөөн хэдэн Засгийн газрууд МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийг (зарчмууд, шийдвэрийн шаталсан бүтэц, чиглэлтэй хянан шалгалт болон үнэлгээний үйл явцууд) Засгийн газрын түвшинд эсвэл Засгийн газрын байгууллага бүрийн хүрээнд ашигласан байдаг. Энэ нь мөн МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчмуудын хувьд ч адил юм.

Сүүлийн санаа нь: Сайн МХХТ-ийн засаглал хамгийн дээд түвшинд үр дүнтэй манлайллын нэгэн бүтээгдэхүүн юм.

Өөрсдийн улсдаа МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийг үүсгэхээр тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа бодлого боловсруулагчид Weil, Ross-ийн “МХХТ-ийн засаглалын шилдэг 10-н манлайллын зарчмууд”-ыг авч үзэснээр эхлэх хэрэгтэй юм.⁷⁸ Эдгээр зарчмууд нь төрийн салбарын нөхцөлд тохирсон бөгөөд дараах байна.

МХХТ-ийн засаглалын шилдэг 10-н манлайллын зарчмууд

1. Идэвхитэй дизайны засаглал

Удирдлага байгууллагын зорилтууд болон гүйцэтгэлийн зорилгын хүрээнд МХХТ-ийн засаглалыг идэвхитэйгээр тодорхойлох хэрэгтэй. Идэвхитэй зохиомжийн засаглал нь ахлах менежерүүдийг удирдлагыг гартаа авах, нөөцүүдийг хувиарьлах, үйл явцад анхаарал, дэмжлэг тавихтай холбогддог.

2. Дахин дизайн хийх

Засаглалын өөрчлөлт нь хүссэн ажиллах горимтой өөрчлөлтийг шаарддаг. Гэхдээ бүх засаглалын бүтцийн талаар бодож үзэх нь хувь хүмүүсийг шинэ үүрэг, хариуцлагуудыг сурахыг шаарддаг учраас засаглалын дахин зохиомж нь давтамжтай биш юм.

3. Ахлах албан тушаалтнуудыг хамрах

Ахлах түвшний албан тушаалтнаас бүрдсэн удирдлага нь стратегийн шийдвэр гаргахад зайлшгүй холбогддог. Мэдээллийн ахлах ажилтнууд нь МТ-ийн засаглалын амжилттай хэрэгжүүлэхэд заавал оролцох шаардлагатай. Бусад ахлах менежерүүд холбогдох ажлын хэсэг, үнэлгээний үйл явц, гүйцэтгэлийн шалгалтанд оролцох ёстой.

4. Сонголт хийх

МХХТ-ийн засаглал нь зорилго бүртэй нийцэх боломжгүй юм. Гэхдээ засаглалын хүрээнд анхаарлын төвд байгаа зөрчилүүдийг шийдвэрлэх зорилгуудын тодорхойлж чадна. Асуудлыг тэнцвэрүүлэх тутам засаглал илүү цогц болдог.

78 Adapted from Weill and Ross, IT Governance, 222-230.

5. Онцгой байдлыг зохицуулах үйл ажиллагааг тодорхойлох

Онцгой нөхцөл байдал нь хэрхэн байгууллага сурч байгааг хэлдэг. МТ-ийннэр томъёололд, онцгой нөхцөл байдал нь одоогийн нөхцөл байдлыг сорилтонд оруулдаг, ялангуяа Байгууллагын архитектурыг. Онцгой нөхцөл байдлуудын зарим хүсэлтүүд нь хийсвэр, гэхдээ ихэнх нь бизнесийн хэрэгцээ шаардлагатай нийцэхээр үнэн байдаг. Хэрвээ онцгой нөхцөл байдал бизнесийн нэгжээр санал болгосон бол Байгууллагын Архитектурын өөрчлөлт нь бүх л байгууллагаас үр ашиг хүртэж чадна.

6. Урамшууллын зөв хэлбэрийг сонгох

МХХТ-ийн засаглалын нийтлэг асуудал нь урамшуулах зорилгоор хөгжсөн МХХТ-ийн засаглалын зохион байгуулалттай дэмжлэг болон шагналын системтэй тохирдоггүй. Засаглал болон урамшууллын асуудал нь бизнесийн нэгжийн хамтын ажиллагааны асуудал юм. . Хэрвээ МТ-ийн засаглалыг бизнесийн хамтын ажиллагаа, бие даах, эсхүл энэ хоёрыг хослуулах байдлаар зохион байгуулж байгаа бол энэ бүх урамшууллын хэлбэрүүд нь цугтаа эсхүл өөр хоорондоо уялдсан байх шаардлагатай.

Санхүүгийн хоригоос зайлсхийх нь санхүүгийн дэмжлэгийг үзүүлэхтэй нэгэн адил чухал байж болох талтай.

7. МХХТ-ийн засаглалд дахь эзэмших эрх болон хариуцлага бий болгох

МХХТ-ийн засаглал нь эзэмшигч болон хариуцлагатай байх ёстой. Засгийн газрын удирдлага бүх засаглалыг удирдаж байна, гэхдээ Засгийн газрын удирдлагууд хувь хүн (МХХТ-ийн яамны сайд) эсвэл бүлгийг (МХХТ-ийн яам, эсвэл МХХТ-ийн уялдуулан зохицуулах зөвлөл) МХХТ-ийн засаглалын зохиомж, хэрэгжүүлэлт, гүйцэтгэлд төлөөлөгчөөрөө сонгох магадлалтай байна.

Гурван чухал асуудал бий. Үүнд:

- МХХТ-ийн засаглал Засгийн газрын бусад гол хөрөнгүүдээс тусдаа зохиомжлогдож чадахгүй. (санхүүгийн, хүний гэх мэт)
- Хүн эсвэл бүлэг МХХТ-ийн засаглалыг дангаараа хэрэгжүүлж чадахгүй. Засгийн газрын удирдлага бүх сайдууд МХХТ-ийн засаглалд хувь нэмэр оруулах нь тэд санхүүгийн засаглал эсвэл ямар нэгэн бусад гол хөрөнгөд нэмэр оруулж байгаатай адилаар үүнийг тодорхой болгох хэрэгтэй.
- МХХТ-ийн хөрөнгүүд нь Засгийн газрын ихэнх гүйцэтгэлд илүү ач холбогдолтой чухал зүйл юм.

8. Зохион байгуулалтын төрөл бүрийн түвшинд засаглалын дизайн зохиох

Засгийн газрыг өргөн хамарсан стратегиудын хүрээнд засгийн газрыг бүхэлд нь МХХТ-ийн засаглалд ажиллуулна. Яамдууд тус тусдаа боловч МХХТ-ийн засаглалын үе шат бүрийг хангасан байх шаардлага гарна.

Засаглалын доод түвшнүүд нь дээд түвшнүүдэд зориулан бий болсон засаглалын арга хэрэгслээр дамжин тухайн засаглалд шилжинэ. Засаглалын бусад түвшинд нөлөөлж байгаа учир МХХТ-ийн засаглалаар Засгийн газрыг бүхэлд нь хангах ажлыг эхлүүлэх хэрэгтэй.

9. Ил тод байдал болон боловсрол

МХХТ-ийн засаглалын талаар хийсвэрээр авч үзэхэд их хэмжээний ил тод байдал эсвэл боловсролтой байх боломжгүй юм. Ил тод байдал болон боловсрол нь голдуу хамтдаа байдаг – илүү боловсрол байвал, илүү ил тод байна гэсэн адил тодотголтой. Засаглалын ил тод байдал хэдий чинээ илүү байна, засаглалд илүү их итгэл байна гэсэн үг юм.

10. Үндсэн зургаан нөөц хөрөнгөнд нийцэх нийтлэг механизмыг хэрэгжүүлэх (тухайлбал: хүний нөөц хөрөнгө, санхүүгийн нөөц хөрөнгө, физик хөрөнгө, оюуны өмч, мэдээлэл болон мэдээллийн технологи, харилцан хамаарал)

МХХТ-ийн засаглалыг зохиомжлоход, бусад гол хөрөнгүүдийг зохицуулахад хэрэглэгдэх арга механизмыг дахин нягталж үзэх, МХХТ-т шинэ, бие даасан МХХТ-ийн арга хэрэгсэл үүсгэхээс илүүтэйгээр тэдний гэрээг өргөтгөх арга хэмжээг авч үзэх. 6-н гол хөрөнгийн нэгээс илүүг нь зохицуулахын тулд ижил арга хэрэгсэл ашиглаж байгаа байгууллагууд илүү сайн засаглалтай байна гэсэн үг.



Өөрийгөө шалгах нь:

1. МХХТ-ийн засаглал гэж юу вэ? Яагаад энэ чухал вэ?
2. МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийн элементүүд нь юу вэ?
3. Австралийн МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчмуудыг жагсааж бич.

Нэмэлт материалууд

Австралийн Засгийн газрын мэдээллийн менежментийн газар. МХХТ-ийн засаглалын хороо. Австралийн хамтын нөхөрлөл.
<http://www.finance.gov.au/e-government/strategy-and-governance/ict-governance-committees.html>.

Худалдааны яам. Засгийн газрын ахлах мэдээлийн газар. МХХТ-ийн Засаглал. New South Wales Засгийн газар (Австрали).
<http://www.gcio.nsw.gov.au/ict-key-strategies/ict-governance/ict-governance>.

Ross, Jeanne W, Peter Weill, David Robertson. 2006. Стратеги шиг Байгууллагын Архитектур: Бизнесийн гүйцэтгэлд зориулсан сан байгуулах. Бостон. Harvard Бизнесийн сургуулийн хэвлэл.

Shatten, Allen. 2007. МХХТ-ийн засаглалд Хот төлөвлөлтийн зам. Мэдээллийн эрин үе (8-н сарын 17).
<http://www.infoage.idg.com.au/index.php/id;1125477169;fp;4;fpid;119792017>.

Weill, Peter, Jeanne W. Ross. 2004. МТ-ийн засаглал: Хэрхэн шилдэг гүйцэтгэгчид МТ-ийн шийдвэр гаргах эрхээ гайхамшигтай үр дүнд удирддаг вэ. Бостон. Harvard Бизнесийн сургуулийн хэвлэл.

Ziolkowski, Richard, Eugene Clark. 2005. МХХТ-ийн засаглалд зориулсан Стандартууд. Элсрүү шилжихэд илүү хүчирхэг хүний танин мэдэхүйг судлах сангийн шаардлага. Төрийн захиргааны АНДБ-ийн сэтгүүл 26, дугаар 1 (6-н сар): 77-90.
<http://sunzi1.lib.hku.hk/hkjo/view/51/5000806.pdf>.

ДҮГНЭЛТ

Энэ модуль 3 хэсгээс бүрддэг. Эхний хэсэг нь ХМХХТ-ийн бодлогыг хөгжүүлэх үйл явцуудыг тодорхойлдог, хоёрдугаар хэсэг нь ХМХХТ-ийн үндэсний бодлогын гол элементүүд болон тэдний хэрэгжүүлэлтийн стратегиудыг авч үздэг бол гуравдугаар хэсэг нь МХХТ-ийн засаглалыг авч үздэг.

Эхний хэсэг ХМХХТ-ийн бодлого, стратегиудыг боловсруулах алхмуудыг тодорхойлж, бодлого боловсруулах үйл ажиллагаанд төрийн, зах зээлийн, иргэний үүргүүдийг гаргаж өгдөг. Энэ хэсэг мөн шинэ МХХТ-ийн хөгжилд хуулийн болон зохицуулалтын шаардлага, ялангуяа интернэт технологиуд, технологиудын нэгдэл зэргийг авч үздэг. Эхний хэсгийн зарим гол санаанууд нь:

- Бодлого боловсруулагчид хүсээгүй үр дагаврыг бууруулахын тулд ХМХХТ-ийн хөндлөнгөөс оролцох явдлын нөхцөл, боломжит үр дагаврыг үнэлэх хэрэгтэй.
- МХХТ-ийн бодлого боловсруулагчид ХМХХТ-ийн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд төр, зах зээл, иргэний нийгмийн оролцооны зөв зохистой тэнцвэрийг хангах хэрэгтэй.
- Бодлого боловсруулагчид техникийн өөрчлөлтийн хүлээх шаардлагагүй, учир нь хуучин зохицуулалт шинэ технологи түүний үр дүнг зохицуулах үед шинээр асуудлууд үүсдэг.
- Бодлого боловсруулагчид ямар одоогийн болон батлагдсан хууль шинэ технологийн тархац, шинэ бизнесийн хөгжлийг сааруулж байгаа үнэлэх шаардлагатай.

Хоёрдугаар хэсэг хөгжлийн төлөөх өргөн хүрээний МХХТ-ийн үндсэн гурван элемент болох чадавхи бүрдүүлэх, эдийн засгийн МХХТ-ийн салбарыг бий болгох, засаглалтай холбоотой асуудлуудыг онцлон авч үздэг. МХХТ-ийн чадавхи бүрдүүлэхэд 2 өргөн асуудал байдаг: бүх иргэд мэдээллийн эрин зуунд амжилтанд хүрэх үндсэн чадвартай байхыг хангах, МХХТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг хөгжүүлснээр улсын МХХТ-ийн салбар, эдийн засаг ерөнхийдөө тогтвортой байдлаар өснө. МХХТ-ийн аж үйлдвэрийн зах зээлийн байгуулахтай холбоотой бодлого, стратегиуд нь судлагдсан МХХТ-ийн үйлдвэрлэл, оффшори, глобал програм хангамжийн хөгжүүлэлт, тоон контентын зах зээлд ялгаатай Засгийн газруудаар хэрэгжүүлэгдсэн. Энэ хэсэг мөн үнэгүй болон нээлттэй эхийн програм хангамжийг хөгжүүлэх, хамтран ажиллах чадварыг бий болгохын тулд Засгийн газрын үүргийг авч үзнэ. Энэ хэсгийн зарим гол санаанууд нь:

- МХХТ-ийн чадавхийг хөгжүүлэх нь ХМХХТ-ийн хүчийг ашиглах гэж буй ямар нэгэн улсын хувьд бодлогын чухал зорилт юм.
- Зөвхөн технологи дээр төвлөрсөн болон зохистой сурган хүмүүжүүлэх ухаанаар үндэслэгдсэн боловсролын МХХТ-ийн хөтөлбөрүүд нь бүтэлгүйтэх магадлалтай.
- Өнөөдрийн глобал эдийн засагт, засгийн газар МХХТ-ийн салбар үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд голлох үүрэгтэй байх зохистой орчноор хангаж байгааг яаралтай, шийдвэртэйгээр авч үзэх хэрэгтэй.
- Холбогдсон засаглал Засгийн газрын агентлагуудын хоорондын хамтын ажиллагааг дэмждэг төдийгүй иргэдтэй идэвхитэй, үр дүнтэй харилцах, зөвлөлдөх, олон оролцогч талуудтай бүс нутгийн болон олон улсын хүрээнд хамаарах талд чиглэдэг.

Гуравдугаар хэсэг нь МХХТ-ийн засаглалыг авч үздэг бөгөөд МХХТ-ыг хэрэглэхэд шийдвэр гаргах эрх, үүрэг хариуцлагыг тусгай заах үндсэн бүтцийг тодорхойлдог. Үндсэн бүтэц нь зарчмуудын бүрдэл, шийдвэр гаргах шаталсан бүтэц, тайлагнах болон хянан шалгалтын үйл явцуудын тохиромжтой багцуудыг хамардаг. МХХТ-ийн хөрөнгө оруулалтуудад зэрэглэл тогтоох шаардлага байгаа. Энэ хэсгийн үндсэн санаанууд нь сайн МХХТ-ийн засаглал нь хамгийн дээд түвшинд үр дүнтэй манлайллын бүтээгдэхүүн юм.

ХАВСРАЛТ

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Чадавхи	Хүмүүс, байгууллага, нийгэм бүхэлдээ өөрсдийн асуудлаа амжилттайгаар удирдах чадвар.
Чадавхи хөгжүүлэх	Хүмүүс, байгууллагууд, нийгэм бүхэлдээ цаг хугацааны туршид чадавхийг ил болгох, хүчирхэгжүүлэх, үүсгэх, тохируулах, сахих үйл явцыг.
Иргэний нийгмийн байгууллагууд	Сайн дурын, ашгийн бус бүлэг эсвэл холбоо тусгай нийгмийн зорилтуудыг хангах эсвэл тусгай бүлэгт үйлчлэх; хамгийн өргөн дэлгэрсэн нь төрийн бус байгууллагууд.
Малайзын харилцаа холбоо, мултимедиагийн тухай хууль (СМА)	(1999 онд батлагдсан) Нэгдлийг тусгах, нийцүүлэх зорилгоор болосруулсан зохицуулалтын эрх зүйн баримт бичиг. Энэхүү хууль нь цахилгаан холбоо болон өргөн нэвтрүүлэгт технологи, үйлчилгээний төвч байр суурийг баримталсан тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг хуульчилж өгсөн. Тус улсын 31 төрлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 4-н үндсэн ангилалд оруулсан. Нэгдлийн тухай харах.
Холбогдсон засаглал	МХХТ-ыг хэрэглэх замаар Засгийн газрын агентлагуудын хоорондын хамтын ажиллагааг дэмждэг төдийгүй иргэдтэй ивэвхитэй, үр дүнтэй харилцах, зөвлөлдөх, олон оролцогч талуудтай бүс нутгийн болон олон улсын хүрээнд хамтран ажилладаг.
Нэгдэл	Хоёр эсвэл түүнээс илүү зүйлс хамтдаа байх тохиолдлыг хэлнэ. Энэ нь багаж хэрэгсэл(gadgets) үүсэх, агуулгын төрөл бий болох, цахимжалтаар хийгдэх боломжтой болж байгаа аж үйлдвэрлэлийн салбар мөн энд хамаарна.
Зохиогчийн эрх	Хуулийн зохицуулалт бөгөөд ихэнх Засгийн газрууд үүнийг өөрсдийн хуулиндаа баталсан байдаг. Эх ажил, бүтээл боловсруулагчдад онцгой эрх олгохыг хэлэх г бөгөөд энэ нь ихэвчлэн хязгаарлагдмал хугацаанд байдаг.
Тоон контентын зах зээл	Тоон бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдний үндсэн суурь нь болж байгаа технологиудыг үүсгэх, зохиомжлох, удирдах, тараахыг авч үздэг. Тусгай салбаруудад визуал эффектүүд, болон хөдөлгөөнт дүрслэл, интерактив мултимедиа, компьютер болон онлайн тоглоомууд, боловсролын мултимедиа, цахим кино, ТВ үйлдвэрлэл, кино болон ТВ пост-үйлдвэрлэл зэрэг орно.
Цахим эдийн засаг	Эд зүйлсийг үйлдвэрлэх гэдгээс санааг үйлдвэрлэх шилжилтээр тодорхойлогддог; мөн “мэдлэгийн эдийн засаг”, “сүлжээжсэн эдийн засаг”, “шинэ эдийн засаг” гэж тодорхойлогддог.
Тоон гарын үсэг	Функцийн хувьд гараар бичигдсэн гарын үсэгтэй адил юм. Тоон гарын үсэг нь ассиметрик криптографын төрөл бөгөөд, ихэнх улсуудын хуулинд гэрээнд гарын үсэг зурахад хүлээн зөвшөөрөгдсөн болгож заагдаагүй байна.
Цахим засаглал	МХХТ-г нийгмийн “чухал ач холбогдолтой удирдах функцээр” ашиглах гэдгээр тодорхойлогддог. Түүн дотроо уялдаа холбоо, арбитр, сүлжээ, зохицуулалт зэргийг агуулна. Илүү нарийвчилсан тодорхойлолт нь: цахим засаглал гэдэг нь захиргааны үйл ажиллагааны салбарт (төрийн үйлчилгээг хүргэх, зохицуулалт, хууль сахиулах, аюулгүй байдал, хүнд суртлыг арилгах, бодлого боловсруулалтыг сайжруулах), улс төрийн үйл ажиллагааны салбарт (хэрхэн нийгэм шийдвэр гаргаж байгаатай хамааралтай төрөл бүрийн ажиллагаа болон гишүүдийг нэгтгэж байгаа үнэ цэнийг байгуулах) орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, дэлхий нийтийн түвшинд хэрэглэхийг хэлнэ.

Цахим засаг	Төрийн салбарын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор МХХТ-ийг хэрэглэх.
Глобал програм хангамжийн хөгжил	Бодит цаг хугацааны буюу синхрон болон асинхрон харилцан үйлдлийг хамааран газар зүйн ялгаатай байрлал дахь улс үндэстний хил хязгаарын хүрээнд ажиллах програм хангамжийн ажлыг хэлнэ.
Засгийн газрын хамтран ажиллах чадвар	Өөрийн байгууллагууд, иргэд, хамтрагчид бие биетэйгээ хэрхэн харилцан үйлчлэлцэх тэр л замыг тодорхой заах стандарт болон зөвлөмжүүдийн багцыг Засгийн газар хэрэглэдэг. Энэ нь дээд түвшний бодлогын илэрхийлэл, техникийн агуулга, үйл явцын баримтжуулалт, хэрэгжүүлэлт, нийцлийн дэглэмүүд юм.
МХХТ-ийн засаглал	МХХТ-ыг хэрэглэхэд тустай зан байдлыг урамшуулах шийдвэр гаргах эрх болон үүрэг хариуцлагын үндсэн бүтцийг тусгайлан тодорхойлохыг хэлнэ. Энэ нь байгууллагын хувьд хэн хамгийн сүүлийн шийдвэрийг гаргаж байна гэдгээр тодорхойлогддог.
МХХТ-ийн засаглалын үндсэн бүтэц	Засгийн газрууд МХХТ-ийн засаглалын үндсэн бүтцийг хөгжүүлэхийн тулд хөгжлийн зорилгуудын дагууд МХХТ-ийн хэрэглээг хамгийн их байлгах аар ажиллаж байна. Энэ үндсэн бүтэц нь ерөнхийдөө дараахаас бүрдэнэ. 1) Зарчмуудын бүрдэл, 2) Шийдвэр гаргах шатлан захирах ёс 3) Тайлагнах болон ажиглах үйл явцуудын захиалгаар хийсэн цуглуулга.
МХХТ-ийн хөрөнгө оруулалтын зарчмууд	МХХТ-ийг хэрэглэхтэй холбоотой дээд түвшний мэдэгдлүүдийн хамааралтай бүрдэл. Энэ бол МХХТ-ийн зарлагын зэрэглэлийг тогтоох өөр нэг арга юм.
Хамтран ажиллах чадвар	Хоёр эсвэл түүнээс дээш систем эсвэл бүрэлдэхүүн хэсгүүд мэдээлэл солилцох чадвар болон солилцсон мэдээллийг ашиглах чадварыг хэлнэ.
Либералчлал	Засгийн газрын бодлого боловсруулах үйл явц нь эдийн засгийн хөгжил, үйл ажиллагаанд аливаа саад тотгор учруулахгүй байх арга зам юм. Олон улсын худалдаанд үнэ тарифыг бууруулах, үнэ тариф мөрдөхгүйгээр үүсдэг саадыг арилгах гэсэн утгатай. Цахилгаан холбооны салбарт цахилгааны холбооны үйлчилгээгээр хангахад монополчлолыг устгахтай холбоотой.
Зах зээлд суурилсан шинэчлэлүүд	Ерөнхийдөө бодлогууд зах зээлийн хүчийн үнэ, тоо хэмжээ, чанарыг тогтоох боломжийг өгдөг, зарим тохиолдолд олгогдож байгаа үйлчилгээг тодорхойлох гэж үздэг. Засгийн газрууд голдуу шинэчлэлийг гурван аргаар эхэлдэг: хувьчлал, либералчлал, эсвэл хоёулангийнх нь хослуулан.
Үндэсний үйлдвэрлэлийн архитектур	Засгийн газрын МХХТ-ийн төслүүдийн хоорондын харилцан хамаарал болон өөрчлөлтийн удирдлагыг тайлбарлах үндсэн бүтэц эсвэл шүхэр.
Үндэсний мэдээллийн дэд бүтэц	Тухайн улсын хэрэгцээний дагуу дуун, өгөгдөл, текст, зураг, видео мэдээллийг интерактив горимоор дамжуулах чадамжтай өргөн зурвасын сүлжээг хэлнэ.
Төрийн бус байгууллага	Иргэний нийгмийн байгууллагуудыг харах.
Оффшоринг	Ажлын функцүүд гадаад улсуудад зардал багатай газар луу шилжих.
Нээлттэй эх	Эх код нь нээлттэй, өргөтгөж болох, үнэгүй тараах боломжтой програм хангамж юм. Энэ нь мөн өргөн утгаараа “ялгаатай арга барил, урьтамж, хэлэлцэх асуудлаас нэгэн зэрэг оролт хийх боломжийг олгодог бөгөөд хөгжлийн хаалттай, төвлөрсөн загвараас ялгарах үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтын загвар” гэж тодорхойлогддог.

Аутсорсинг	Дотоодын компаниар бус гадаадын компанийг хөлсөлж ажил гүйцэтгүүлэх. Эдгээр нь ерөнхийдөө логик, нөөцлөлт, хувиарьлалтын үйлчилгээ; мэдээллийн технологийн үйлчилгээ түүн дотроо програм хангамж бүтээх болон компьютерийн төвүүдийн удирдлага; бизнес үйл явцын аутсорсингийн салбар, жишээлбэл: дуудлагын төвүүд, санхүүгийн гүйлгээний боловсруулалт, болон хүний нөөцийн удирдлага.
Бодлого	Улс төрийн жүжигчин эсвэл бүлэг улс төрийн жүжигчдийн зорилгуудыг сонгох, эдгээр улс төрийн жүжигчдийн эрх мэдлийн хүрээнд, зарчмын дагуу тусгай нөхцөл байдалд эдгээр зорилгуудад хүрэхтэй холбоотойгоор хийсэн хоорондоо холбоотой шийдвэрүүдийн иж бүрдлийг хэлнэ.
Хувьчлал	Засгийн газрын эзэмшдэг эсвэл хянадаг үйлдвэрүүдийг хувьд шилжүүлэх үйл явцад чиглэдэг.
Төрийн бодлого	Нийгмийн хангамж эсвэл сайн сайхантай холбоотой асуудлуудыг зохицуулах хариу үйл ажиллагаа юм. Энэ нь тухайн улсын хууль, зохицуулалтууд, шийдвэрүүд болон Засгийн газрын үйл ажиллагаанд хэсэгчлэн заагдсан байдаг.
Газар тариалангийн системийн хурдацтай үнэлгээ	Системтэй, оролцохуйц боломжтой загвараар оролцогчид, тэдгээрийн сүлжээг үнэлэх зорилгоор хөгжүүлэгдсэн жүжигчинд чиглэсэн арга.
Зохицуулалт	Хуулийг дагаж мөрдүүлэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн гаргасан журам эсвэл даалгавар. Энэ нь хуулиар баталгаажсан байх ба хуулийг баталгаажуулах гэхээсээ илүүтэйгээр тодорхой сэдэв дээр илүү нарийвчилсан загварыг өгдөг.
Үйлчилгээний төвч байр суурийг баримталсан тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд аль үйлчилгээ илүү хэрэгцээтэй байна эсвэл үр дүнтэй байна гэдгийг мэдэх дохио авах боломжийг олгодог.
Оролцогч талууд	Боловсруулагдаж байгаа бодлогод өөрийн ашиг сонирхолтой хувь хүмүүс, бүлэг хүмүүс, байгууллагууд байдаг. Тэд ялгаатай сонирхолтой байдаг.
Оролцогч талуудын дүн шинжилгээ	Тэдний хамаарал, дотоод харилцан хамаарал, өгөгдсөн асуудал эсвэл нөөцүүдэд хамаатай сонирхол зэрэг дээр үндэслэн оролцогч талуудыг адилтган таних, тодорхойлох төрөл бүрийн хэрэгслүүдийг ашиглахыг хэлнэ.
Технологийн төвч байр суурийг баримталсан зохицуулалт эсвэл хууль	Хууль болон Засгийн газрын саадууд нь тусгай технологид дэмжлэг үзүүлэх ёсгүй. Энэ нь тухайн технологид зах зээл давуу байдал өгөхөөс сэргийлэх төдийгүй технологийн тусгай акт эсвэл даалгавар технологийн шинэчлэл байгаа газарт хэрэггүй болох магадлалтай технологийн хуучралаас сэргийлэх
Вашингтоны тохиролцоо	Дэлхийн банк болон Олон улсын мөнгөний бодлогыг зохион байгуулсны дараа нь нэрлэгдсэн хөгжлийн стратеги нь Засгийн газрын доод чанарын, төрийн зохицуулалтыг халах, хурдацтай ардчилал болон хувьчлал гэж цохон тэмдэглэсэн байдаг.
Дараа үеийн Вашингтоны тохиролцоо	Вашингтоны тохиролцооны залгамжлагч нь үр дүнтэй байдлын чухалыг онцолдог, гэхдээ иргэний нийгмийн оролцоог авч үздэг.
21-р зууны ур чадварууд	Мэдээллийн эрин зуунд хөгжүүлэгдэх ур чадварууд. Эдгээр нь бүтээлч байдал, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийн бичиг үсэг, холбооны чадвар, бусад дээд зэрэглэлийн сэтгэх чадварууд үүнд багтана.

СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

“Цуврал модулиудын талаар” гарчигтай хэсэгт тэмдэгсэнчлэн, цувралуудын энэ модуль болон бусад нь янз бүрийн үзэгчдэд, ялгаатай, өөрчлөгдөн буй үндэсний нөхцөл байдлуудад зориулан бүтээгдсэн. Модулиуд нь зарим талаараа, бүхэлдээ, ялгаатай горимуудаар (онлайн, онлайн бус) үзүүлэгдэх байдлаар зохиомжлогдсон. Модуль нь сургалтын байгууллагууд мөн түүнчлэн Засгийн газрын байгууллагуудад хувь хүмүүс эсвэл бүлэг хүмүүст ашиглагдаж болно. Оролцогчдын мэдээлэл болон сургалтын үргэлжлэх хугацаа агуулгын илүү нарийвчилсан зүйлсүүдийг тодорхойлно.

Эдгээр “тэмдэглэгээнүүд” нь сургагчдад модулийн агуулгыг үр дүнтэйгээр үзүүлэх зарим санаа, саналуудыг өгдөг. Сургалтын арга барил, стратегиудын цаашдын зөвлөмжүүд нь Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэг олгох Академи цуврал модулиудын дагалдах материал хэлбэрээр боловсруулагдсан заах загвараар бүтээгдсэн гарын авлагаар дамжиж очно. Гарын авлага нь <http://www.unapcict.org/academy> гэсэн хаяг дээр байгаа.

Модулийг хэрэглэх нь

Модулийн хэсэг бүр сургалтын зорилгын талаархи мэдээллээр эхэлж, “Өөрийгөө шалгах нь.” гэсэн асуултуудаар төгсөнө. Уншигчид зорилтууд болон асуултуудаар модулийн өөрсдийн үйл явцыг үнэлэхэд ашиглаж болно. Хэсэг бүр мөн сургагчдад хэрэглэгдэж эсвэл уншигчдын гүйцэтгэх ёстой хэлэлцүүлгийн асуултууд, практик дасгалуудыг агуулдаг. Эдгээр асуултууд болон дасгалууд нь уншигчдыг өөрсдийн туршлага дээр агуулгыг хэмжих, үзүүлж буй асуудлуудыг тусган бодох боломжийг олгох зорилгоор боловсруулагдсан.

Жишээн дээр суралцах нь модулийн агуулгын чухал хэсэг юм. Эдгээр нь хэлэлцүүлэг, дүн шинжилгээний зорилготой бөгөөд ялангуяа ямар гол баримтлал болон зарчмууд нь модулийн ажил, жинхэнэ төсөл, хөтөлбөрүүдэд тусгагдсан байна гэдгийг мэдэхэд юм. Энэ нь уншигчдад дотоодын нөхцөлд тохирох МХХТ-д суурилсан, МХХТ дэмжсэн хандлагуудыг тохируулах шаардлагыг ойлгоход чухал юм. Сургагчид оролцогчдыг бусад жишээнүүдээс иш татах, модулийн агуулгыг баяжуулахын тулд тэдний өөрсдийн жишээнүүдээс татах боломжийг олгож болно.

Сургалтын хугацааг бүтэцчилэх

Үзэгчдээс шалтгаалан, боломжтой цаг, дотоодын нөхцөл, модулийн агуулга ялгаатай хугацаанд заагдаж болно. Ялгаатай үргэлжлэх цугларалтанд юуг хамарч үзэх нь доор тайлбарлагдсан. Сургагчид өөрийн орон болон үзэгчид дээр үндэслэн цугларалтын бүтцийг засахаар уригдсан.

90 минутын сургалтын хугацаа

Модулийн ерөнхий танилцуулгыг өгөх. Та өөрийн семинарын агуулгыг боловсруулахын тулд хэсэг бүрийн “Дүгнэлт” болон танилцуулгын хэсгийг авч үзэх, оролцогчдод илүү хамааралтай асуудлуудыг онцолж авах. Мөн дэд хэсгийн асуудал дээр төвлөрч болно, жишээлбэл; хэсэг 1-т үзүүлсэн МХХТ-ийн загварыг сонгож болно. Ерөнхийдөө оролцогчдын сонирголоос хамаарна.

3 цагийн сургалтын хугацаа

Энэ нь тодорхой хэсгүүд дээр илүү нарийн төвлөрөх зорилгоор бүтэцлэгдсэн 90 минутын цугларалт юм. Оролцогчдын мэдээллээс хамаараад, та модулийн ерөнхий танилцуулгыг гүйлгэх, тэгээд хэсгүүдийг нэг эсвэл хоёроос нь тодорхой дэд хэсгүүд дээр төвлөрөх,

ялангуяа хэсэг 1-ийн олон оролцогч талуудын МХХТ-ийн бодлогын хөгжүүлэлт, хэсэг 2-ийн МХХТ-ийн чадавхи бүрдүүлэх, хэсэг 3-ийн МХХТ-ийн засаглалын үндсэн бүтэц дээр төвлөрч болно.

Гурван цагийн цугларалт нь мөн 90 минутын 2 хэсэгт хуваагдаж болно. Эхний хэсэг нь холбогдох хэсгийн дүгнэлт болон жишээн дээр суралцах, дараагийн хэсэг нь бүлгийн дасгал байж болно. “Хийх зүйлс” нэмэлт мэдээллийг бүлгийн дасгалажлыг гүйцэтгүүлэхэд ашиглана уу.

Бүтэн өдрийн сургалт (6 цаг)

Бүх гурван хэсгийг хамрахын тулд 2 цагаар 3-н хэсэг цугларалт болгон хуваа. Хэсэг бүрийн ерөнхий танилцуулгыг хийх, нэг эсвэл хоёр дэд хэсгүүдийн асуудлуудад төвлөр (Учир нь бүгдийг нь хамрах цаг байхгүй). 2 цагийн сургалтын хугацаа бүрт, хүргэлтийн арга нь янз янз байна. Эхний сургалтын хугацаанд та оролцогч бүрээс тэдний ХМХХТ-ийн бодлого боловсруулахад тулгардаг сорилтуудын талаар асуухыг хүсэж болно. Энэ нь хувь хүмүүс болон эсвэл сургагчдаар баримтжуулагдаж болно. Хоёрдугаар сургалтын хугацаанд та хэсэг 2-ын жишээн дээр суралцах загварыг бүх ангид эсвэл бүлгээр хэлэлцэж болно. Гуравдугаар сургалтын хугацаанд та бүлгийн дасгал өгч, хэрхэн МХХТ-ийн засаглал эхний хэсэгт оролцогчдод тулгарсан сорилтуудын заримыг арилгаж чадах вэ гэх мэт.

Өөр нэг арга нь нэг өдрийн сургалтын хугацаа нь модулийн зөвхөн нэг хэсэг дээр төвлөрч болно. Хэсэг гурвын 2 дэд хэсэг нь хос гурван цагийн сургалтын хугацаанд, хэсэг 1 болон 2-ын гурван дэд хэсгүүд 3 хоёр цагийн сургалтын хугацаанд хамарч болно. Бүлгийн хэлэлцүүлгийг батжуулж PowerPoint слайдуудын хооронд практикийн дасгалуудыг өгөх.

Гурван өдрийн сургалтын хугацаа

Хэсэг бүрт нэг өдөр зориул. Нэгдүгээр өдөрт хэсэг 1-ээр эхэлж, гуравдугаар өдөрт хэсэг 3-аар дуусгах. Өдөр бүрийн эхэнд ерөнхий танилцуулга хийж, төгсгөлд нь дүгнэлт хий. Сүүлийн өдөр, сүүлчийн 90-минут нь модулийн агуулгатай холбоотой туршлагуудыг хуваалцах, хэлэлцэх. Газар дээр зочлох нь хоёрдугаар өдөрт хэсэг 2 болон 3-ын хэлэлцүүлгийг нөхөх байдлаар зохион байгуулах.

Таван өдрийн сургалтын хугацаа

Энэ цагийн интервалд та модулыг бүхэлд нь хамрах ёстой. Модулийн дээд түвшний ерөнхий танилцуулгаар эхэлж, тэгээд хэсэг бүрт нь өргөтгө. Таван өдрийн туршид үзэгчдийн сонирхолыг татах үүднээс, хангалттай үзэгчидтэй хамтран ажиллах, агуулга үзүүлсний дараах завсарлагаанд практик дасгалуудыг хийвэл сэдвийг илүү сонирхолтой болгоно. “Хийх зүйлс” болон “Асуулт” хайрцгуудыг санаа гаргахад ашигла. Тусгай газарт зочлох нь хоёрдугаар эсвэл гуравдугаар өдрийн хуваарьт байвал зохино.

Сургалтын материалууд

Сургагчид APCICT-ын вэб сайтад байгаа слайдуудыг ашиглаж болно. (<http://www.unapcict.org/academy>).

Сургагчид цааш нь унших зүйлсийн жагсаалтыг хэрэглэх ёстой ба эх баримт бичиг, вэб сайтуудыг хайж олох. Сургагчид мөн бусад хамааралтай жишээн суралцах материалуудыг зохистой лавлагаатай нь хамт хэрэглэх ёстой.

ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Эмануэль С. Лалана нь бие даасан ашгийн бус байгууллага “IDEACORP”-ийн гүйцэтгэх захирал юм. Тэр маш олон ХМХТ-ийн сургалт, судалгааны төслүүдийг Филиппин болон АНДБ-д удирдаж байсан. 2004-2007 онуудад Доктор. Лалана Филиппин улсын Мэдээлэл,Холбооны комиссын (CICT) комиссараар ажилласан. CICT нь анхдагч МХХТ-ийн бодлого, төлөвлөлт, уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх, зохицуулах болон Филиппиний Засгийн газрын хэрэгжүүлэх салбаруудын нэгж нь юм.

UN-APCICT- НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ын Ази, Номхон далайн бүсийн төв

НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ын Ази, Номхон далайн бүсийн төв нь (UN-APCICT) НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооны (ESCAP) салбар юм. UN-APCICT-ийн зорилго нь хүний, институтын чадавхи бүрдүүлэх, улмаар нийгэм эдийн засгийн хөгжилд МХХТ-ыг ашиглах зорилгоор хорооны гишүүн улсуудын хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд оршдог ба дараах гурван гол багана дээр тулгуурладаг:

1. Сургалт. Бодлого боловсруулагч болон МХХТ-ын мэргэжилтнүүдийн МХХТ-ын мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх, МХХТ-ын сургагчид, институтуудын чадавхийг сайжруулах;
2. Судалгаа. МХХТ-ын хүний нөөцтэй холбоотой аналитик судалгааг явуулах;
3. Зөвлөгөө. Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооны гишүүн болон холбогдох гишүүдэд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт зөвлөгөө өгөх.

UN-APCICT нь БНСУ-ын Инчеон хотод байрладаг.

<http://www.unapcict.org>

ESCAP- АНДБ-ийн Эдийн засаг, Нийгмийн Хамтын Ажиллагааны байгууллага

ESCAP бол НҮБ-ын бүс нутгийн хөгжлийн төв бөгөөд Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төв нь болж явдаг. Зорилго нь 53 гишүүн, 9 холбогдох гишүүдийн хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. Тус байгууллага нь глобал, олон улсын түвшний хөтөлбөрүүд болон асуудлуудын хоорондын стратегийг холбох гүүр болон ажилладаг. Энэ нь бүс нутаг дахь засгийн газруудад глобалчлагдаж буй дэлхийд бүс нутгийн давтагдашгүй нийгэм-эдийн засгийн сорилтуудтай тулгарахад өөрийн байр сууриа хадгалж үлдэх, бүс нутгийн хандлагаар тусламж үзүүлдэхэд оршино. Төв нь Тайландын Бангкок хотод байрладаг.

<http://www.unescap.org>

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН МХХТ-ИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙН АКАДЕМИ

<http://www.unapcict.org/academy>

Сургалт нь 8 модультай бөгөөд хөгжлийн төлөөх МХХТ-ын өргөн хүрээний сургалтын хөтөлбөр болж, гол зорилго нь бодлого боловсруулагчдыг чухал шаардлагатай мэдлэг, ур чадвараар хангаснаар үндэсний хөгжлийн зорилгуудад хүрэх, тоон хуваагдлыг арилгахын тулд МХХТ-ын боломжуудыг хөшүүрэг болгон ашиглах явдал юм.

Модуль 1- МХХТ-ийн хэрэглээ болон бодит хөгжлийн харилцан хамаарал

МХЗ-уудыг хангахын тулд МХХТ-г хэрэглэхэд бодлогоос хэрэгжүүлэлт хүртэл гол асуудлууд болон шийдвэрийн санаануудыг онцлон тэмдэглэсэн.

Модуль 2- Хөгжлийн бодлого, үйл явц, засаглалд зориулсан МХХТ

Хөгжлийн төлөөх МХХТ-ын бодлого боловсруулах, засаглал дээр төвлөрөн хөгжлийг дэмжих үндэсний бодлого, стратегиуд, үндсэн бүтцүүдийн талаар чухал мэдээлэл олгоно.

Модуль 3- Цахим засгийн хэрэглээнүүд

Цахим засгийн ойлголтууд, зарчмууд, хэрэглээний төрлүүдийг тайлбарладаг. Энэ нь мөн хэрхэн засгийн газрын систем бий болсон болон зохиомжийн асуудлуудыг тодорхойлдог.

Модуль 4- Төрийн албан хаагчдад МХХТ-ийн хөгжлийн чиг хандлагуудыг танилцуулах нь

МХХТ-ын одоогийн чиг хандлага, ирээдүйн чиглэлд гүнзгий ойлголт өгөх. Энэ мөн МХХТ-ын шийдвэр гаргахад гол техникийн болон бодлогын асуудлыг авч үздэг.

Модуль 5- Интернэтийн засаглал

Интернэтийн хэрэглээ, үйл ажиллагааг зохицуулах олон улсын бодлогууд болон процессуудыг одоогийн үргэлжилж буй хөгжлийг авч үздэг.

Модуль 6- Сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

Мэдээллийн аюулгүй байдлын асуудлууд, чиг хандлагууд, мэдээллийн аюулгүй байдлын стратеги боловсруулах процессуудыг авч үзнэ.

Модуль 7- МХХТ-ийн төслийн удирдлагын онол болон практик

Хөгжлийн төлөөх МХХТ-той холбоотой төслийн удирдлагын үзэл баримтлалуудыг тайлбарлах, түүн дотроо аргууд, үйл явцууд, нийтлэг хэрэглэгддэг төслийн удирдлагын зарчмуудыг авч үзнэ.

Модуль 8- Хөгжлийн төлөөх МХХТ-ийн санхүүжилтийн хувилбарууд

Хөгжлийн төлөөх МХХТ-д болон цахим засгийн төслүүдэд зориулсан санхүүжилтийн сонголтуудыг эрж хайх. Төр-хувийн хэвшлийн түншлэл нь хөгжиж буй орнуудын хамгийн хэрэгтэй санхүүжилт гэж онцлон тэмдэглэгддэг.

Эдгээр модулиуд нь Академийн хамтрагчдийн кейс судалгааны дагуу өөр өөр улс орны бодлого боловсруулагчдын шаардлагатай нийцэх, түүнтэй хамааралтай байх зорилгоор шинэчлэн сайжруулагдсан. Модулиуд нь тухайн улс орны хэл дээр орчуулагдана. Цаашлаад, эдгээр модулиуд нь бодлого боловсруулагчидтай тэдний хамааралтай байдлыг хангах зорилгоор тогтмол шинэчлэгдэж, шинэ модулиудыг 21-р зуунд зориулсан МХХТ-иудыг үндэслэн боловсруулна.

Виртуал Академи (AVA – <http://ava.unapcict.org>)

- Академид зориулсан онлайн зайн сургалтын орчин
- Бүх Академийн модулууд түүн дотроо виртуал лекцүүд, слайдууд болон жишээнүүдэд онлайнаар хандах боломжтой
- Суралцагчдыг өөрсдийн байгаа газраасаа суралцах боломжийг нээж өгсөн

Цахим хамтын ажиллагааны төв (e-Co Hub – <http://www.unapcict.org/ecohub>)

- Хөгжлийн төлөөх МХХТ-ын мэдлэг хуваалцах, нөөц материалуудын портал
- Модулаар нөөцүүдэд хялбар хандах боломжийг олгодог
- Хэрэглэгчид онлайн хэлэлцүүлэгт оролцож, e-Co Hub-ийн онлайн бүлгийн гишүүн болж, хөгжлийн төлөөх МХХТ-ын мэдлэгээ нэмэгдүүлэх, хуваалцах боломжтой.

AVA болон e-Co Hub-дахь үйлчилгээг авах сонирхолтой байвал доорхи хаягаар бүртгүүлнэ үү.
http://www.unapcict.org/join_form